



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН ХОРОО



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP

# ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ 2018

ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН  
2018 ОНЫ СУДАЛГААНЫ ҮР ДҮН





МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН ХОРОО



**THE WORLD BANK**  
IBRD • IDA | WORLD BANK GROUP

# ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ 2018

ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН 2018 ОНЫ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

УЛААНБААТАР ХОТ  
2020

ННА-60.6  
ДАА-310  
Я-32

### СУДАЛГААНЫ ТАЙЛАН ХЯНАСАН

А.Ариунзаяа	ҮСХ-ны дарга
Ч.Баянчимэг	ҮСХ-ны дэд дарга
Икүко Уочи	ДБ-ны эдийн засагч
А.Амарбал	ҮСХ-ны ХАНСГ-ын дарга

### СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН

Икүко Уочи	ДБ-ны эдийн засагч
М.Оюунцэцэг	ҮСХ-ны ХАНСГ-ын ахлах статистикч
С.Болормаа	ҮСХ-ны ХАНСГ-ын ахлах статистикч
Д.Даваажаргал	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Н.Хэнбиш	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Л.Ундрал	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Б.Батням	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч

### МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

- 📍 Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу  
Засгийн газрын III байр
- ☎ 976-11-326414
- 🌐 [www.nso.mn](http://www.nso.mn)
- ✉ [international@nso.mn](mailto:international@nso.mn)

ISBN: 978-99978-758-5-3



## ӨМНӨХ ҮГ

Дэлхийн улс орнууд өөрт тулгарсан саад бэрхшээлийг даван түүлж, ирээдүйд гарч болох эрсдэлээс сэргийлэх, цаашид хөгжих бололцоог төгөлдөржүүлэхийн тулд хэнийг ч ардаа үл үлдээж, хамтдаа хүчин зүтгэх тогтвортой хөгжлийн 17 зорилго бүхий хөтөлбөрийг 2015 онд баталсан билээ. Тогтвортой хөгжлийн зорилгын нэгдүгээрт “Ядуурлыг устгах”, аравдугаарт “Тэгш бус байдлыг бууруулах” гэж тодорхойлсон.

Монгол Улсын төр засаг дэлхий нийтийн энэхүү уриалгад нэгдэн орж ядуурал, тэгш бус байдлыг бууруулахын төлөө түүштай ажиллаж байна.

ТХЗ-ын гол санаа нь “хэнийг ч ардаа үлдээхгүй” гэсэн утгатай. Тиймээс хүн бүрийг, ялангуяа хамгийн ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийг тооцох нь

чухал юм. Энэхүү зорилтыг үр бүтээлтэй хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулахад чухал хувь нэмэр болох ядуурлын талаарх бодитой тоо мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцох, хугацааны хувьд харьцуулагдах боломжтой болгох ажлыг Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд амжилттай хийсээр ирсэн.

Энэ удаагийн “Ядуурлын дүр төрх” тайланг боловсруулахдаа 2018 оны дэлгэрэнгүй ӨНЭЗС-нд хамрагдсан 16 мянга гаруй өрхийн мэдээлэлд үндэслэн ядуурлын тооцоог хийж, 2010-аас 2018 оны хооронд ядуурлын хамралтад гарч буй өөрчлөлт, нөлөөлж буй хүчин зүйлсийг харьцуулан шинжилсэн юм.

ҮСХ-ноос хүн амын хэрэглээний мэдээллийг цуглуулж амьжиргааны түвшин, ядуурлын үзүүлэлтийг тооцох боломжтой өрхөд суурилсан “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” (ӨНЭЗС)-г Дэлхийн банкны техникийн дэмжлэгтэй явуулдаг. Энэ судалгаа нь тус хорооноос урьд өмнө зохион байгуулж байсан түүвэр судалгаануудын (“Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшний үнэлгээ” 1995 он, “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа” 1998 он, “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа” 2002-2003 он) үргэлжлэл бөгөөд 1966 оноос эхлэн тасралтгүй явагдаж байгаа “Өрхийн орлого, зарлагын судалгаа”-тай бүрэн хэмжээгээр нэгтгэгдэж, жил бүр тогтмол явагдаж байна.

Хүн амын амьжиргааны байдал нь дан ганц ядуурлын үзүүлэлтүүдээр хэмжигдэхгүй өргөн цар хүрээтэй асуудал юм. Хүн амын аж байдлыг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлтэй уялдуулан судалж, нарийвчлан үнэлэх болон ядуурал, нийгэм, эдийн засгийн асуудлаар гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээний ажил хийхэд ӨНЭЗС-гаар цуглуулсан баялаг мэдээлэл нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, олон улсын байгууллага, эрдэмтэн, судлаачдад чухал мэдээллийн эх үүсвэр болно гэдэгт найдаж байна.

Судалгааг олон улсын аргачлалын дагуу явуулахад техникийн дэмжлэг үзүүлсэн, мэдээллийг шинжлэн боловсруулах, тайлан бичихэд хамтран ажилласан Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч ноён Андрей Михнев, эдийн засагч хатагтай Икүко Уочи болон ядуурлын судалгааны мэргэжилтнүүд, Монгол дахь Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газрын хамт олонд талархал илэрхийлье.

Судалгааны мэдээллийг өрхөөс цуглуулах амаргүй ажлыг хийж гүйцэтгэсэн төв, орон нутгийн судлаач, ахлагч, хянагч, жолооч, хөтөч, баг, хорооны Засаг дарга нарт болон олон улсын арга зүйн дагуу мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээг гүйцэтгэж, судалгааны үр дүнгийн тайланг боловсруулсан ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Өрхийн орлого, зарлагын судалгааны албаны ажилтнуудад гүн талархал илэрхийлье.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

А.АРИУНЗАЯА



## ӨМНӨХ ҮГ

Дэлхийн Банк Монгол Улсын Үндэсний статистикийн хороотой (ҮСХ) 2002 оноос эхлэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэлд үндэслэн хүн амын амьжиргаа, ядуурлын талаарх тоо мэдээлэлд шинжилгээ хийх чиглэлээр хамтран ажилласаар ирсэн бөгөөд та бүхэнд толилуулж буй энэхүү тайлан нь ядуурал, тэгш бус байдалд хийсэн хамгийн сүүлийн үеийн шинжилгээний бүтээл юм.

ӨНЭЭС-гаар цуглуулсан цагаа олсон, чанартай мэдээлэл нь өнөөг хүртэл бидний ядуурлыг бууруулахын төлөө хийсэн ажил, хүрсэн амжилтыг үнэлэхэд тус болохоос гадна судалгаа, шинжилгээний үр дүнгүүд нь хаана бодлогын зохицуулалт, дэмжлэг хэрэгтэй байгааг тодруулахад тустай байх болно.

Монгол Улс бүсдээ хамгийн залуу хүн амтай орнуудын нэг бөгөөд хүн ам зүйн бүтцэд орж буй энэ өөрчлөлтийн эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө ойрын жилүүдэд тохиох учиртай. Шинэ залуу ажиллах хүчийг хөдөлмөрийн зах зээлд шингээхэд хөрөнгө оруулалт их шаарддаг аж үйлдвэрийн салбараас гадна бүтээмж өндөртэй олон төрлийн салбарт зохистой ажлын байрыг олноор бий болгох шаардлага үүсч байна. Нөгөөтэйгүүр хүний нөөцөд хөрөнгө оруулах, ялангуяа хүүхэд, залуучуудад үр чадвар олгох, мөн хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний оролцоог дэмжих нь эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүн амд эрх тэгш, хүртээмжтэй байлгах ач холбогдолтой юм. Сүүлийн жилүүдэд малчдын амьжиргаа дорвитой сайжирсан хэдий ч малчид мал аж ахуйн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, цаг уурын хүндрэлд өртөмтгий эмзэг хэвээр байна. Улс орнуудын зорилтот бүлэгтээ чиглэсэн оновчтой, үр өгөөжтэй нийгмийн хамгааллын хөтөлбөр нь эдийн засгийн гэнэтийн хямралаас гарах сөрөг нөлөөг бууруулах боломжийг олгосоор байна.

Миний бие ҮСХ-ны дарга хатагтай А.Ариунзаяад энэхүү судалгааг удирдан зохион байгуулан явуулахад хичээл зүтгэл гарган ажилласанд гүн талархал илэрхийлэхийн дашрамд тус хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Өрхийн орлого, зарлагын судалгааны албаны ажилтнуудад Дэлхийн Банкны мэргэжилтнүүдтэй нягт хамтран ажилласанд талархсанаа илэрхийлье.

Дэлхийн Банк ядуурлын бүх хэлбэрийг арилгахын төлөө тууштай ажилласаар ирсэн бөгөөд энэхүү тайлангийн тоо мэдээлэл, дүн шинжилгээ Монгол Улсын Засгийн газрын бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, эрдэмтэн, судлаачдад Монголын ард түмний тогтвортой, эрх тэгш хөгжил цэцэглэлтийн төлөө баримт, мэдлэгт суурилсан ядуурлыг бууруулах бодлого боловсруулахад дэмжлэг болно гэдэгт найдаж байна.

ДЭЛХИЙН БАНКНЫ МОНГОЛ ДАХЬ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ

АНДРЕЙ МИХНЕВ

## АГУУЛГА

<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>3</b>
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	<b>6</b>
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	<b>8</b>
<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b>	<b>11</b>
<b>ХУРААНГУЙ</b>	<b>12</b>
<b>БҮЛЭГ 1. ЯДУУРАЛ БА ТЭГШ БУС БАЙДАЛ</b>	<b>17</b>
1.1. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд	18
1.2. Ядуурлын шугам, ядуурлын хамралтын хүрээний харьцааны мэдрэмж	18
1.3. Ядуурлын газар зүйн тархалт	20
1.4. Ядуурлын чиг хандлага	22
1.5. Ядуурлын бууралт, эдийн засгийн өсөлт	25
1.6. Баялгийн хуваарилалт, тэгш бус байдал	26
<b>БҮЛЭГ 2. ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ</b>	<b>30</b>
2.1. Ядуурал, хэрэглээний хэв шинж	31
2.2. Өрхийн хүн ам зүйн шинж чанарууд	34
2.3. Боловсрол	37
2.4. Хөдөлмөр эрхлэлт	39
2.5. Малчин өрх, мал аж ахуй	45
2.6. Өрхийн удаан эдэлгээтэй бараа, санхүүгийн хөрөнгө	48
2.7. Орон сууц, суурь үйлчилгээний хүртээмж	52
<b>БҮЛЭГ 3. ОРЛОГО, ТҮҮНИЙ ЯДУУРЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ</b>	<b>56</b>
3.1 Өрхийн орлогын бүрэлдэхүүн хэсэг, түүний хандлага	57
3.2 Ядуурлын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс	62
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b>	<b>66</b>
<b>ХАВСРАЛТ А. ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>67</b>
A.1 ӨНЭЭС-ны талаарх товч танилцуулга	67
A.2 Судалгааны түүвэрлэлт	67
<b>ХАВСРАЛТ Б. ЯДУУРЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ</b>	<b>71</b>
B.1 Аж байдлын үзүүлэлтийн сонголт	71
B.2 Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоох	72
B.3 Үнийн тохируулга	76
B.4 Өрхийн бүтцийн тохируулга	77
B.5 Ядуурлын шугам	77
B.6 Ядуурлын хэмжүүрүүд	78
<b>ХАВСРАЛТ В. ДООД, ДЭЭД ЯДУУРЛЫН ТООЦООНУУД</b>	<b>79</b>
<b>ХАВСРАЛТ Г. СТАТИСТИК НЭМЭЛТ ҮР ДҮНГҮҮД</b>	<b>81</b>
<b>ХАВСРАЛТ Д. ЯДУУРЛЫН ТООЦООНУУДЫН СТАНДАРТ АЛДАА БА ИТГЭМЖЛЭЛТ ИНТЕРВАЛУУД</b>	<b>128</b>

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1.1	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дунджаар, хувиар, 2018	18
Зураг 1.2.1	Нэг хүнд ногдох хэрэглээний тархалт, 2018	19
Зураг 1.2.2	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуурлын шугамыг хувилснаар, 2018	19
Зураг 1.3.1	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, бүсээр, хувиар, 2018	20
Зураг 1.3.2	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, суурьшлаар, хувиар, 2018	21
Зураг 1.3.3	Ядуурлын хамралтын хүрээ, аймгаар, хувиар, 2018	22
Зураг 1.4.1	Ядуурлын байдал, 2010-2018	23
Зураг 1.4.2	Ядуурлын байдал, хот, хөдөөгөөр, 2010-2018	23
Зураг 1.4.3	Ядуу, ядууралд өртөхөд ойрхон хүн амын хамралтын хүрээ, хувиар, 2010-2018	24
Зураг 1.4.4	Ядуурлын байдал, бүсээр, 2010-2018	25
Зураг 1.5.1	Ядуурлын бууралтад мэдрэмжийн өсөлт нөлөөлөх нь, 2010-2018	26
Зураг 1.6.1	Нэг хүнд ногдох хэрэглээний өсөлт, хот, хөдөөгөөр, хувиар	27
Зураг 1.6.2	Ядуурлын шинжилгээ, суурьшлаар	28
Зураг 1.6.3	Хөрш зэргэлдээ хөгжиж буй орнуудын Жини коэффициент	29
Зураг 2.1.1	Нэг хүнд сард ногдох дундаж хэрэглээ ба хэрэглээний тархалт, тэнцүү 5-н бүлгээр, 2018	31
Зураг 2.1.2	Нэг хүнд сард ногдох дундаж хэрэглээ, хэрэглээний бүтэц, ядуу, ядуу бусаар, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, 2018	32
Зураг 2.1.3	Хүнсний хэрэглээний бүтэц, хувиар, 2018	32
Зураг 2.1.4	Хүнсний хэрэглээнд хувийн аж ахуйн хэрэглээний эзлэх хувь, хүнсний үнийн индексийн хандлага	33
Зураг 2.1.5	Хүнсний бус хэрэглээний бүтэц, 2018	34
Зураг 2.2.1	Өрхийн ам бүлийн дундаж тоо, 2018	35
Зураг 2.2.2	Хүн ам зүйн ачаалал, хувиар, 2018	35
Зураг 2.2.3	Ядуурлын хамралтын хүрээ, насны бүлэг, хүүхдийн тоогоор, хувиар, 2018	36
Зураг 2.2.4	Хүн ам зүйн ачаалал, 2010-2018, хүн амд хүүхдийн эзлэх хувь, 2018	36
Зураг 2.3.1	Боловсролын түвшин, Зүүн Азийн орнуудын их, дээд сургуульд хамрагдалтын хувь, 2018	37
Зураг 2.3.2	Сургуульд хамрагдагчдын бүтэц, насаар, хүйсээр, хувиар, 2018	38
Зураг 2.3.3	25, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин, хувиар, 2018	38
Зураг 2.3.4	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, бага сургуулийн төрлөөр, хувиар, 2018	39
Зураг 2.4.1	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, цалин хөлстэй ажиллагчдын тоо, хувиар, 2010-2018	41

Зураг 2.4.2	Цалин хөлстэй ажиллагчид, ажил мэргэжлийн төрлөөр, өрхийн түвшинд цалин хөлстэй ажиллагчдын хувиар, 2018	42
Зураг 2.4.3	Цалин хөлстэй ажиллагчдын өсөлт, 2016-2018, уул уурхайн салбарт ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь, 2010-2018, уул уурхайн салбарт ажиллагчдын ажил мэргэжил, 2018	43
Зураг 2.4.4	Хөдөлмөрийн насны хүн амын ядуурлын хамралтын хүрээ, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар, 2018	44
Зураг 2.4.5	Ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар	45
Зураг 2.5.1	Хөдөлмөр эрхлэлтийн байдал, өрхийн тэргүүлэгч нь малчин өрхийн ядуурлын хамралтын хүрээ, хувиар	46
Зураг 2.5.2	Малчин өрхүүдийн малын тоо, борлуулалт, хэрэглээ, 2018	47
Зураг 2.5.3	Ноолуурын үнэ, үйлдвэрлэлийн чиг хандлага	47
Зураг 2.6.1	Өрхийн удаан эдэлгээтэй хөрөнгө, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, хувиар, 2018	48
Зураг 2.6.2	Мэдээлэл, технологийн хүртээмж, хувиар, 2010, 2018	49
Зураг 2.6.3	Санхүүгийн орлоготой, хадгаламжтай өрхийн эзлэх хувь, 2018	49
Зураг 2.6.4	Хэрэглээ, орлогын харьцуулалт	50
Зураг 2.6.5	Зээлийн хүртээмж	51
Зураг 2.6.6	Зээлтэй өрхийн эзлэх хувь, зээлийн төрлөөр, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр	51
Зураг 2.7.1	Сууцны төрөл, хүн амд эзлэх хувиар, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, 2018	52
Зураг 2.7.2	Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж, хүн амд эзлэх хувиар, 2018	54
Зураг 2.7.3	Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж, аймгаар, хүн амын эзлэх хувь, 2018	54
Зураг 3.1.1	Өрхийн орлогын хуваарилалт, хувиар	58
Зураг 3.1.2	Өрхийн орлогын эх үүсвэр, хувиар	59
Зураг 3.1.3	Нэг хүнд ногдох сарын дундаж орлого, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, 2018	60
Зураг 3.1.4	Өрхийн дундаж орлого, дүнд эзлэх хувиар, 2018	61
Зураг 3.2.1	Ядуурлын өөрчлөлтийн бүтцийн шинжилгээ, орлогын бүрэлдэхүүн хэсгээр, пунктээр	63
Зураг 3.2.2	Ядуурлын өөрчлөлтийн бүтцийн шинжилгээ, орлогын бүрэлдэхүүн хэсгээр, улс дундаж, хот, хөдөөгөөр	65
Зураг Г.1.	Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд сард ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт	102
Зураг Г.2.	Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, хот, хөдөөгөөр, 2016, 2018 он	103
Зураг Г.3.	Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, суурьшлаар, 2016, 2018 он	104
Зураг Г.4.	Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, бүсээр, 2016, 2018 он	104
Зураг Г.5.	Сургуульд хамрагдалтын түвшин	111



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.6.1	Ядуурлын өөрчлөлтийг хэрэглээний өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь 2016, 2018 оны зөрүүгээр, пунктээр	27
Хүснэгт 1.6.2	Тэгш бус байдлын чиг хандлага, 2010-2018	29
Хүснэгт 2.4.1	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, хүн амын хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, суурьшлаар, хувиар, 2018	40
Хүснэгт 2.4.2	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, хүйсээр, насны бүлгээр, хувиар, 2018	41
Хүснэгт 2.4.3	Хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар, 2018	42
Хүснэгт 2.4.4	Ажиллах хүчний оролцоо, хүн амын хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, суурьшлаар, хувиар, 2018	44
Хүснэгт 2.7.1	Дэд бүтцийн суурь үйлчилгээний үзүүлэлтийн тодорхойлолт	53
Хүснэгт 3.1.1	Өрхийн орлогын бүрэлдэхүүн хэсэг	57
Хүснэгт 3.1.2	Нэг хүнд ногдох орлогын жилийн нийт өсөлтийн хувь (ЖНӨХ), хот, хөдөөгөөр, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр	62
Хүснэгт А.1	ӨНЭЗС-ны түүврийн хуваарилалт, 2018	69
Хүснэгт А.2	ӨНЭЗС-ны хамрагдалт, ТАШН-ээр, ярилцлага авсан сараар, 2018	70
Хүснэгт Б.1	Түүврийн анхан шатны нэгжийн Паашийн индекс, бүлгээр, ярилцлага авсан сараар, 2018	76
Хүснэгт Б.2	Нэг хүнд сард ногдох ядуурлын шугам, 2018	78
Хүснэгт В.1	Нэг хүнд сард ногдох ядуурлын шугам, 2016, 2018 он	79
Хүснэгт В.2	Доод ядуурлын тооцоонууд, 2016, 2018 он	79
Хүснэгт В.3	Дээд ядуурлын тооцоонууд, 2016, 2018 он	80
Хүснэгт Г.1.	Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2018	81
Хүснэгт Г.2.	Ядууралд өртөх эмзэг байдал	81
Хүснэгт Г.3.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр	82
Хүснэгт Г.4.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар	82
Хүснэгт Г.5.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, 2018 он	83
Хүснэгт Г.6.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2016, 2018 он	84
Хүснэгт Г.7.	Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ, 2016, 2018 он	85
Хүснэгт Г.8.	Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ, аймаг, нийслэлээр, 2018 он	85
Хүснэгт Г.9.	Ядуурлын өөрчлөлтийг хэрэглээний өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь, 2016, 2018 оны зөрүүгээр, пунктээр	86
Хүснэгт Г.10.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улирлаар	87
Хүснэгт Г.11.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн ам бүлийн тоогоор	87
Хүснэгт Г.12.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар	88
Хүснэгт Г.13.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр	88

Хүснэгт Г.14.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшингээр	89
Хүснэгт Г.15.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажиллах хүчний оролцооны байдлаар	89
Хүснэгт Г.16.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн салбараар	90
Хүснэгт Г.17.	Мал аж ахуй эрхлэлт	90
Хүснэгт Г.18.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, мал аж ахуй эрхлэлтийн байдлаар	91
Хүснэгт Г.19.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, газар эзэмшил, өмчлөлийн байдлаар	91
Хүснэгт Г.20.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламжийн байдлаар	92
Хүснэгт Г.21.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, зээлийн төрлөөр	92
Хүснэгт Г.22.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр	93
Хүснэгт Г.23.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр	93
Хүснэгт Г.24.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр, хот, хөдөөгөөр	94
Хүснэгт Г.25.	Шилжүүлэг, бэлэг, тусламж, төрлөөр	95
Хүснэгт Г.26.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын болон хувийн шилжүүлэг, бэлэг, тусламжаар	96
Хүснэгт Г.27.	Нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, төгрөгөөр, дүнд эзлэх хувиар	97
Хүснэгт Г.28.	Нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, ядуурлын байдлаар, хот, хөдөөгөөр	98
Хүснэгт Г.29.	Нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, ядуурлын байдлаар, суурьшлаар	99
Хүснэгт Г.30.	Нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, ядуурлын байдлаар, бүсээр	100
Хүснэгт Г.31.	Нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, төгрөгөөр, хүн амын хэрэглээний тэнцүү 10 бүлгээр	101
Хүснэгт Г.32.	Нийт хэрэглээнд эзлэх хувь, хүн амын хэрэглээний тэнцүү 10 бүлгээр	101
Хүснэгт Г.33.	Ядуурлын дүр төрх, өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар, хот, хөдөөгөөр, хувиар	105
Хүснэгт Г.34.	Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, хот, хөдөөгөөр, хувиар	106
Хүснэгт Г.35.	Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, суурьшлаар, хувиар	107
Хүснэгт Г.36.	Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, бүсээр, хувиар	108
Хүснэгт Г.37.	18, түүнээс дээш насны хүн амын боловсролын дээд түвшин, хувиар	109
Хүснэгт Г.38.	18, түүнээс дээш насны хүн амын боловсролын дээд түвшин, хувиар	109
Хүснэгт Г.39.	Бага, бүрэн бус дунд, бүрэн дунд боловсролын сургуульд хамрагдалтын түвшин, хувиар	110
Хүснэгт Г.40.	18, түүнээс дээш насны хүн амын боловсролын дээд түвшин, хувиар	112
Хүснэгт Г.41.	Хүн амын өвчлөл, гэмтэл, хот, хөдөөгөөр, ядуурлын байдлаар, хувиар	113
Хүснэгт Г.42.	Хүн амын өвчлөл, гэмтэл, хүйсээр, ядуурлын байдлаар, хувиар	114
Хүснэгт Г.43.	18, түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хувиар	115

Хүснэгт Г.44.	18, түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хот, хөдөөгөөр, ядуурлын байдлаар, хувиар	115
Хүснэгт Г.45.	18, түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хүйсээр, ядуурлын байдлаар, хувиар	115
Хүснэгт Г.46.	Хүн ам, ажиллах хүчний байдлаар, хувиар	116
Хүснэгт Г.47.	Ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин, ядуурлын байдлаар, хувиар	117
Хүснэгт Г.48.	Ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин, хүйсээр, хувиар	118
Хүснэгт Г.49.	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, мэргэжлээр, ядуурлын байдлаар, хувиар	119
Хүснэгт Г.50.	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, мэргэжлээр, ядуурлын байдлаар, хувиар	120
Хүснэгт Г.51.	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, мэргэжлээр, хүйсээр, хувиар	121
Хүснэгт Г.52.	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, мэргэжлээр, хүйсээр, хувиар	122
Хүснэгт Г.53.	Ядуурлын дүр төрх, хадгаламж, зээлийн байдлаар, хот, хөдөөгөөр, хувиар	123
Хүснэгт Г.54.	Сүүлийн 12 сард авсан зээлийн дундаж хэмжээ, төрлөөр, мянган төгрөгөөр	124
Хүснэгт Г.55.	Сүүлийн 12 сард төлсөн зээлийн зарцуулалт, зориулалтаар, хувиар	125
Хүснэгт Г.56.	Өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээтэй бараа, хувиар	126
Хүснэгт Г.57.1.	Нэг хүнд ногдох бодит орлогын өсөлт, хувиар	126
Хүснэгт Г.57.2.	Нэг хүнд ногдох орлогын өсөлт, хувиар	127
Хүснэгт Д.1.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хот, хөдөөгөөр	128
Хүснэгт Д.2.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар	128
Хүснэгт Д.3.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр	129
Хүснэгт Д.4.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, аймгаар	130
Хүснэгт Д.5.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улирлаар	131
Хүснэгт Д.6.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар	131
Хүснэгт Д.7.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр	132
Хүснэгт Д.8.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшингээр	133
Хүснэгт Д.9.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламжийн байдлаар	134
Хүснэгт Д.10.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, зээлийн байдлаар	135
Хүснэгт Д.11.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр	136
Хүснэгт Д.12.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сайжруулсан ундны усны эх үүсвэртэй эсэхээр	137
Хүснэгт Д.13.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эсэхээр	138
Хүснэгт Д.14.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, цахилгаан эрчим хүчний хангамжтай эсэхээр	139
Хүснэгт Д.15.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, цахилгаан эрчим хүчний хангамж, сайжруулсан ундны усны эх үүсвэр болон сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эсэхээр	140

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХС	Ажиллах хүчний судалгаа
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХҮ	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд
ЗАНД	Зүүн Ази Номхон Далай
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТАШН	Түүвэрлэлтийн анхан шатны нэгж
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХАНСГ	Хүн ам, нийгмийн статистикийн газар
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс

## ХУРААНГУЙ

Макро эдийн засаг 2016-аас 2018 оны хооронд тогтвортой өссөн хэдий ч ядуурлын бууралт зогсонги байдалтай байна.

**Хүн амын ядуурлын хамралтын хүрээ 2016 онд 29.6 хувь байсан бол 2018 онд 28.4 хувь болж бага зэрэг буурчээ.** “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны 2018 оны дүнгээс харахад нийт хүн амын 28.4 хувь буюу 904.9 мянган хүн ядуу амьдарч байгаа бөгөөд сарын хэрэглээ нь 166580 төгрөгөөс бага байна. Хүн амын өсөлт өндөр байсан учраас (жилийн дундаж өсөлт 2.0 хувь) ядуу хүний тоо 2016 онд 907.5 мянга байснаа 2018 онд 904.9 мянга болж 2.6 мянган хүнээр буурчээ. Тухайлбал, ядуурлын шугамыг 25 хувиар өсгөхөд нийт хүн амын 14.9 хувь буюу 474.8 мянган хүн ядуурлын шугам болон ядуурлын шугамыг 25 хувиар өсгөсөн үзүүлэлтийн хооронд амьдарч байгаа нь нийгэм, эдийн засгийн ямар нэгэн сөрөг цочролд өртөхөд л ядууралд орох эмзэг байдалтай байна.

**Эдийн засаг (ДНБ) тогтвортой өссөн шиг ядуурал буураагүй байна.** Манай улс макро эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг өрхийн ялангуяа ядуучуудын амьжиргааг дээшлүүлэхэд чиглүүлэх хүндхэн сорилттой тулгарч байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт 2016-аас 2018 онд 2010-аас 2014 оны эдийн засгийн өндөр өсөлтийн үетэй харьцуулахад ядуурал буурахад хоёр дахин бага нөлөө үзүүлсэн байна. 2010-аас 2014 оны хооронд нэг хүнд ногдох бодит ДНБ нэг хувиар өсөхөд ядуурал 0.9 нэгж хувиар буурч байсан бол 2016-аас 2018 онд 0.5 нэгж хувь буурчээ. Сүүлийн хоёр жилд манай улсын нэг хүнд ногдох ДНБ-ий жилийн дундаж өсөлт 4.4 хувь байсан энэ өсөлтийн гуравны нэг нь уул уурхайн салбараас хамааралтай боловч тус салбар нь нийт ажиллагчдын 6 орчим хувийг л ажлын байраар хангадаг. Уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засгийн өсөлтийг бүх ажиллагчид тэгш хүртэж чаддаггүй бөгөөд үр чадвар шаардахгүй бага цалинтай үйлчилгээний ажил эрхэлдэг олон тооны ажиллагчид өсөлтийн үр өгөөжийг хүртэж чадахгүй үлдсээр байна.

Хот, хөдөөд ядуурал жигд бус бууралттай байна. Хөдөөд ядуурал 4 пунктээр буурсан харин хотод өөрчлөлтгүй байжээ.

**Хотын ядуу хүн амын хэрэглээний өсөлт бага, харин хөдөөгийн ядуу хүн амын хэрэглээ эрчимтэй өссөн байна.** Хөдөөд, ялангуяа хөдөө нутагт хүн амын орлого, хэрэглээ бусад суурьшилтай харьцуулахад илүү эрчимтэй өссөн байна. Орлого, хэрэглээний энэ өсөлт 2016 онд 34.9 хувь байсан хөдөөгийн ядуурлын хамралтын хүрээг 2018 онд 30.8 хувь болж 4.1 пунктээр буурахад нөлөөлжээ. Эсрэгээрээ, хотын хүн амын хэрэглээний өсөлт бага байгаагаас ядуурлын бууралт зогсонги байдалд орж, 2016-аас 2018 оны хооронд ядуурлын хамралтын хүрээ өөрчлөлтгүй 27 хувьтай хэвээр байна. Хэрвээ эдийн засгийн өсөлт тэгш хуваарилагдаад, хэрэглээний тэгш бус байдал нэмэгдээгүй байсан бол хотод ядуурал 2 пунктээр буурахаар байжээ.

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлт, ялангуяа хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн нь хотын ядуу иргэдийн амьжиргаанд сөргөөр, харин мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хөдөөгийн малчдад эерэгээр нөлөөлжээ.** Ядуу өрхүүдийн хүнсний хэрэглээндээ зарцуулсан мөнгөн дүнгийн эзлэх хувь нийт хэрэглээнд нь өндөр хувийг эзэлдэг учраас хүнсний бүтээгдэхүүнээ худалдан авч хэрэглэдэг хотын ядуу хүн амд үнийн өсөлт хүнд туссан байна. Харин мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулж орлого олдог, өрхийн хүнсний хэрэглээнийхээ тал хувийг хувийн аж ахуйгаасаа хэрэглэдэг малчид, тэр дундаа ядуу малчдад хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт тийм ч их нөлөө үзүүлсэнгүй.

**Хотод ядуу хүн амын төвлөрөл нэмэгдсэн байна.** Ядуурлын хамралтын хүрээ хоттой харьцуулахад хөдөөд өндөр хэвээр байгаа ч хот, хөдөөгийн ядуурлын хамралтын хүрээний зөрүү

нь 2010 онд 15.8 пункт (хотод 33.2 хувь, хөдөөд 49.0 хувь) байснаа 2018 онд 3.6 пункт (хотод 27.2 хувь, хөдөөд 30.8 хувь) болж буурчээ. Нийт хүн амын 66 хувь нь хотод амьдардаг бол нийт ядуу хүн амын арван хүн тутмын зургаа (63.5 хувь) нь хотод, тэр дундаа арван хүн тутмын дөрөв нь Улаанбаатар хотод (41.8 хувь) амьдарч байна.

**Хот, хөдөөгийн хүн амын хэрэглээний өсөлт болон түүний хуваарилалтын эрс ялгаатай байдал нь тэгш бус байдлын үзүүлэлтэд нөлөөлжээ.** Хотын хүн амын хэрэглээний өсөлтийн тэгш бус хуваарилалт нь Жини коэффициентийг өсгөсөн ч хөдөө орон нутагт ядуурлыг бууруулахад чиглэсэн тэгш хүртээмжтэй бодлогын үр нөлөөгөөр үндэсний хэмжээний Жини коэффициент бараг өөрчлөлтгүй (32.7) хэвээр байна.

Хөдөө аж ахуйн салбараас олох орлого эрчимтэй өссөн, ядуу эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын хөтөлбөрийг өргөжүүлсэн нь хөдөөгийн хүн амын ядуурал буурахад их нөлөөлжээ. Харин хотын ядуу бүлгийн хүн амын цалинд өөрчлөлт ороогүйгээс ядуурлын хамралтад тодорхой бууралт гарсангүй.

**Хотын хүн амын хамгийн бага хэрэглээтэй 20 хувь 2016-аас 2018 онд хүндхэн нөхцөлд амьдарсан байна.** Хотын хамгийн бага хэрэглээтэй 20 хувийнхны бодит орлогын өсөлт 2016-аас 2018 оны хооронд буурсан нь (-1.0 хувь) гол амьжиргааны эх үүсвэр болох цалин хөлс болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого саарсантай холбоотой байна.

**Хөдөө аж ахуйн орлогын өсөлт, тэр дундаа малын гаралтай бүтээгдэхүүний үнэ өссөн нь хөдөөд ядуурал эрчимтэй буурахад нөлөөлөв.** Хөдөөгийн хүн амын бодит орлого дунджаар 2.6 хувиар (2016 онтой харьцуулахад) өссөн ба хөдөөгийн хамгийн бага хэрэглээтэй 20 хувийн хүн амын бодит орлогын өсөлт бусад бүлгийнхтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 3.8 хувь байна. Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ өндөр, ялангуяа хамгийн их ашиг хүртээдэг ноолуурын үнэ өндөр байсан нь малчдын орлого нэмэгдэхэд нөлөөлжээ. Хөдөө аж ахуйн орлогын өсөлт дангаараа хөдөөгийн хүн амын ядуурлын түвшинг 2016-аас 2018 оны хооронд 1.8 пунктээр бууруулсан байна.

**Гэхдээ мал аж ахуйгаас хамааралтай амьдардаг малчдын хувьд гэнэтийн байгалийн гамшиг, аюул, осол тохиолдоход эмзэг байдалд байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй юм.** Малчдад 2016-аас 2018 онд малын гаралтай бүтээгдэхүүний үнэ өссөн өгөөжтэй жилүүд байсан ч зуд, бусад байгалийн гамшиг, малын гаралтай бүтээгдэхүүний үнэ огцом буурах зэрэг хүндрэлүүд амьжиргаанд нь шууд нөлөөлөхүйц эмзэг байдгийг санах хэрэгтэй. Малчин өрхүүдэд эдгээр гэнэтийн хүндрэл тулгарахад ямар нэгэн санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүй бол тэдний хөдөлмөр эрхлэлт, орлого, хэрэглээ буурч амьжиргаа нь доройтох эрсдэлтэй байдаг. Түүнчлэн, малын гаралтай бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэхийн хэрээр бэлчээрийн доройтол хурдацтай өсөж малчдын мал аж ахуйн үйл ажиллагаа доголдоход хүрч болзошгүй юм.

**Мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого эрчимтэй өсөхийн зэрэгцээ нийгмийн хамгааллын шилжүүлгийн хөтөлбөрийг өргөжүүлсэн нь ядуурал буурахад нөлөөлсөн байна.** Ядуу хүн амд чиглэсэн Хүнсний дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хамрах хүрээг 2016-аас 2018 онд хоёр дахин, олгох мөнгөний хэмжээг 20 хувиар нэмэгдүүлсэн, мөн 3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эхчүүдэд мөнгөн тэтгэмж олгох хөтөлбөрийг шинээр бий болгосон гэх зэрэг нийгмийн хамгааллын шилжүүлгүүд нь хот, хөдөөгийн хүн амын ядуурлын бууралтад тодорхой хувь нэмэр оруулж, улсын хэмжээнд ядуурлын хамрах хүрээг 1.2 пунктээр бууруулсан. Энэ хугацаанд бусад зорилтот бүлэгт чиглэсэн болон нийтийг хамарсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдээс нийт хүн ам тэгш ашиг хүртсээр байв.

Ядуу ба ядуу бус хүн амын хооронд боловсрол, үр чадвар, хөрөнгө санхүүгийн ялгаа харагдаж байна.

Ажилгүй, эдийн засгийн идэвхгүй хүн ам, үр чадвар муутай ажилчид ядуу байх магадлал өндөр байна.

**Судалгааны 2018 оны дүнгээр ядууралд өртсөн таван ажилчин тутмын гурав нь цалинтай ажил эрхэлдэг боловч ажил нь ихэнхдээ мэргэжил, үр чадвар бага шаардагдах энгийн ажил, хөдөлмөрийн хөлс багатай худалдаа, үйлчилгээний ажлууд байдаг байна.** Сүүлийн арван жилд ядуу хүмүүс цалинтай ажил хийх нь нэмэгдсэн ч 30 гаруй хувь нь энгийн, үр чадвар шаардагдахгүй ажил эрхэлж, 40 хувь нь гар үрлал, худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж байна. Эсрэгээрээ, ядуу бус цалин хөлстэй ажилчдын арван хүн тутмын нэг нь үр чадвар бага шаардагдах ажил хийдэг, арван хүн тутмын дөрөв нь удирдлагын, мэргэжлийн, техникийн албанд ажиллаж байгаа нь ядуу болон ядуу бус хүн амын цалин зөрүүтэй байгаа шалтгаан болж байна.

**Хөдөлмөрийн насны хүн амын ажилгүй, эдийн засгийн идэвхгүй хүмүүс хамгийн ядуу амьдарч байна.** Хөдөлмөрийн зах зээл дээрх цалин хөлс сайтай ажлын байрны эрэлт хэрэгцээг мэргэжил, үр чадвар багатай ядуучууд хангаж чадахгүй байх нь элбэг учраас тэдэнд ажил олоход бэрхшээл байнга тулгардаг. Хөдөлмөрийн насны (15 ба түүнээс дээш нас) хүн амын дунд ажилгүй иргэдийн ядуурлын хамралтын хүрээ 40 хувь, эдийн засгийн идэвхгүй хүн амынх 34 хувь байгаа нь цалинтай ажилчид (21 хувь), хувиараа хөдөлмөр эрхлэгчид (17 хувь), тэтгэвэрт авагчид (14 хувь)-тай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

**Малчид 2010 онд хамгийн ядуу байсан бол өнөөдөр гурван малчин тутмын нэг нь ядуу амьдарч байна.** Улсын хэмжээнд 2010 онд малчид хамгийн ядуу байсан бөгөөд тухайн үед малчдын 58 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байв. Энэ үеэс малын гаралтай бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, үнэ өссөн, зах зээлийн нөхцөл сайжирч эхэлсэн зэрэг нь тэдний амьжиргааг дээшлүүлсэн. Үүн дээр Засгийн газрын татаас, нийгмийн хамгааллын шилжүүлгүүд эерэг нөлөө үзүүлсэн байна. Хөдөө орон нутагт цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх нь түгээмэл болж, малчин өрхүүд хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаагаа төрөлжүүлж эхэлсэн байна. Тодотговол, хөдөөгийн хүн амын 40 гаруй хувь нь хөдөө аж ахуйн үйл ажиллагаандаа өдрийн бүх цагаа зарцуулдаг, 18 хувь нь хөдөө аж ахуйн үйл ажиллагаа болон цалин хөлстэй ажлуудыг хослуулан ажиллаж байна.

Манай улсын хүн ам боловсролын түвшин өндөртэй ч, эмэгтэйчүүд дээд боловсрол эзэмшсэн байх нь өндөр цалинтай ажилд орох баталгаа болохгүй байна.

**Хүн амын боловсролын түвшин, ялангуяа залуучуудын эзэмшсэн боловсролын түвшин хөрш орнуудтай харьцуулахад хамгийн өндөр байгаа хэдий ч ядуу ба ядуу бус хүн ам боловсролын түвшингээрээ илт ялгаатай байна.** Өнөө үед залуучууд их сургуулийн дипломтой байх нь нийтлэг зүйл болсон. Тухайлбал, 25-29 насны залуучуудын тал хувь нь их, дээд сургуулийн түвшний боловсрол эзэмшсэн нь 45-49 настай иргэдийн боловсролын түвшнээс 30 пунктээр өндөр байна. Хүн амын боловсролын түвшин дээшилж байгаа хэдий ч ядуурал боловсролын түвшинтэй харилцан уялдаатай хэвээр байна. Ядуу хүн амын 10 гаруй хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Гэтэл чинээлэг айлын хүүхдүүд эрт суралцаж эхэлдэг, олон жил суралцдаг, мэдээллийн технологийн талаар илүү мэдлэгтэй байх боломжтой нь ядуу ба ядуу бус өрхийн хүүхдүүдийн дунд мэдлэг чадварын зөрүүг ихэсгэж байна.

**Залуу эмэгтэйчүүдийн (25-29 нас) 70 хувь нь дээд боловсрол эзэмшсэн ч энэ нь тэднийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоход нөлөөлөхгүй байна.** Хөвгүүд, тэр дундаа хөдөөгийн хөвгүүд гэр бүлийнхэндээ туслахын тулд сургуулиасаа эрт завсардах хандлагатай, харин охид илүү удаан суралцаж, өндөр боловсрол эзэмших хандлагатай байна. Эмэгтэйчүүд өндөр боловсрол эзэмшиж байгаа хэдий ч 45 хувь нь эдийн засгийн хувьд идэвхгүй хэвээр байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо бараг



нэмэгдсэнгүй. Харин 2018 онд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо хамгийн өндөр түвшин (72.1 хувь)-д хүрсэн байна. Эндээс ажиллах хүчний оролцооны түвшин дэх хүйсийн ялгаа сүүлийн хоёр жилд нэмэгдсэн нь харагдана. Ажиллах хүчний оролцооны түвшин дэх хүйсийн ялгаатай байдал нь төрөлтийн настай мөн холбоотой бөгөөд хүүхэд төрүүлэх нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бууруулдаг байна.

Ядуу хүмүүс санхүүгийн хувьд сул, хөрөнгийн өмчлөл мүүтэй, түүнээс хүртэх үр өгөөж багатай учир ядуу амьдрах нэг нөхцөл болж байна.

**Ядуу өрхүүд санхүүгийн хувьд сул, хөрөнгийн өмчлөл багатай байна.** Чинээлэг өрхүүд тансаг зэрэглэлийн эд хөрөнгөтэй, мэдээлэл технологийн хүртээмж сайтай, санхүүгийн зах зээлд оролцох боломж илүү байна. Харин ядуу өрхүүд эсрэгээрээ цөөн тооны хөрөнгөтэй, хадгаламжгүй байх нь элбэг бөгөөд өдөр тутмын хэрэгцээгээ хангахын тулд мөнгө зээлэх шаардлагатай тулгарч байдаг. Ядуу малчин өрхүүд малаа зах зээлд борлуулахаас илүүтэйгээр өөрсдийн хэрэгцээнд хэрэглэх нь элбэг байна. Санхүү, хөрөнгийн дутмаг байдлаас болж ядуу хүн амд нэмэлт орлого олох боломж хязгаарлагдмал учраас өрхөд гэнэтийн хүндрэл бэрхшээл тулгарахад амьжиргаанд нь сөргөөр нөлөөлж байдаг. Хүмүүс үр хүүхдэдээ хөрөнгөө өвлүүлэх нь хөрөнгийн ялгаа, өмчлөлийн тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх болно.

Суурь үйлчилгээг иргэдэд хүргэх ялангуяа ариун цэврийн байгууламж, байнгын халаалтын эх үүсвэрээр хангахад бэрхшээл тулгарсаар байна.

**Гэрт амьдардаг өрхүүд суурь үйлчилгээгээр хангагдах боломж хязгаарлагдмал хэвээр байна.** Гэрт амьдардаг хөдөөгийн ядуу арван хүн тутмын ес нь суурь дэд бүтцийн (сайжруулсан ундны ус, ариун цэврийн байгууламж болон байнгын халаалт) аль нэг үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байна. Энэ нь ихэвчлэн тэдний сууцны төрөл (гэр), байршлаас (алслагдсан хөдөө эсвэл хотын гэр хороолол) шалтгаалж байна. Хүн амын хамгийн чинээлэг бүлэгт амьдарч буй иргэдийн 40 орчим хувь нь сайжруулаагүй ариун цэврийн байгууламжтай, уламжлалт халаалтын эх үүсвэртэй байна. Энэ үзүүлэлт нийслэлд 50-60 хувь байна. Суурь үйлчилгээний хүртээмж аймгуудын хувьд ялгаа ихтэй, Хангай болон Баруун бүсийн ихэнх аймагт хомсдолтой байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдүүд ядууралд илүү өртсөн байна. Цаашид хөгжилд хүрэхийн тулд ирж буй хүн ам зүйн (хүн амын цонх үе) сайхан боломжийг ашиглан залуучуудад бодитой, өгөөжтэй хөрөнгө оруулалт хийн, илүү сайн, илүү их ажлын байр бий болгох нь чухал юм.

**Ядуу таван хүн тутмын хоёр нь 15, түүнээс доош насны хүүхдүүд байжээ.** Ядуурал нь өрхийн хүүхдийн тоо болон хүн ам зүйн ачаалалтай өндөр хамааралтай байна. Энэ нь хүүхдүүдээ тэжээх орлого олдог хүний тоо өрхөд хангалтгүй байгааг харуулна. Бүх насны хүүхдүүд, олон хүүхэдтэй залуу гэр бүл (30-39 нас) ахимаг насныхантай харьцуулахад илүү ядуу байна. Өрх олон хүүхэдтэй болох тусам ядууралд илүү өртөж байна. Тухайлбал 2018 онд 3, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тал хувь нь ядууралд өртсөн байжээ. Мөн өрхийн гишүүний тоо нэмэгдэх нь ядуу амьдрах нэг нөхцөл болж байна. 8-аас дээш ам бүлтэй өрхийн 68.9 хувь ядууралд өртсөн байв.


**Манай улсад “Хүн амын цонх үе” үргэлжилж байгаа ба бидэнд бүх салбарт үр чадвар сайтай залуу боловсон хүчин бэлтгэх, ажлын байр нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.** Хүн ам зүйн бүтцийн хувьд манай улс Зүүн Азийн орнууд дундаа хамгийн залуу хүн амтай орнуудын нэг ба нийт хүн амын гуравны нэг нь хүүхдүүд байдаг. Хүн амын дийлэнх болох залуучууд удахгүй хөдөлмөр эрхэлж эхлэх учир зөвхөн хөрөнгө оруулалт их шаарддаг уул уурхайн салбарт бус, харин эдгээр шинэ ажиллагчдыг шингээж чадах олон төрлийн салбарт хангалттай тооны ажлын байр бий болгох шаардлага үүсэх юм. Энэ боломжийг ашиглан цаашдаа эдийн засгийг өсгөх, ядуурлыг бууруулахад хүүхэд, залуучуудыг үр чадвартай боловсон хүчин болгож бэлтгэх хөрөнгө оруулалт нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний тэгш, шударга оролцоог хангахтай нэгэн адил чухал юм.






## ЯДУУРАЛ БА ТЭГШ БУС БАЙДАЛ


■ Нийт хүн амын **28.4 хувь** ядуу амьдарч байна.




■ Нийт хүн амын **15 хувь** ядууралд өртөхөд ойрхон эмзэг байдалтай байна.



Хөдөөгийн ядуурал буурсан ч хотын ядуурал өөрчлөлтгүй хэвээр байна.  
Гурван ядуу хүн тутмын хоёр нь хот, суурин газарт амьдарч байна.



Хамгийн бага хэрэглээтэй 20 хувийн хүн амын хэрэглээний дундаж өсөлт хөдөөд хамгийн их, хотод хамгийн бага хувиар нэмэгдсэн байна.



Энэ бүлэгт 2018 оны ядуурлын байдал болон 2010-аас 2018 оны тэгш бус байдлын хандлагыг харуулна.

## 1.1. ЯДУУРЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Ядуурлын хамралтын хүрээг 2018 оны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны үр дүнд үндэслэн тооцож үзэхэд нийт хүн амын 28.4 хувь буюу 904.9 мянган хүн ядуу амьдарч байна.** Нэг хүнд ногдох сарын хэрэглээ 166580 төгрөг<sup>2</sup>, түүнээс доош бол ядуу гэж тооцогдоно. Өөрөөр хэлбэл үндэсний ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа иргэд амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангах зайлшгүй шаардлагатай хүнс болон хүнсний бус хэрэглээний зүйлсээ худалдан авах чадваргүй байна гэсэн үг юм.

Ядуурлын хамралтын хүрээг илэрхийлж байгаа энэ үзүүлэлтийг ойлгоход хялбар ч уг хэмжигдэхүүн ядуурлын тархалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгдөггүй. Ядуурлын хамралтын хүрээнээс гадна ядуурлын гүнзгийрэлт ба мэдрэмж гэсэн хоёр өөр хэмжүүрийг хамтад нь авч үздэг. Ядуурлын гүнзгийрэлт ядуу хүн амын хэрэглээ ядуурлын шугамаас хэр доогуур байгааг тодорхойлдог. Энэ үзүүлэлт 2018 онд 7.2 хувьтай байгаа нь ядуу хүний дундаж хэрэглээ ядуурлын шугамаас ойролцоогоор 7.2 хувиар бага байгааг харуулна. Ядуурлын мэдрэмжийн индекс ядуурлын гүнзгийрэлтийн квадрат зэрэгт дэвшүүлсэн утга бөгөөд ядуу хүн ам ядуурлын шугамаас хол байх тусам илүү их жигнэнэ гэсэн үг. Энэ үзүүлэлт ядуу хүн амын дундах хэрэглээний ялгаатай байдал буюу тэгш бус байдлыг харуулдаг. Ядуурлын мэдрэмжийн индекс 2.7 байна.

Зураг 1.1.1

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дунджаар, хувиар, 2018<sup>3</sup>



## 1.2. ЯДУУРЛЫН ШУГАМ, ЯДУУРЛЫН ХАМРАЛТЫН ХҮРЭЭНИЙ ХАРЬЦААНЫ МЭДРЭМЖ

**Олон тооны иргэд ядуурлын шугамын дөнгөж дээгүүр хэрэглээтэй амьдарч байгаа нь тэднийг ядууралд өртөж болзошгүй эрсдэлтэй байгааг харуулж байна.** Ядуурлын шугам өөрчлөгдөхөд ядуурлын үндсэн үзүүлэлтүүд хэр зэрэг мэдрэмжтэй байгааг ойлгох нь чухал. Ядуурлын шугамыг бага зэрэг өсгөх эсвэл бууруулахад ядуурлын үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөхийг энэ хэсэгт харуулав. Зураг 1.2.1-д нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр тооцсон тархалтыг ядуурлын шугам болон ядуурлын шугамыг 25 хувиар нэмэгдүүлсэн үзүүлэлтийн хамт дүрслэн харууллаа. Ядуурлын шугамыг 25 хувиар өсгөхөд нийт хүн амын 14.9 хувь буюу 474.8


1 Судалгааг үндэсний болон бус нутаг (Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар), хот, хөдөө, суурьшил (Улаанбаатар, аймгийн төв, сумын төв, хөдөө нутаг), аймгийн түвшинд үр дүнг тархах боломжтойгоор зохион байгуулан явуулдаг.

2 Ядуурлыг нэг хүнд ногдох сарын хэрэглээнд тулгуурлан тооцдог. Нэг хүнд ногдох сарын хэрэглээ буюу үндэсний ядуурлын шугам 2018 онд 166580 төгрөг байна. Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.


3 Зурганд 95%-ийн итгэмжлэлт интервалтай үед алдааны хэмжээ ямар байгааг харуулав.

мянган хүн ядуурлын шугам болон ядуурлын шугамыг 25 хувиар өсгөсөн үзүүлэлтийн хооронд орж 2018 оны нийт хүн амын 28.4 хувь буюу 904.9 мянган ядуу хүн дээр нэмэгдэхээр байна. Эдгээр “бараг л ядуу” хүмүүс үнийн өсөлт, ажилгүйдэл, өвчин, байгалийн гамшигт нэрвэгдэх зэрэг цочролд өртөхөд л ядууралд орох эмзэг байдалтай байна

**Зураг 1.2.1** Нэг хүнд ногдох хэрэглээний тархалт, 2018




**Зураг 1.2.2** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуурлын шугамыг хувилснаар, 2018



### 1.3. ЯДУУРЛЫН ГАЗАР ЗҮЙН ТАРХАЛТ

**Ядуурал бүсээр ялгаатай байна.** Ядуурлын үзүүлэлтүүдийг Баруун, Хангай, Төв, Зүүн болон Улаанбаатар гэсэн таван бүс нутгаар Зураг 1.3.1-д харуулав. Улаанбаатар хот, Төвийн бүсэд ядуурал хамгийн бага буюу нийт хүн амынх нь 25.9-26.1 хувь нь ядуу байна. Баруун, Хангай болон Зүүн бүсэд ядуурлын хамралтын хүрээ өндөр, нийт хүн амынх нь 30.8-37.4 хувь нь ядуу ялангуяа Зүүн бүсэд таван хүн түтмын хоёр нь ядуу амьдарч байгаа буюу үндэсний хэмжээнд ядуурлын түвшин хамгийн өндөр үзүүлэлттэй бүс болсон байна. Гэвч хүн амын бага хувь амьдардаг Зүүн бүсэд (7 хувь) нийт ядуу хүн амын 10 хүрэхгүй хувь ногдож байна (Зураг 1.3.1).


Зураг 1.3.1

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, бүсээр<sup>4</sup>, хувиар, 2018

**Хөдөө орон нутагт ядуурлын хамралт илүү өндөр байгаа боловч ядуу хүн амын төвлөрөл хот суурин газарт өсөн нэмэгдэж байна.** Хөдөөд нийт хүн амын 30.8 хувь ядуу байгаа нь хот суурин газрын ядуурлын хамралт (27.2 хувь)-аас бага зэрэг өндөр байна (Зураг 1.3.2). Ядуурлын байдал хот суурин газар, хөдөөд ялгаатай байхын зэрэгцээ газар зүйн байршлаар мөн ялгаатай байна. Улаанбаатар хотод аймгийн төвүүдтэй харьцуулахад, сумын төвд хөдөө нутгийнхтай харьцуулахад ядуурлын хамралт бага байна. Манай улсын нийт хүн амын гуравны хоёр нь амьдардаг хот суурин газарт ядуу хүн амын төвлөрөл нэмэгдэж байна. 2018 онд хот суурин газар болох Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд нийт ядуучуудын 63.5 хувь нь амьдарч байгаа бол хөдөөд харьцангуй бага буюу хөдөө нутагт нийт ядуучуудын 18.1 хувь нь, сумын төвд нийт ядуучуудын 18.4 хувь нь амьдарч байна.

4 Баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгууд, Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон аймгууд, Төвийн бүсэд Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгууд, Зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд багтдаг.

**Зураг 1.3.2** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, суурьшлаар<sup>5</sup>, хувиар, 2018




**Ядуурлын хамралтын хүрээ аймгаар ялгаатай байна.** Зураг 1.3.3-д ядуурлын хамралтын хүрээг аймгаар үзүүлэв. Ядуурлын хамралтын хүрээ Говьсүмбэр аймагт хамгийн өндөр (51.9 хувь) буюу хүн амын талаас илүү нь ядуу амьдарч байна. Зүүн болон Баруун бүсийн аймгуудад ядуурлын хамралтын хүрээ өндөр, Улаанбаатар хот, Төв аймаг, Төвийн бүсийн зарим аймгуудад (Өмнөговь, Дундговь, Дорноговь) харьцангуй бага байна. Уул уурхайн баялаг ихтэй Өмнөговь аймагт ядуурлын түвшин хамгийн бага буюу аймгийн хүн амын 11.8 хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байна. Ядуучуудын газарзүйн байршлын тархалтыг харахад ядуу арван хүн тутмын дөрвөөс илүү нь (378.2 мянган ядуу хүн) Улаанбаатар хотод амьдарч байна. Говьсүмбэр аймагт ядуурлын хамралтын хүрээ хамгийн өндөр байгаа ч цөөн хүн амтай аймаг учраас нийт ядуучуудын 1 хувиас бага буюу 8.2 мянган хүн л ядуу амьдарч байна.


5 Хот, хөдөөг дөрвөн суурьшилд хуваадаг. Хотыг Улаанбаатар ба аймгийн төв, хөдөөг сумын төв ба хөдөө нутаг гэсэн суурьшилд хуваав.

**Зураг 1.3.3** Ядуурлын хамралтын хүрээ, аймгаар, хувиар, 2018


(а) Ядуурлын хамралтын хүрээ



(б) Ядуурлын хамралтын хүрээ



(в) Ядуу хүн амын дүнд эзлэх хувь



Эх үүсвэр: ӨНЗЭС 2018


## 1.4. ЯДУУРЛЫН ЧИГ ХАНДЛАГА

### Ядуурал 2010 оноос эрчимтэй буурсан хэдий ч 2016 оноос зогсонги байдалтай байна.

Ядуурлын байдал хэрхэн өөрчлөгдсөнийг 2010-аас 2018 оны байдлаар Зураг 1.4.1-д харуулав. Эдийн засгийн сэргэлтийн үе буюу 2010-аас 2014 онд ядуурал эрчимтэй буурч 38.8 хувиас 21.6 хувь болсон бол эдийн засгийн хямралын улмаас 2016 онд эргээд 29.6 хувь болж өсжээ. Ядуурлын хамралтын хүрээ 2016-аас 2018 оны хооронд 1.2 пунктээр буурч 2018 онд 28.4 хувь болжээ. Хүн амын өсөлт өндөр байсан хэдий ч ядуу хүний тоо 2016-аас 2018 оны хооронд 2.6 мянгаар буурсан байна. Дээрх хугацаанд ядуурлын хамралтын хүрээнд ямар нэгэн өөрчлөлт гаралгүй зөвхөн хүн ам өссөн гэж үзвэл ойролцоогоор 39 мянган хүнийг ядуурлаас гаргажээ гэж тооцож болно.<sup>6</sup>


6 Монгол Улсад оршин суугаа хүн ам 2016 онд 3064.0 мянга, 2018 онд 3186.0 мянга байсан. Ядуу хүн амын тоо 2016 онд 907.5 мянга, 2018 онд 904.9 мянга байв. Хүн амын өсөлт орсон тооцоогоор ядуу хүний тоо 2016-аас 2018 онд 2.6 мянгаар буурсан (2016-аас 2018 онд хүн амын жилийн дундаж өсөлт 2 хувь байв). Хэрэв 2018 онд ядуурлын хамралтын хүрээ 29.6 хувь хэвээрээ байсан гэж үзвэл 943.7 мянган хүн ядуу байх байжээ. Гэтэл 2018 онд 904.9 мянган хүн ядуу байгаа нь энэ хугацаанд ядуурал буурахад ахиц гарч ойролцоогоор 39 мянган хүнийг ядуурлаас гаргаж чаджээ гэж тооцов.

Зураг 1.4.1 Ядуурлын байдал, 2010-2018



**Хөдөө орон нутагт ядуурал эрчимтэй буурч чадсан ч хот суурин газрын ядуурал 2016-аас 2018 оны хооронд өөрчлөгдсөнгүй.** Хот суурин газарт ядуурлын хамралтын хүрээ бага хэдий ч хөдөө орон нутагт ядуурал хурдтай буурч байна. 2010 онд хөдөөгийн хүн амын арван хүн тутмын тав нь ядуу амьдарч байсан бол одоо арван хүн тутмын гурав нь ядуу байна. Гэтэл сүүлийн хоёр жилийн хугацаанд хот суурин газрын ядуурал буурсангүй. Үүний улмаас хот, хөдөөгийн ядуурлын хамралтын хүрээний зөрүү багассан гэхдээ хот суурин газарт ядуу хүн амын төвлөрөл харьцангуй их болсон байна. Хот суурин газарт амьдарч байгаа ядуу хүн амын эзлэх хувь нийт ядуу хүн амын 55.2 хувь (2010 онд) байснаа 63.5 (2018 онд) хувь болон өсжээ (Зураг 1.4.2б).

Зураг 1.4.2 Ядуурлын байдал, хот, хөдөөгөөр, 2010-2018






**Хүн амын 14.9 хувь ядууралд өртөх эмзэг байдалтай байна.** Ядуурлын шугам болон ядуурлын шугамыг 25 хувиар өсгөсөн үзүүлэлтийн хооронд байгаа хүн амыг эмзэг буюу ядууралд өртөхөд ойрхон хүн ам гэж тодорхойлсон. Зураг 1.4.3-г харуулснаар ядуу хүн амын хамралтын хүрээ цаг хугацааны явцад өөрчлөгдөж ирсэн хэдий ч хот, хөдөөд хүн амын ойролцоогоор 13-17 хувь ядууралд өртөхөд ойрхон хэвээр байна. Ядуурал буурахад ахиц дэвшил гарч байгаа хэдий ч хөдөөгийн ядуу бус хүн амын дөрвөн хүн тутмын нэг нь ядууралд өртөхөд илүү өндөр эрсдэлтэй байна. Ядуурлын шугамтай ойрхон байгаа хүн амын нягтрал хөдөөд хоттой харьцуулахад өндөр байгаатай үүнийг холбож ойлгож болох юм. Манай улсад ядууралд өртөхөд ойрхон, эмзэг байдалтай хүн ам их байгаа нь эдгээр хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх, амьдралын чанарыг сайжруулах хүчин чармайлт хэрэгтэй байгааг харуулж байна.

Зураг 1.4.3


Ядуу, ядууралд өртөхөд ойрхон хүн амын хамралтын хүрээ, хувиар, 2010-2018



**Бүсийн түвшний ядуурлын хамралтын хандлагыг харахад ядуурлыг бууруулахад гарч буй ахиц тэгш бүс байна.** 2010-аас 2018 оны хооронд Баруун болон Хангайн бүсэд ядуурлын хамралтын хүрээ их буурчээ (Зураг 1.4.4). Эдгээр бүсэд 2010 онд бүсийн хүн амын 50 гаруй хувь нь ядуу амьдарч байсан бол 2010-аас 2018 оны хооронд энэ үзүүлэлт 20 орчим пунктээр буурчээ. Ядуурлыг ийнхүү хурдацтай бууруулснаар Баруун, Хангайн бүсийн ядуу хүн амын эзлэх хувь хэмжээ 2010 онд 45 хувь байснаа 2018 онд 35 хувь болж буурсан байна харин бусад бүсэд (Төв, Зүүн ба Улаанбаатар хот) ядуурлыг бууруулахад хүндрэлтэй байжээ. Энэ хугацаанд Төв, Зүүн бүсэд ядуу хүн амын эзлэх хувь хэмжээ харьцангуй бага байсан мөн ядуурлын бууралт ч гэсэн зогсонги байдалтай байв. Баруун, Хангайн бүсэд ядуурал их хэмжээгээр буурсан учраас Зүүн бүс 2018 оны үзүүлэлтээр (37.4 хувь) улсын хэмжээнд хамгийн өндөр ядууралтай бүс болжээ. Нийт ядуу хүн амд эзлэх Улаанбаатар хотын ядуу хүн амын тоо 2010 онд 35 хувь байснаа өсөж 2018 онд 42 хувь болсон нь хотжилттой тодорхой хэмжээгээр холбоотой гэж дүгнэж болохоор байна.

Зураг 1.4.4

Ядуурлын байдал, бүсээр, 2010-2018




### 1.5. ЯДУУРЛЫН БУУРАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

**Сүүлийн үед ДНБ-ий өсөлт эрчимтэй байгаа ч ядуурлын бууралтын хүрд саарчээ.**

Ядуурлын мэдрэмжийн өсөлт нэг хүнд ногдох хэрэглээний өсөлт болон ДНБ-ий өсөлт ядуурлын бууралтад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарладаг үзүүлэлт юм. 2010-аас 2014 оны хооронд нэг хүнд ногдох бодит ДНБ 1 хувиар өсөхөд ядуурал 0.9 нэгж хувиар буурсан байна. Гэвч 2016-аас 2018 оны хооронд нэг хүнд ногдох бодит ДНБ өсөлтийн ядуурлын бууралтад нөлөөлсөн хүрдыг харьцуулан үзвэл 50 хувь бага, нэг хүнд ногдох бодит ДНБ нэг хувийн өсөлт ядуурлын хамралтыг 0.5 нэгж хувиар бууруулжээ (Зураг 1.5.1а). Нэг хүнд ногдох хэрэглээний өсөлт болон ядуурлын мэдрэмжийн өсөлтийн хамаарал ижил хандлагатай байгаа нь ажиглагдлаа (Зураг 1.5.1б). Нэг хүнд ногдох хэрэглээнээс шалтгаалсан ядуурлын мэдрэмжийн үзүүлэлт 2010-аас 2014 онд -1.6 байсан бол 2016-аас 2018 онд -1.0 болсон байв. Өрхийн судалгааны болон үндэсний тооцооны тоо мэдээлэл ядуурлын мэдрэмжийн өсөлтөд өөр өөрөөр нөлөөлөх нь тийм ч нийтлэг бүс<sup>7</sup> боловч энэ хоёр шинжилгээний дүнгээс харахад эдийн засаг, хүн амын хэрэглээний өсөлтийн үр өгөөжийг ядуу хүн ам хүртэж чадахгүй байгааг харуулж байна.

7 Раваллион (2001) ба Адамс (2004)-г үзнэ үү.


Зураг 1.5.1 Ядуурлын бууралтад мэдрэмжийн өсөлт нөлөөлөх нь, 2010-2018



## 1.6. БАЯЛГИЙН ХУВААРИЛАЛТ, ТЭГШ БУС БАЙДАЛ

**2010 оны эхэн үеийн эдийн засгийн сэргэлтийн үед өсөлтийн үр өгөөжийг хүн ам хангалттай хүртэж байсан бол 2016-аас 2018 оны хооронд энэ үйл явц удааширсан байна.** Хүн амын хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн нэг хүнд ногдох хэрэглээний жилийн дундаж өсөлт 2010-аас 2014 онд 7.2 хувь байгаа нь нийт хүн амын нэг хүнд ногдох хэрэглээний жилийн дундаж өсөлтөөс 0.9 пунктээр илүү байна (Зураг 1.6.1а). Энэ хугацаанд хэрэглээний өсөлт ядуу хүн амд илүү таатайгаар хуваарилагдсан бөгөөд хэрэглээний өндөр өсөлт нь ядуурлыг бууруулах үйл явцыг дэмжиж, хүрдасгажээ. Харин 2016-аас 2018 онд хүн амын хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн нэг хүнд ногдох хэрэглээний өсөлт 1.3 хувь болсон нь нийт хүн амын нэг хүнд ногдох хэрэглээний жилийн дундаж өсөлтөөс 0.6 пунктээр бага байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн нэг хүнд ногдох хэрэглээний өсөлтийн хэв шинж мөн ялгаатай байна. Хот, хөдөөгийн хүн амын хамгийн их хэрэглээтэй 40 хувийн (IV ба V) нэг хүнд ногдох хэрэглээний өсөлт ижил байсан бол хамгийн бага хэрэглээтэй 60 хувийн (I-III) хэрэглээний өсөлт маш их ялгаатай байна (Зураг 1.6.1б). Хөдөөгийн хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний өсөлт хамгийн ихээр (3.8 хувь) өссөн, хот суурин газрын хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний өсөлт хамгийн бага өсөлттэй (0.1 хувь) байна.

**Зураг 1.6.1** Нэг хүнд ногдох хэрэглээний өсөлт, хот, хөдөөгөөр, хувиар



**Хот суурин газрын ядуу хүн амд эдийн засгийн өсөлт хүртээмжгүй байснаас 2016-аас 2018 оны хооронд ядуурал буурах үйл явц саарсан болохыг шинжилгээний дүн харуулж байна.** Өсөлт-тэгш бус байдлын бүтцийн шинжилгээгээр (Датт, Раваллион нар 1992) ядууралд гарсан өөрчлөлт нэг хүнд ногдох дундаж хэрэглээний өсөлт, хэрэглээний хуваарилалтын алинаас илүү хамааралтай болохыг шинжилдэг. Хүснэгт 1.6.1-д харуулснаар 2016-аас 2018 оны хооронд хөдөөд хэрэглээний дундаж өсөлт ядуурлыг 4.2 пунктээр буурахад нөлөөлсөн, харин ядууралд үзүүлэх тэгш хуваарилалтын нөлөө бараг тэг (0.1 пункт) байна. Өөрөөр хэлбэл хөдөөд хэрэглээний өсөлт ядуурлыг бууруулахад бүрэн нөлөөлжээ. Харин хотод хэрэглээний өсөлт ядуурал буурахад нөлөөлж чадаагүй байна. Хэрэв баялгийн хуваарилалт өөрчлөгдөөгүй бол дундаж хэрэглээний өсөлт хот суурин газрын ядуурлыг 2.0 пунктээр бууруулж чадах байсан ч тэгш бус байдал нэмэгдсэнээр ядуурлыг эргээд 2.1 пунктээр өсөхөд хүргэсэн байна.<sup>8</sup> Энэ нь хот суурин газрын ядуурал 2016-аас 2018 оны хооронд өөрчлөлтгүй хэвээр үлдэхэд хүргэжээ.

**Хүснэгт 1.6.1**

Ядуурлын өөрчлөлтийг хэрэглээний өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь 2016, 2018 оны зөрүүгээр, пунктээр

	Улсын дундаж	Хот	Хөдөө
Хэрэглээний өсөлт	-2.51	-2.05	-4.23
Тэгш бус хуваарилалт	1.28	2.12	0.11
Ядуурлын өөрчлөлт	-1.23	0.07	-4.12


Эх үүсвэр: ӨНЭЗС 2016, 2018

8 Хэрэглээний дундаж түвшин өөрчлөгдөөгүй гэж таамаглав.

**Нийслэл хотод ядуурал буурах үйл явц саарсан бол хөдөө орон нутгийн хүн ам ядуурал буурахад чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна.** Газар зүйн байршлын задлан шинжилгээний арга нь (Раваллион, Хуппи нар 1991) бүс хоорондын хүн амын шилжилт хөдөлгөөн ядуурлын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг тооцдог. Хөдөө орон нутгийн хүн ам нийт хүн амын 20 хүрэхгүй хувийг эзэлдэг боловч 2010-аас 2014 онд нийт ядуурлын хамралтын бууралтын гуравны нэг, 2016-аас 2018 онд гуравны хоёрыг бүрдүүлжээ (Зураг 1.6.2). Улаанбаатар хот 2010-аас 2014 онд нийт ядуурлын хамралтын бууралтын 37.4 хувийг бүрдүүлж байсан бол 2016-аас 2018 онд ядуурлын бууралт зогсонги байдалд оржээ. Сүүлийн хоёр жилийн хугацаанд (2016-2018 он) үндэсний хэмжээнд ядуурлын хамралт хамгийн ядуу суурьшил буюу хөдөө нутагт 5 пунктээр буурсан хэдий ч 2018 онд хөдөөгийн хүн амын 32.9 хувь нь ядуу амьдарсан хэвээр байна.

Зураг 1.6.2

Ядуурлын шинжилгээ, суурьшлаар



**Хот, хөдөөгийн хүн амын хэрэглээний өсөлт, түүний хуваарилалтын ялгаатай байдал нь тэгш бус байдлын үзүүлэлтэд нөлөөлснөөр 2018 онд улсын хэмжээнд тэгш бус байдал харьцангуй тогтвортой байхад нөлөөлжээ.** Хүснэгт 1.6.2-т харуулснаар хотын хэрэглээний өсөлтийн тэгш бус хуваарилалт Жини коэффициентыг 2016 онд 33.1 байсныг 2018 онд 34.0 болон өсөхөд хүргэжээ. Харин хөдөөд хүн амын хэрэглээний өсөлтийн хуваарилалт тэгш байснаар 2016-аас 2018 онд тэгш бус байдал буурсан байна. Хүн амын хэрэглээний өсөлт, түүний хуваарилалтын холимог хосолсон шинж үндэсний хэмжээнд тэгш бус байдал 2016 онд 32.3 байсныг 2018 онд 32.7 болж бага зэрэг нэмэгдэхэд нөлөөлжээ. Тэгш бус байдлын Жини коэффициент энэ хугацаанд тогтвортой үлдсэн ба хөрш зэргэлдээ орнуудын үзүүлэлтээс харьцангуй бага байна (Зураг 1.6.3).


## Хүснэгт 1.6.2

Тэгш бус байдлын чиг хандлага, 2010-2018

	2010	2012	2014	2016	2018
<b>Жини коэффициент</b>					
Улсын дундаж	33.0	33.8	32.0	32.3	32.7
Хот	32.9	34.2	32.9	33.1	34.0
Хөдөө	31.7	30.6	28.3	29.6	29.2
<b>Тейлийн индекс</b>					
Улсын дундаж	19.3	20.0	18.6	19.0	19.2
Хот	19.3	20.6	19.5	20.0	20.6
Хөдөө	17.5	16.2	14.6	15.4	15.1

Эх үүсвэр: ӨНЭЭС 2010-2018

## Зураг 1.6.3

Хөрш зэргэлдээ хөгжиж буй орнуудын Жини коэффициент<sup>9</sup>


9 Малайз, Филиппин улс Жини коэффициентийг хэмжихдээ нэг хүнд ногдох орлогыг ашигласан бол бусад орнууд хэрэглээг ашигласан байна. Эх үүсвэр: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд (ДХҮ): <https://datacatalog.worldbank.org/dataset/world-development-indicators>

# 2

## БҮЛЭГ

### ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ

Хүн амын хэрэглээний бүтэц, ядуурлын байдлаар:  
Ядуу хүмүүс хүнсний хэрэглээндээ илүү зардал гаргадаг байна.



Ядуу хүмүүс ядуу бус хүмүүсээс...



Хүнсэнд  
2 дахин



Боловсролд  
4 дахин



Эрүүл мэндэд  
6 дахин



Хувцсанд  
3 дахин



Тээвэр, харилцаа  
холбоонд  
4 дахин

бага хэрэглээний зардал гаргаж байна.

Хэн илүү ядуу амьдарч байна вэ?



Нийт ядуу хүн амын  
42 хувь нь 15 хүртэлх  
насны хүүхдүүд байна.



3, түүнээс олон  
хүүхэдтэй өрхүүдийн  
тал нь ядуу байна.



Ядуу 3 хүн тутмын 2 нь  
бүрэн дунд, түүнээс бага  
боловсролтой байна.



Хөдөлмөрийн насны хүн  
амын дунд **ажилгүй, эдийн  
засгийн идэвхгүй хүмүүс**  
хамгийн ядуу амьдарч байна.



Ихэнх ядуу хүмүүс **ур  
чадвар бага шаарддаг  
энгийн ажил** эрхэлж байна.




Ядуу хүмүүс  
**санхүүгийн хөрөнгө  
муутай** байна.

Энэ бүлэгт хүн амын хэрэглээний хэв шинж, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөрөнгийн эзэмшил, суурь үйлчилгээний хүртээмж зэрэг үзүүлэлтүүдээр 2018 оны ядуурлын дүр төрхийг харууллаа.

## 2.1. ЯДУУРАЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ ХЭВ ШИНЖ

**Ядуу бус хүн амын нэг хүнд ногдох дундаж хэрэглээ ядуу хүн амтай харьцуулахад гурав дахин их байна.** Судалгааны 2018 оны дүнгээр ядуу бус нэг хүн сард дунджаар 342 мянган төгрөгийг хэрэглээндээ зарцуулдаг бол ядуу хүн 124 мянган төгрөг буюу өдөрт 4093 төгрөг зарцуулж байна (Зураг 2.1.1а). Хамгийн чинээлэг бүлгийн хүмүүс хамгийн ядуу бүлгийн хүмүүсийн зарцуулсан хэмжээнээс 5 дахин их мөнгө хэрэглээндээ зарцуулжээ. Өөрөөр хэлбэл хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээ улсын нийт хэрэглээнд харьцангуй давамгайлж, нийт хэрэглээний 41 хувийг эзэлж байгаа бол хамгийн ядуу 20 хувийнхны хэрэглээ дөнгөж 8 хувийг эзэлж байна (Зураг 2.1.1б).

**Зураг 2.1.1** Нэг хүнд сард ногдох дундаж хэрэглээ ба хэрэглээний тархалт, тэнцүү 5-н бүлгээр, 2018




**Ядуу хүмүүс хэрэглээнийхээ ихэнх хувийг хүнсэндээ зарцуулах хандлагатай байна.** Хамгийн ядуу бүлгийн нэг хүнд ногдох хүнсний дундаж хэрэглээ хамгийн чинээлэг бүлгийн нэг хүний зарцуулсан үнийн дүнгийн гуравны нэгийг эзэлж байна (Зураг 2.1.2а). Амьжиргааны түвшин дээшлэх тусам нийт хэрэглээнд хүнсний хэрэглээний эзлэх хувь аажмаар буурч байна. Хэрэглээний бүлгийн хамгийн ядуу 20 хувьд амьдардаг хүмүүс нийт хэрэглээнийхээ 43 хувийг хүнсэндээ зарцуулдаг бол хамгийн чинээлэг 20 хувь нь 26 хувийг хүнсэндээ зарцуулжээ (Зураг 2.1.2б).



Зураг 2.1.2

Нэг хүнд сард ногдох дундаж хэрэглээ, хэрэглээний бүтэц, ядуу, ядуу бусаар, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, 2018




Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

Тайлбар: Хүнсний хэрэглээнд согтууруулах ундаа болон тамхийг оруулж тооцов.

**Ядуучууд, ялангуяа хөдөө орон нутагт амьдардаг хүмүүсийн хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний төрөлжилт хязгаарлагдмал, шим тэжээлтэй хүнсний бүтээгдэхүүн хангалттай бус байна.** Манай улсын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн нь мах, гурил, сүүн бүтээгдэхүүн юм. Ядуу хүмүүс хүнсний хэрэглээнийхээ 80 хувийг эдгээр бүтээгдэхүүнд зарцуулдаг байна. Ядуу бус хүмүүс мөн адил хүнсний хэрэглээнийхээ дийлэнх хувийг эдгээр бүтээгдэхүүнд зарцуулдаг боловч ядуу хүмүүстэй харьцуулахад илүү олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж байна (Зураг 2.1.3). Ихэнх хүмүүс гэрээсээ хол зайтай ажилладаг учир ажлын газрынхаа ойролцоо хоолны газар, ресторанд орж хооллох, эсвэл гаднаас хоол авч идэхэд мөнгө зарцуулж байгаа нь хот суурин газрын ядуу бус хүн амын дунд “гадуур хооллох” хэв маягийг ихэсгэж, амьдралын өөр хэв маяг бий болох хандлага үүссэн байна.

Зураг 2.1.3

Хүнсний хэрэглээний бүтэц, хувиар, 2018




Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

Тайлбар: Бусад гэдэгт загас, бусад далайн бүтээгдэхүүн болон бусад хүнсний бүтээгдэхүүн орно.

**Хөдөөгийн хүн ам хүнсний хэрэглээнийхээ тал хувийг хувийн аж ахуйгаасаа хэрэглэдэг бол хотын хүн ам бүх төрлийн хүнсний зүйлийг худалдан авч хэрэглэх шаардлагатай болдог.** Малчид хүнсний хэрэглээнийхээ ихэнх хувийг хувийн аж ахуйгаасаа хангадаг. Тухайлбал, махны хэрэглээнийхээ 80 хувийг хувийн мал аж ахуйгаасаа хэрэглэж байна (Зураг 2.1.4а). Харин голчлон цалингийн болон бизнесийн үйл ажиллагааны орлоготой хотын хүн ам бараг бүх хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэдэг нь хүнсний бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөлд өртөх эрсдэлтэй байдаг. 2016 оноос хойш хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом өсөж (Зураг 2.1.4б), 2018 оны зун (жилийн өмнөхөөс) инфляцын түвшинг 12 хувьд хүргэв. Хэрэглээнийхээ ихэнх хувийг хүнсэндээ зарцуулдаг хотын ядуу хүн амд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт хүндээр тусч, 2016-аас 2018 онд хотын ядуурал буурахгүй зогсонги байдалд ороход нөлөөлжээ. Харин цөөн нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг, мал аж ахуйгаасаа хамааралтай амьдардаг хөдөөгийн ядуу малчдад хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нөлөө багатай ч мал, малын гаралтай бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл эмзэг тусах юм. Мөн түүнчлэн хахир өвөл (зуд) эсвэл бусад байгалийн гамшиг тохиолдоход малчдын хөдөлмөр эрхлэлт, орлого, хэрэглээ зэрэг амьжиргааны байдалд шууд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Зураг 2.1.4

Хүнсний хэрэглээнд хувийн аж ахуйн хэрэглээний эзлэх хувь, хүнсний үнийн индексийн хандлага




**Ядуу болон ядуу бус хүн амын хүнсний бус хэрэглээний зардал нэлээд ялгаатай байна<sup>10</sup>.** Халаалт болон үйлчилгээний зардлаас бусад бүх хүнсний бус хэрэглээнд ядуу бус хүн ам ядуу хүн амтай харьцуулахад 3-6 дахин их мөнгө зарцуулжээ (Зураг 2.1.5а). Ядуу өрхүүд дулаалга муутай сууцанд амьдрах нь нийтлэг учир өвлийн сард сууцаа дулаан байлгах халаалтын хэрэглээ нь харьцангуй их байдаг. Ядуу хүмүүс дунджаар сарын хүнсний бус хэрэглээнийхээ 18 хувийг халаалт, халаалт ашигласан үйлчилгээнд зориулдаг бол ядуу бус хүмүүс энэ хэрэглээнд 10 хувийг зарцуулдаг байна. Түүнчлэн хүнсний бус хэрэглээний бүлэг дэх эрүүл мэндийн зардлын ялгаатай байдлыг хүмүүсийн дадал, давуу байдалтай холбон тайлбарлаж болно. Өвдөж эсвэл гэмтсэн үедээ ядуу бус хүмүүс хувийн эмнэлэгт хандан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахыг илүүд үзэж, шаардлагатай эм, тариа, витаминьг худалдан авдаг бол ядуу хүмүүс хангалттай хэмжээнд

10 2018 оны ӨНЭЗС-нд хүнсний бус хэрэглээний 360 гаруй нэр төрлийг багтаасан бөгөөд үүнд хувцас, тээвэр, харилцаа холбоо, ахуйн болон бусад хүнсний бус бүтээгдэхүүний зардал багтсан болно. Нэмж хэлэхэд, боловсрол, эрүүл мэнд, халаалт, түрээс, удаан эдэлгээтэй барааны зардлыг тусад нь тооцдог.

эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал байдаг. Судалгаанаас тооцож үзэхэд ядуу бус хүмүүс ядуу хүмүүстэй харьцуулахад зургаа дахин их мөнгө эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулжээ. Хот, хөдөөгийн ядуу бус хүмүүс хүнсний бус хэрэглээнийхээ 10 гаруй хувийг эрүүл мэнддээ зарцуулдаг, харин ядуу хүмүүс 4-өөс 7 хувийг зарцуулж байна (Зураг 2.1.5б). Боловсрол, тээвэр, холбоо, удаан эдэлгээтэй бараа, түрээс зэрэг бусад хүнсний бус бүлгийн зардал нийт хэрэглээ нэмэгдэхийн хэрээр дагаж өсжээ. Хөдөөд ядуу болон ядуу бус өрхүүдийн нийт хэрэглээнд хувцсанд зарцуулсан зардал давамгайлж байгаа нь газарзүйн байршлаас шалтгаалан хүнсний бус барааны хүртээмж хангалтгүй байдгаас хувцас худалдан авахад их зардал гаргадаг байж болох юм.

**Зураг 2.1.5** Хүнсний бус хэрэглээний бүтэц, 2018




## 2.2. ӨРХИЙН ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ ЧАНАРУУД


**Ам бүл цөөтэй өрхүүд амьжиргаа сайтай байна.** Манай улсын нэг өрх 2018 онд дунджаар 3.6 ам бүлтэй үүнээс ядуу бүлэгт хамаарах өрхүүдийн ам бүлийн дундаж 4.8, ядуу бус өрхүүдийн ам бүлийн дундаж 3.2 байна (Зураг 2.2.1а). Хэрэглээний ялгаатай бүлгүүдэд өрхийн ам бүлийн дундаж тоо өөр байна. Тухайлбал хамгийн ядуу 20 хувийн өрхийн ам бүлийн дундаж хамгийн чинээлэг хувийнхны ам бүлийн дунджаас ойролцоогоор 2 дахин их байна.

**Хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэжээгдэгчдийн тоо болон хүүхдийн тоо ихсэх тусам ядуурал нэмэгдэж байна.** Өрхийн гишүүдийн насны бүтэц ядуурлыг тодорхойлох нэг үзүүлэлт юм. Ядуу өрх олон хүүхэдтэй байгаа нь хүн ам зүйн ачаалал нэмэгдэхэд хүргэж байна (Зураг 2.2.1б, Зураг 2.2.2). Өөрөөр хэлбэл, ядуу өрхөд өрхийн бусад гишүүдээ, ялангуяа үр хүүхдүүдээ тэжээн тэтгэх хангалттай тооны хөдөлмөрийн насны хүмүүс дутагдалтай байгааг харуулж байна. Ядуу өрх ядуу бус өрхтэй харьцуулахад нэг хүнд ногдох орлого бага байх хандлагатай байдаг.

**Зураг 2.2.1** Өрхийн ам бүлийн дундаж тоо, 2018



**Зураг 2.2.2** Хүн ам зүйн ачаалал<sup>11</sup>, хувиар, 2018




**Нийт ядуу хүн амын 42<sup>12</sup> хувь нь 15 хүртэл насны хүүхдүүд байна.** Зураг 2.2.3а-д ядуурлын хамралтын хүрээг насны бүлгээр харуулав. Бүх насны хүүхдүүд, 30-39 насны залуучууд ахмад үеэс илүү ядууралд өртөж байна. Тухайлбал, 5 хүртэлх насны хүүхдүүдийн 38 хувь ядуу байгаа нь өндөр үзүүлэлт юм. Нөгөөтэйгүүр ядуу зургаан хүн тутмын нэг<sup>13</sup> нь сургуулийн өмнөх насны буюу 5 хүртэлх насны хүүхдүүд байна. Өрхийн түвшинд олон хүүхэдтэй (0-14 нас) өрх, ялангуяа 3, түүнээс олон хүүхэдтэй өрх хүүхэдгүй өрхтэй харьцуулахад илүү ядуу амьдарч байна (Зураг 2.2.3б). Дүгнэхэд, залуу өрхийн тэргүүнтэй (30-39 нас), олон хүүхэдтэй өрхүүд ядууралд илүү өртөмтгий байна.

11 Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох “тэжээгдэгчийн” хувийг илэрхийлдэг. Хүн ам зүйн ачаалал нь өрхийн хөдөлмөрийн бус насны гишүүд (15 хүртэлх насны хүүхдүүд болон 65, түүнээс дээш насны хөгшдийн тоо)-ийн тоог хөдөлмөрийн нас (15-64 нас)-ны гишүүдийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, Хүүхдийн ачааллыг 15 хүртэлх насны хүүхдийн тоог өрхийн хөдөлмөрийн насны гишүүд (15-64 нас)-ийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, Хөгшдийн ачааллыг 65, түүнээс дээш насны ахмадуудын тоог өрхийн хөдөлмөрийн насны гишүүд (15-64 нас)-ийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

12 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.


13 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.

**Зураг 2.2.3** Ядуурлын хамралтын хүрээ, насны бүлэг, хүүхдийн тоогоор, хувиар, 2018



**Манай улсад нийт хүн амын дийлэнхийг залуучууд, хүүхдүүд эзэлдэг учир хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ ажлын байр бий болгох сорилт тулгарч байна.** Судалгааны 2018 оны дүнгээр хүн амын голч нас 27<sup>14</sup> байгаа нь Зүүн Азийн хөгжиж буй орнууд дунд нийт хүн амд эзлэх хүүхдийн тоо өндөр байгааг илэрхийлнэ. Тодотговол, хүүхдийн ачаалал жил ирэх тусам нэмэгдэж, 2018 оны байдлаар нийт хүн амын гуравны нэг нь 15 хүртэлх насны хүүхдүүд байна (Зураг 2.2.4б). Цаашид олон тооны залуучууд хөдөлмөрийн зах зээлд хүч түрэн орж ирэх учраас шинэ ажиллах хүчийг шингээх ажлын байрыг хангалттай хэмжээгээр бий болгох шаардлага байна. Түүнчлэн энэ боломжийг ашиглан эдийн засгийг өсгөх, ядуурлыг бууруулахад чиглүүлэн залуучуудад хөрөнгө оруулах, ялангуяа боловсролын чанарыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь чухал юм.

**Зураг 2.2.4** Хүн ам зүйн ачаалал, 2010-2018, хүн амд хүүхдийн эзлэх хувь, 2018




## 2.3. БОЛОВСРОЛ

**Манай улсын боловсролын салбарын хөгжил дэвшилттэй байгаа нь залуучуудын боловсролын түвшин хөрш орнуудтай харьцуулахад хамгийн өндөр байгаагаас харагдана.** Зураг 2.3.1а-д 25, түүнээс дээш настай хүн амыг насны бүлгээр боловсролын түвшингээр харуулав. 45, түүнээс дээш насны иргэдийн 25 хүрэхгүй хувь их, дээд сургууль төгссөн эсвэл түүнтэй адилтгах боловсрол эзэмшсэн байхад дийлэнх нь бүрэн дунд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, тусгай мэргэжлийн дунд сургууль төгссөн байна. Залуу үеийнхэнд их, дээд сургуульд суралцах хандлага нийтлэг байгаа нь өндөр цалин хөлстэй ажилд орох сонирхолтой нь холбоотой байж болох юм. Ялангуяа сүүлийн хорин жилийн хугацаанд их, дээд сургуульд сурах хандлага нэмэгдсээр байна. Тухайлбал, судалгааны 2018 оны дүнгээр 25-29 насны иргэдийн бараг тал хувь нь их, дээд сургууль төгссөн эсвэл түүнтэй дүйцэхүйц боловсрол эзэмшсэн байхад 45-49 насны иргэдийн дөнгөж 20 хувь дээд боловсрол эзэмшсэн байдаг. 2018 оны судалгааны дүнгээр залуучуудын их, дээд сургуульд хамрагдалт 66 хувь байгаа бол Азийн орнуудын дундаж 44 орчим хувь байдаг байна. Энэ нь Зүүн Азийн орнууд дунд дээгүүрт орох үзүүлэлт юм.

Зураг 2.3.1

Боловсролын түвшин<sup>15</sup>, Зүүн Азийн орнуудын их, дээд сургуульд хамрагдалтын хувь, 2018



**Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа ч энэ нь илүү сайн ажлын байраар хангагдах баталгаа болохгүй байна.** Боловсролын салбар дахь хүйсийн ялгаа залуучуудын дунд илүү тод харагдаж байна (Зураг 2.3.1а). Судалгааны 2018 оны дүнгээс харахад 25-29 настай эмэгтэйчүүдийн 70 хувь дээд болон мэргэжлийн боловсролтой, харин эрэгтэйчүүдийн 58 хувь дээрх түвшний боловсролтой байна. Зураг 2.3.2-оос харахад охидууд хөвгүүдийг бодвол удаан хугацаанд суралцаж байгаа нь хөвгүүд эрт хөдөлмөрийн зах зээлд оролцож эхэлдэгтэй холбоотой байж болох юм<sup>17</sup>. Ялангуяа хөдөөгийн малчин өрхөд хөвгүүд багаасаа мал аж ахуйн ажилд оролцдог нь тэдний боловсролын түвшин бүрэн дунд боловсролоор


15 Боловсролын түвшинг ангилахдаа “Мэргэжлийн боловсролд техник мэргэжлийн боловсрол болон тусгай мэргэжлийн дунд боловсролын, “Дээд” боловсролд дипломын дээд, бакалавр, магистр, докторыг хамруулсан.

16 Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд: <https://datacatalog.worldbank.org/dataset/world-development-indicators>

17 ҮСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018 нэгдсэн тайлан, хуудас 228-231

хязгаарлагдах хандлагыг үүсгэж байж болно. Арван найман настнуудыг харвал хөвгүүдийн 37 хувь, охидуудын 22 хувь бүрэн дунд боловсролоос цааш үргэлжлүүлэн суралцаагүй байна. Охидууд хэдийгээр дээд боловсрол эзэмшсэн ч цалин сайтай ажилд орох баталгаа болохгүй байна. 25, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 40 орчим хувь ажиллах хүчнээс гадуур байна (Дэлгэрэнгүй үр дүнг 2.4 хэсгээс харна уу).


**Зураг 2.3.2** Сургуульд хамрагдагчдын бүтэц, насаар, хүйсээр, хувиар, 2018



Эх үүсвэр: ӨНЗЭС 2018

**Ядуу болон ядуу бус хүн амын боловсролын түвшингийн ялгаа дээд боловсрол эзэмшсэн байдлаар илүү тодорхой харагдаж байна.** Дийлэнх ядуу хүмүүс сургуулиас завсардсан эсвэл бүрэн дунд, түүнээс бага боловсролтой байна. Тэдний арван хүн тутмын нэг нь их, дээд сургууль болон түүнтэй ижил түвшний боловсрол олгох сургууль төгссөн байхад хамгийн чинээлэг 20 хувийн хүн амын тал нь дээд боловсролтой байна (Зураг 2.3.3а). Өрхийн тэргүүний эзэмшсэн боловсролын түвшин ядууралтай хамааралтай байгаа нь (Зураг 2.3.3б) сайн боловсрол эзэмших нь тухайн хүний ирээдүйн амьдралд эерэг нөлөө үзүүлэх хамгийн том хөрөнгө оруулалт болохыг илэрхийлж байна.

**Зураг 2.3.3** 25, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин, хувиар, 2018




Эх үүсвэр: ӨНЗЭС 2018

**Амьжиргаа сайтай өрхийн хүүхдүүд бага наснаасаа суралцаж эхэлдэг мөн хувийн сургуульд илүү хамрагдах хандлагатай байна.** Зураг 2.3.4а-аас харахад хамгийн чинээлэг 20 хувийн өрхийн 2-6 настай хүүхдүүдийн 70 хувь нь сургуулийн өмнөх боловсролд (СӨБ) хамрагдаж байгаа бол хамгийн ядуу 20 хувийнхний хувьд энэ үзүүлэлт 50 хүрэхгүй хувьтай байна. Ихэнх хүүхдүүд төрийн өмчийн сургуульд суралцаж байгаа ч чинээлэг эцэг, эхчүүд хүүхдүүдээ хувийн сургуульд сургах болсон хандлага нь хамгийн чинээлэг 20 хувийн өрхийн таван хүүхэд тутмын нэг нь хувийн бага сургуульд суралцаж байгаагаас харагдана (Зураг 2.3.4б). Алслагдсан хөдөө орон нутгийн хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломж хязгаарлагдмал, сургуулийн өмнөх боловсролын байгууллага тэдний амьдарч буй газраас хол зайд байгаа нь бэрхшээл болж байна.

Зураг 2.3.4

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, бага сургуулийн төрлөөр, хувиар, 2018



## 2.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ<sup>18</sup>

**Хөдөө аж ахуйн ялангуяа мал аж ахуй эрхлэлт, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл ядуу хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн гол салбар болж байна.** Хүн амын хамгийн бага хэрэглээтэй 20 хувийн хүн амын хөдөлмөр эрхэлдэг гурван хүн тутмын нэгний үндсэн ажил<sup>19</sup> хөдөө аж ахуйн салбарт, 11.7 хувь нь барилгын салбарт, 10.7 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт ажиллаж байна. Харин хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүн амын 94<sup>20</sup> хувь мал аж ахуй эрхлэх, малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажил эрхэлж байна. Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй хүн амын эзлэх хувь хэрэглээний ялгаатай бүлгүүдэд тогтмол бүүрч байна. Хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн хүн амын 30 гаруй хувь, чинээлэг 20 хувийн хүн амын 15 хүрэхгүй хувь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байв. Өрхүүдийн амьжиргаа сайжирч, хэрэглээ нэмэгдэх тусам хөдөө аж ахуйн салбарт ажиллах нь багасаж, худалдаа, боловсрол, бусад үйлчилгээний салбарт ажиллах хандлага нэмэгдэж байна.

18 Хөдөлмөрийн зах зээлийн албан ёсны статистикийг ҮСХ-ноос зохион байгуулж явуулдаг Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр авна уу. 2018 оны ӨНЭЗС-нд Ажиллах хүчний судалгаатай харьцуулахад хангалттай тооны асуултыг оруулаагүй болно. Тус тайланд ӨНЭЗС-ны хөдөлмөр эрхлэлтийн бүлгийг ядуучууд болон бусад чухал хүчин зүйлийг хөдөлмөрийн зах зээлийн өнцгөөс нь харуулахад ашигласан болно.

19 ӨНЭЗС-ны 2018 оны судалгаанаас үндсэн ажлыг 15, түүнээс дээш настай хүн амын сүүлийн 7 хоногт эрхэлсэн ажил эсвэл сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй ч сүүлийн 12 сард эрхэлсэн гол ажлаар тодорхойлсон.

20 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн



**Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэлтийн байдал хот суурин газар болон хөдөө орон нутагт ялгаатай байна.** Хөдөө нутагт ажиллагчдын 89 хувь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг бол нийслэл хотод 2 орчим хувь тус салбарт ажиллаж, дийлэнх нь худалдаа, үйлдвэрлэл, барилга, бусад үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж байжээ. Харин сумын төвийн нийт ажиллагчдын 80 хувь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажиллаж байна. Тодруулбал, сумын төвийн гурван ажилчин тутмын нэг нь төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний салбарт ажилладаг, таван хүн тутмын нэг нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг байна.

## Хүснэгт 2.4.1

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, хүн амын хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, суурьшлаар, хувиар, 2018

	Улсын дундаж	Хүн амын хэрэглээний тэнцүү 5-н бүлэг					Суурьшил			
		I	II	III	IV	V	Улаан-баатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө нутаг
Хөдөө аж ахуй	24.0	32.5	30.2	25.8	22.4	14.3	1.7	8.0	20.1	88.8
Уул уурхай, олборлох	5.8	5.3	5.1	5.6	5.9	6.6	5.7	8.8	8.2	1.2
Боловсруулах үйлдвэр	7.6	8.9	8.1	7.4	7.1	7.0	11.2	8.5	5.8	0.7
Цахилгаан, ус хангамж	1.9	2.0	1.6	2.0	2.0	1.9	1.7	3.8	2.4	0.1
Барилга	7.4	11.7	8.0	7.1	6.2	5.8	11.2	8.7	4.1	1.2
Худалдаа	13.5	10.7	10.8	11.6	15.5	17.1	19.7	16.4	9.4	1.4
Зочид буудал, зоогийн газар	3.6	4.9	3.9	3.9	3.0	3.0	5.2	4.1	2.9	0.5
Тээвэр	5.8	4.1	5.7	5.6	6.2	6.8	7.6	7.4	5.5	1.0
Санхүү, үл хөдлөх хөрөнгө	2.2	0.8	1.3	2.2	2.7	3.4	3.2	2.0	2.3	0.4
Төрийн удирдлага	7.2	5.2	6.6	7.6	6.9	8.7	7.4	9.5	10.9	1.5
Боловсрол	9.2	5.6	9.2	10.3	9.3	10.4	8.5	10.8	18.2	1.9
Эрүүл мэнд	4.0	2.2	3.1	4.4	4.7	4.6	4.4	5.1	5.4	0.9
Бусад	7.8	6.1	6.3	6.6	8.1	10.5	12.6	7.0	5.0	0.6
Хөдөө аж ахуй	24.0	32.5	30.2	25.8	22.4	14.3	1.7	8.0	20.1	88.8
Аж үйлдвэр, барилга	22.7	27.9	22.9	22.1	21.1	21.3	29.7	29.8	20.5	3.2
Үйлчилгээ	53.4	39.6	46.9	52.1	56.5	64.5	68.6	62.2	59.5	8.0

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

**Аж үйлдвэр болон үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхлэгчдийн дунд хүйсийн ялгаа их байна.** Эмэгтэйчүүд бөөний болон жижиглэнгийн худалдаа, зочид буудал, зоогийн газар, боловсрол, эрүүл мэндийн салбарт түлхүү ажилладаг, эрэгтэйчүүд уул уурхай, барилга, тээвэр гэх мэт биеийн хүчний хөдөлмөр шаардсан салбарт илүү ажиллаж байна. Боловсролын салбарын 75 хувь, эрүүл мэндийн салбарын 81 хувь эмэгтэй ажиллагчидтай бол уул уурхай, барилга, тээврийн салбарын нийт ажиллагчдын 80 гаруй хувийг эрэгтэйчүүд эзэлж байна (Дэлгэрэнгүй үр дүнг хавсралтаас харна уу).

**Залуучууд уул уурхай, барилгын салбарт, ахимаг насныхан хөдөө аж ахуйн салбарт ажиллах хандлага байна.** 50, түүнээс дээш насны ажиллагчдын гурван хүн тутмын нэг хөдөө аж ахуйн салбарт ажилладаг бол 15-29 насны ажиллагчдын 23 хувь нь тус салбарт ажиллаж байна. Ахимаг насны ажиллагчидтай харьцуулбал хөдөлмөр эрхэлж буй залуучууд биеийн хүчний хөдөлмөр шаардсан, их, дээд сургууль төгссөн диплом шаардахгүйгээр хялбар олдох боломжтой барилга, уул уурхайн салбарт ажиллах хандлагатай байна. 15-29 насны залуучуудын 7 хувь нь уул уурхай, 9 хувь нь барилгын салбарт ажилладаг. Уул уурхай, барилгын салбарын нийт ажиллагчдын 30 хувь дээрх насны бүлэгт харьяалагдаж байна (Дэлгэрэнгүй үр дүнг хавсралтаас харна уу).

Хүснэгт 2.4.2

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, хүйсээр, насны бүлгээр, хувиар, 2018

	Улсын дундаж	Хүйс		Насны бүлэг			
		Эрэгтэй	Эмэгтэй	15-29	30-39	40-49	50+
Хөдөө аж ахуй	24.0	26.3	21.3	22.8	20.5	23.4	32.7
Уул уурхай, олборлох	5.8	9.1	2.0	7.1	6.6	5.0	3.7
Боловсруулах үйлдвэр	7.6	7.1	8.2	7.8	8.3	7.7	5.9
Цахилгаан, ус хангамж	1.9	2.4	1.3	1.3	1.8	2.2	2.3
Барилга	7.4	11.6	2.7	9.1	7.7	7.1	5.2
Худалдаа	13.5	11.0	16.5	13.3	13.0	14.3	13.5
Зочид буудал, зоогийн газар	3.6	1.3	6.3	4.6	3.9	3.2	2.5
Тээвэр	5.8	8.8	2.4	4.1	6.5	6.9	5.3
Санхүү, үл хөдлөх хөрөнгө	2.2	1.7	2.9	3.3	2.9	1.2	1.0
Төрийн удирдлага	7.2	7.6	6.7	7.2	8.0	7.2	5.7
Боловсрол	9.2	4.4	14.8	7.4	9.6	10.4	9.2
Эрүүл мэнд	4.0	1.4	6.9	3.8	3.5	4.0	4.8
Бусад	7.8	7.5	8.1	8.1	7.6	7.4	8.1


Хөдөө аж ахуй	24.0	26.3	21.3	22.8	20.5	23.4	32.7
Аж үйлдвэр, барилга	22.7	30.2	14.2	25.3	24.5	22.0	17.1
Үйлчилгээ	53.4	43.6	64.5	51.9	55.1	54.7	50.3

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

**Хөдөлмөрийн зах зээлийн бүтэц 2010-аас 2018 оны хооронд өөрчлөгдөж цалин хөлстэй ажиллагчдын хувь нэмэгджээ.** 2010-аас 2018 онд цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг хүний тоо өссөн байна. Хөдөлмөр эрхлэлтийг бүтцээр авч үзвэл цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг хүн ам <sup>21</sup> пунктээр нэмэгдсэн, үүний дотор хөдөөгийн цалин хөлстэй ажиллагчдын нийт хөдөөгийн ажиллагчдад эзлэх хувь 2010 онд 29 хувь байснаа 2018 онд 39 хувь болж 10 пунктээр өсжээ. Цалин хөлстэй ажиллагчид өссөн гол шалтгаан нь үйлчилгээний салбарт шинэ ажлын байр бий болсонтой холбоотой байж болох юм (Зураг 2.4.1б). Цалин хөлстэй ажиллагчдын бүтцэд бага зэргийн өөрчлөлт оржээ. Тухайлбал, үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо 2010-аас 2018 онд 131<sup>22</sup> мянгаар нэмэгдсэн. Үүнээс худалдаа, төрийн удирдлага, боловсролын салбарт нэмэгдсэн ажиллагчдын тоо энэ хугацаанд нэмэгдсэн нийт ажиллагчдын 40<sup>23</sup> гаруй хувийг эзэлж байна.

Зураг 2.4.1

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, цалин хөлстэй ажиллагчдын тоо, хувиар, 2010-2018



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010- 2018

21 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.

22 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.

23 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.

**Дийлэнх ядуу хүмүүс цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг ч ихэнхдээ үр чадвар бага шаардсан энгийн хөдөлмөр эрхэлж байна.** Хүснэгт 2.4.3-аас харахад ядуу хүн амын 60 орчим хувь хөдөө аж ахуйгаас бусад салбарт, 4 хувь хөдөө аж ахуйн салбарт цалин хөлстэй ажиллаж байна. Хүн амын хэрэглээний түвшин ахих тусам цалин хөлстэй ажиллагчид нэмэгдэж чинээлэг 20 хувийн ажиллагчдын 70 гаруй хувь цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг байна. Цалин хөлстэй ажлыг задалж үзвэл, ядуучууд үр чадвар бага шаардсан энгийн үйлчилгээний ажил хийдэг, харин чинээлэг 20 хувийн ажиллагчдын гуравны хоёр нь мэргэжлийн, техникийн албан тушаалд ажиллаж байна (Зураг 2.4.2а). Хамгийн ядуу 20 хувийн ажиллагчдын жилийн дундаж цалин 3755.0 мянган төгрөг<sup>24</sup>, чинээлэг 20 хувийн ажиллагчдынх 8781.0 мянган төгрөг<sup>25</sup> байгаа нь нэлээн ялгаатай байна<sup>26</sup> (Зураг 2.4.2б).

## Хүснэгт 2.4.3

Хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар, 2018


	Улсын дундаж	Хүн амын хэрэглээний тэнцүү 5-н бүлэг					Ядуурлын байдал	
		I	II	III	IV	V	Ядуу	Ядуу бус
Цалин хөлстэй ажиллагч	64.7	59.2	61.7	64.3	64.4	70.8	59.1	66.3
ХАА-н салбарын ажиллагч	2.0	4.9	2.0	1.6	1.5	0.9	4.1	1.4
Малчин	21.4	26.9	27.8	23.7	20.4	12.6	27.7	19.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	11.0	8.2	8.0	9.6	12.7	14.4	8.3	11.7
Бусад	1.0	1.0	0.5	0.9	1.0	1.3	0.8	1.0

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

Тайлбар: Цалин хөлстэй ажиллагчдыг хоёр төрөлд хуваасан. 1. ХАА-н бус салбарт цалин хөлстэй ажиллагч 2. ХАА-н салбарт цалин хөлстэй ажиллагч. Бусад гэдэгт цалингүй ажиллагчид, газар тариалан эрхлэгчийг оруулан тооцсон.

## Зураг 2.4.2

Цалин хөлстэй ажиллагчид, ажил мэргэжлийн төрлөөр, өрхийн түвшинд цалин хөлстэй ажиллагчдын хувиар, 2018



Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

24 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.


25 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.

26 2018 оны ӨНЭЗС-ны мэдээллийн баазаас тооцсон жилийн дундаж цалин нь судалгаанд хамрагдахаас өмнөх сүүлийн 12 сарын хугацаанд хийсэн ажлын бүх цалин хөлс, үүнд тухайн ажилчны хөдөлмөрийн хөлс, урамшуулал, нэмэгдэл (бэлэн мөнгөөр буюу мөнгөн бус урамшууллын хэлбэрээр авсан) зэргийг оруулж тооцсон нийт мөнгөн дүн юм. Зарим хүмүүсийн хувьд сүүлийн 12 сарын тодорхой хугацаанд хөдөлмөр эрхэлсэн бол тухайн хугацааны цалин хөлстэй орлого жилийн цалингаар тооцогдоно.

**Уул уурхайн салбарт 2016-аас 2018 онд ажлын байр ихээр бий болсон боловч хөрөнгө оруулалт их шаарддаг, нийтэд хүртээмжтэй бус байна.** Уул уурхайн салбар манай улсын экспортын хамгийн том салбар бөгөөд эдийн засгийн өсөлтөд маш их нөлөө үзүүлдэг. 2016-аас 2018 оны эдийн засгийн өсөлтийн 33 хувь уул уурхайн салбараас хамаарч байна. Энэ хугацаанд нийт 62 мянган<sup>27</sup> цалин хөлстэй ажлын байр шинээр бий болсны 17 мянга<sup>28</sup> буюу 27 хувь нь уул уурхайн салбарт бий болжээ (Зураг 2.4.3а). Хэдий уул уурхайн салбар өсөлттэй байдаг ч тус салбар хөрөнгө оруулалт их шаарддаг, бүтээн байгуулалтын ажил дууссаны дараа шинэ ажлын байр бий болгох нь багасдаг. Тус салбарын ажиллагчдын тоо 2010-аас 2018 онд бага зэрэг нэмэгдэж нийт ажиллагчдад эзлэх хувь 5.8 хувь болжээ (Зураг 2.4.3б). Уул уурхайн салбарын ажиллагчдыг ажил мэргэжлээр ангилбал, дийлэнх ажиллагчид машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажил эрхэлж, 17 хувь нь энгийн ажил хийж байна (Зураг 2.4.3в). Уул уурхайн салбарын өсөлтөөс цөөн хүн ашиг хүртсээр, цалингийн орлого нь сүүлийн хоёр жилийн хугацаанд төдийлөн нэмэгдээгүй ядуу ажиллагчид үр өгөөжийг хүртэж чадахгүй үлдэж байна.

Зураг 2.4.3

Цалин хөлстэй ажиллагчдын өсөлт, 2016-2018, уул уурхайн салбарт ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь, 2010-2018, уул уурхайн салбарт ажиллагчдын ажил мэргэжил, 2018




**Ажилгүй, эдийн засгийн идэвхгүй байх нь ядуу амьдрах магадлалыг нэмэгдүүлж байна.** Ажилгүйдлийн түвшин хүн амын хэрэглээний бүлэг бүрд ялгаатай байна (Зураг 2.4.4, Хүснэгт 2.4.4). Хамгийн бага хэрэглээтэй 20 хувийн хүн амын ажилгүйдлийн түвшин 17.3 хувь, чинээлэг 20 хувийнх 4.4 хувь байгаагаас хамгийн ядуу болон чинээлэг бүлгийн хүн амын ажилгүйдлийн түвшинд ялгаа их байгааг харж болно (Хүснэгт 2.4.4). Үүний адилаар, эдийн засгийн идэвхгүй хүн ам болох өндөр настан, оюутан сурагчдын хувь ядуу болон чинээлэг бүлэгт ихээхэн ялгаатай байна. Ядуучуудын мэдлэг, үр чадварын түвшин доогуур байдаг нь хөдөлмөрийн зах зээлд цалин хөлс сайтай ажил олоход хүндрэлтэй байдаг байж болох юм. Орлогогүй буюу ажилгүй, эдийн засгийн идэвхгүй байх нь хэрэглээ багатай байхад нөлөөлж ядууралд өртөх магадлалыг ихэсгэдэг. Хөдөлмөрийн насны (15, түүнээс дээш) ажилгүй иргэдийн 40 хувь, эдийн засгийн идэвхгүй хүн амын 34 хувь ядуу байгаа нь ажил эрхэлж байгаа хүн ам болон өндөр настнуудын ядуурлын түвшингээс харьцангуй өндөр байна (Зураг 2.4.4б).

27 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.

28 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.

Зураг 2.4.4

Хөдөлмөрийн насны хүн амын ядуурлын хамралтын хүрээ, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар, 2018



Эх үүсвэр: ӨНЗЗС 2018

Тайлбар: Тэтгэвэр авагч гэдэгт 60, түүнээс дээш настай; оюутан, сурагчдад аль нэг шатны сургуульд суралцдаг эдийн засгийн идэвхгүй хүн амыг хамруулсан. Идэвхгүй хүн ам гэдэгт тэтгэвэр авагч болон оюутан, сурагчдаас бусад эдийн засгийн идэвхгүй хүн амыг хамруулсан. Улсын дундаж нь 15, түүнээс дээш насны бүх хүн амын хувьд ядуурлын хамралтын хүрээг харуулна.

**Газарзүйн байршлаар авч үзвэл, хөдөө орон нутагт ажиллах хүчний оролцооны түвшин өндөр, ажилгүйдлийн түвшин бага байна.** Хөдөө орон нутгийн дийлэнх ажиллагчид уламжлалт аж ахуй эрхлэгч буюу малчид, газар тариаланчид байгаа бөгөөд малчид жилийн дөрвөн улирлын турш малаа хариулан ажиллаж, амьдарч байна. Иймээс хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин бага, ажиллах хүчний оролцоо өндөр байна. Бусад суурьшилд ажиллах хүчний оролцоо, ажилгүйдлийн түвшин бага зэрэг ялгаатай байна.

Хүснэгт 2.4.4

Ажиллах хүчний оролцоо, хүн амын хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, суурьшлаар, хувиар, 2018<sup>29</sup>

	Улсын дундаж	Хүн амын хэрэглээний тэнцүү 5-н бүлэг					Суурьшил			
		I	II	III	IV	V	Улаан-баатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө нутаг
Ажилгүйдлийн түвшин	9.5	17.3	12.2	9.8	6.7	4.4	9.6	12.8	12.4	3.4
Ажиллах хүчний оролцоо	62.6	60.4	63.4	63.1	61.9	63.5	59.2	61.0	60.9	76.1
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	56.6	50.0	55.7	56.9	57.7	60.7	53.6	53.2	53.3	73.5


Эх үүсвэр: ӨНЗЗС 2018

29 Хөдөлмөрийн насны хүн ам гэдэг нь 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Ажиллах хүчинд хөдөлмөрийн насны сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлсэн эсвэл ажилгүй байгаа бүх хүн амыг, идэвхгүй хүн амд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг, ажиллах хүчний оролцооны түвшинд ажиллах хүчинд оролцож буй хүн амын нийт хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувийг, ажилгүйдлийн түвшинд нийт ажилгүй иргэдийн тоог ажиллах хүчинд оролцож буй нийт хүн амын тоонд харьцуулж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинд хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн тоог хөдөлмөрийн насны нийт хүн амд харьцуулж тус тус тооцсон.

**Ажиллах хүчний оролцоонд хүйсийн ялгаа их байна.** ӨНЭЗС-ны 2018 оны дүнгээр эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 54 хувь, эрэгтэйчүүдийнх 72 хувь байна (Зураг 2.4.5a). Ажиллах хүчний судалгаагаар энэ хандлага ижил, 2018 онд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо хамгийн өндөр түвшин болох 69.5 хувьд хүрсэн, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн хоёр орсон жилд 54 орчим хувьтай хэвээр байна (Ажиллах хүчний судалгаа, 2016-2018). Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо бага байгаа нь хөдөлмөрийн хуваарилалт нөлөөлсөн байж болох юм. Учир нь монгол эмэгтэйчүүд хүүхдээ харах, гэрийн ажлаа хийх өрхийн гол гишүүн байдаг. Хүүхдээ асрах, гэрийн ажил хийх нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжийг бууруулж байдаг (Дэлхийн Банк<sup>30</sup>, 2018). Чинээлэг өрхийн эмэгтэйчүүд хүүхэд асрах, гэрийн ажил хийх үйлчилгээг хөлслөх боломжтойгоос гадна өндөр боловсрол эзэмшсэн байдаг учраас хөдөлмөрийн зах зээлд илүү оролцоотой байх хандлагатай байдаг (Зураг 2.4.5b). Хөдөө орон нутагт амьдарч буй эмэгтэйчүүд хөдөө аж ахуйн ажлыг гэрийн ажилтай хавсран гүйцэтгэх боломжтой байдаг болохоор ажиллах хүчний оролцооны түвшин өндөр байдаг. Эсрэгээрээ үйлдвэр, үйлчилгээний салбар давамгайлсан, ажлын газар нь ихэвчлэн гэрээс нь зайтай байдаг хот суурин газрын эмэгтэйчүүд гэрийн ажлыг үндсэн ажлынхаа хажуугаар хийх боломжгүй байдаг шалтгаанаар ажиллах хүчний оролцооны түвшин бага байна. Хэдийгээр эмэгтэйчүүд ажилтай байгаа ч цалин хөлс багатай үйлчилгээ, худалдаа, төрийн байгууллагад ажиллах хандлага их байна. Эмэгтэй ажиллагчдын жилийн дундаж орлого (5.9 сая төгрөг) эрэгтэй ажиллагчдын дундаж орлогоос (7.0 сая төгрөг) 18 хувиар бага байна<sup>31</sup>.

Зураг 2.4.5

Ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар



## 2.5. МАЛЧИН ӨРХ, МАЛ АЖ АХУЙ

**Мал бол малчдын үндсэн хөрөнгө юм.** Мал аж ахуй хөдөөгийн малчдын амьжиргаанд гол үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, мал аж ахуй нь өрхийн хөдөлмөр эрхлэлтийн гол үйл ажиллагаа, орлого, хэрэглээний гол эх үүсвэр болохоос гадна өрхөд гэнэтийн бэрхшээл тулгарах үед даатгалын хэлбэрээр ашиглах боломж юм. Судалгааны 2018 оны дүнгээр хөдөөгийн хоёр

30 Дэлхийн банк, 2018, "Perceptions of pre cariousness: a qualitative study of constraints underlying gender disparities in Mongolia's labor market"


31 ӨНЭЗС-ны 2018 оны мэдээллийн баазаас тооцсон дүн.

ажиллагчид тутмын нэг нь мал аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байна. Мал аж ахуйтай холбоотой хөдөлмөр эрхлэлт нийслэлээс бусад бүс нутагт өргөн тархсан байна (Зураг 2.5.1a).

**Өмнө нь малчин өрхүүд хамгийн ядуу байсан бол өнөөдөр тэдний гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч байна.** Улсын хэмжээнд 2010 онд малчид хамгийн ядуу байсан бөгөөд тухайн үед малчдын 58.4 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байв. Энэ үеэс малын гаралтай бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, үнэ өсөн, зах зээлийн нөхцөл сайжирч эхэлсэн зэрэг нь тэдний амьжиргааг дээшлүүлсэн, үүн дээр засгийн газрын татаас, нийгмийн хамгааллын шилжүүлгүүд эерэг нөлөө үзүүлсэн байна. Үүний үр дүнд өрхийн тэргүүлэгч нь малчин өрхүүдийн ядуурлын хамралтын хүрээ 2018 онд 33.2 хувь болж 2010-аас 2018 онд 14.8 пунктээр буурчээ (Зураг 2.5.1б).

Зураг 2.5.1

Хөдөлмөр эрхлэлтийн байдал, өрхийн тэргүүлэгч нь малчин өрхийн ядуурлын хамралтын хүрээ, хувиар




**Өрхийн малын тоо амьжиргааны түвшинтэй нь хамааралтай байна.** Зураг 2.5.2а-д үзүүлснээр хүн амын хэрэглээний бүлгүүдэд малын тооны ялгаа байгааг харж болно. Хамгийн ядуу бүлгийн малчин өрхүүдийн 63, хоёр дахь бүлгийн өрхүүдийн 45, хамгийн чинээлэг малчин өрхүүдийн 38 хувь нь 200-аас бага толгой малтай байна. Чинээлэг өрхүүдийн гуравны нэг нь 500-аас дээш толгой малтай байгаа нь тэднийг өргөн хэмжээний мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжтойг илтгэнэ. Манай улсын мал аж ахуйн салбарт хийсэн судалгаагаар 500, түүнээс дээш толгой малтай (Дэлхийн банк, 2009) малчид зах зээлд шаардлагатай малын гаралтай бүтээгдэхүүнийг хурдан үйлдвэрлэж нийлүүлэх боломжтой бол 200-аас цөөн толгой малтай малчид зах зээлд нийлүүлэлт, борлуулалт хийх боломж хязгаарлагдмал, хахир өвөлд (зуд) илүү өртөмтгий байдаг байна.

**Ядуу малчин өрхүүд малыг зах зээлд борлуулахаас илүү өөрсдийн хэрэгцээнд зориулан хадгалах хандлагатай байдаг.** Хамгийн ядуу бүлгийн малчин өрхүүд бусад бүлгийн малчин өрхүүдтэй харьцуулахад малыг цөөн тоогоор нядалж өөрсдийн хэрэгцээнд хэрэглэдэг. Мөн бусад бүлгүүдтэй харьцуулахад цөөн тооны мал борлуулдаг байна. Хамгийн ядуу бүлгийн малчдын борлуулсан малын тоо хамгийн чинээлэг бүлгийн малчдын борлуулсан малын тооноос гурав дахин бага байжээ. (Зураг 2.5.2б). Энэ нь хамгийн ядуу бүлгийн малчин өрхүүд борлуулах хангалттай тооны малгүй, дийлэнх малаа өөрсдийн хэрэглээнд зориулдаг болохыг харуулна.

Зураг 2.5.2

Малчин өрхүүдийн малын тоо, борлуулалт, хэрэглээ, 2018




Тайлбар: Дор хаяж нэг малтай өрхийг хамруулсан.

**Ноолуур нь мал аж ахуйгаас олох орлогын хамгийн чухал эх үүсвэр бөгөөд зах зээлийн үнэлгээ нэмэгдсэн нь хөдөөгийн малчдын орлогын өсөлтөд маш их нөлөө үзүүлжээ.** Манай улсын экспортын гол салбар болох зэс, алтны дараа орох гурав дахь салбар нь түүхий ноолуурын үйлдвэрлэл юм. Ямааны тоо толгой хурдацтай өсөж байгаа нь дэлхийн зах зээл дээрх ноолуурын эрэлт улам бүр нэмэгдэж байгааг илэрхийлж байна (Зураг 2.5.3а). Малчин өрхүүд дунджаар өрхийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын 71 хувийг ноолуурын үйлдвэрлэлээс авдаг<sup>32</sup>. Ноолуурын үнэ 2018 онд маш их өсжээ. 2018 оны хаврын оргил үеэр улсын хэмжээнд ноолуурын дундаж үнэ кг тутамд 90 мянган төгрөгт хүрч, жилийн дундаж үнэ кг тутамд 78 мянган төгрөг болж өссөн нь 2016 оны дундаж үнэтэй харьцуулахад 95 хувиар их байна (Зураг 2.5.3б). Хүн амын хэрэглээний бүлгүүдийн ноолуурын үйлдвэрлэл ялгаатай хэдий ч ноолуурын үнийн өсөлт бүх ноолуур үйлдвэрлэгчдэд ашгаа өгч 2016-аас 2018 онд хөдөөгийн ядуурлыг бууруулж чаджээ. Дэлхийд ноолуурын эрэлт улам бүр нэмэгдэж байгаатай зэрэгцэн хурдацтай өсөж буй ямаан сүрэг бэлчээрийг доройтуулж, малчдын мал аж ахуй эрхлэлт болон амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Зураг 2.5.3

Ноолуурын үнэ, үйлдвэрлэлийн чиг хандлага



32 Өрхийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого нь ноос, ноолуур, хялгас, арьс, шир, сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын нийт дүн бөгөөд өөрийн хэрэглээний үнийг хасаж тооцдог.




## 2.6. ӨРХИЙН УДААН ЭДЭЛГЭЭТЭЙ БАРАА, САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

**Чинээлэг амьдралтай өрхүүд тансаг зэрэглэлийн байранд амьдарч, үнэтэй машин унаж, харин ядуучууд цөөн тооны удаан эдэлгээтэй хөрөнгөтэй байна.** Хүн амын хэрэглээний бүлгүүдийн цахилгаан барааны хэрэглээний түвшин нэмэгдсэн нь манайд цахилгаанаар хангагдсан өрхийн түвшин өндөр байдгийг харуулж байна. Хүн амын хамгийн чинээлэг бүлгийн өрхүүдийн дийлэнх нь хөргөгч, угаалгын машин, будаа агшаагчтай байхын зэрэгцээ талаас илүү хувь нь дор хаяж нэг машин эзэмшдэг нь тэднийг орлогынхоо ихэнх хувийг удаан эдэлгээтэй хөрөнгөнд зарцуулж буйг харуулдаг. Чинээлэг өрхүүдийн удаан эдэлгээтэй хөрөнгийн үнэ (хэрэглээний үнэ) ядуу өрхийнхөөс дунджаар 5 дахин их байна. Харин ядуу өрхүүдийн дийлэнх өнгөт телевизор, тавилга гэх мэт чухал хэрэгцээтэй цөөн хөрөнгөтэй байдаг. Ялангуяа ядуу хүмүүс мотоцикл (15 хувь) болон автомашины (14 хувь) өмчлөл багатай байгаа нь тэднийг удаан эдэлгээтэй бараа худалдан авах хуримтлалгүй, нийтийн тээврийн үйлчилгээнд найддаг болохыг харуулна.

Зураг 2.6.1


Өрхийн удаан эдэлгээтэй хөрөнгө, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, хувиар, 2018



**Чинээлэг өрхүүд боловсронгуй технологи ашиглан мэдээлэл олж авах боломжтой байхад алслагдсан хөдөө нутагт амьдардаг ядуу хүмүүст интернэтэд холбогдох боломж хомс хэвээр байна.** 2010-аас 2018 онд хөдөө амьдарч буй ядуу хүмүүсийн дунд гар утасны хэрэглээ сайжирсан (Зураг 2.6.2). 2010 онд хамгийн ядуу бүлгийн өрхүүд, алслагдсан хөдөө нутагт амьдардаг өрхүүдийн гар утасны хэрэглээ бусдаас бага байсан бол 2018 онд бараг бүх өрх гэртээ дор хаяж нэг гар утастай байна. Гэвч хөдөө орон нутгийн ядуу өрхүүдийн дунд интернэтийн хүртээмж, компьютерийн хэрэглээ, ашиглалт мүү хэвээр байна. 2018 онд хамгийн ядуу бүлгийн өрхийн гурван хувь нь компьютертэй<sup>33</sup>, дөрвөн өрх тутмын нэг нь интернэтэд холбогдсон, харин хамгийн чинээлэг бүлгийн өрхүүдийн гуравны хоёр нь интернэтэд холбогдсон байна. Алслагдсан хөдөө нутгийн иргэдийн интернэтийн үйлчилгээ бусад суурьшлын хүн амаас нэлээн хоцрогдсон байна. Энэ технологийн ялгаа нь хөдөөгийн ядуу хүүхдүүдэд харилцаа холбооны техникийг ашиглан мэдээлэл олж авах, харилцах, суралцах боломжийг бууруулах юм.

Зураг 2.6.2


Мэдээлэл, технологийн хүртээмж, хувиар, 2010, 2018



**Чинээлэг өрхүүд санхүүгийн зах зээлд оролцох, хүүгийн орлого олох, бусад хөрөнгө оруулалтаас өгөөж хүртэх илүү боломжтой байна.** Судалгааны 2018 оны дүнгээр улсын хэмжээнд дөрвөн өрх тутмын нэг нь хадгаламжтай байна<sup>34</sup>. Хамгийн чинээлэг бүлгийн өрхүүд хамгийн ядуу бүлгийн өрхүүдтэй харьцуулахад гурав дахин их хадгаламжтай байна (Зураг 2.6.3а). Хүн амын хэрэглээний тэнцүү таван бүлгийн хадгаламжинд хийсэн мөнгөн дүн ихээхэн ялгаатай байв. Сүүлийн 12 сарын хугацаанд дор хаяж нэг удаа хадгаламжинд орлого хийсэн өрхүүдийн хувьд тооцож үзэхэд хүн амын хамгийн чинээлэг бүлгийн өрхүүд дунджаар 2348 мянган төгрөг хадгалуулсан нь хамгийн ядуу бүлгийн өрхүүдийн хадгалуулсан мөнгөн дүнгээс (1217 мянган төгрөг) бараг хоёр дахин их байна. Манайд санхүүгийн хөрөнгө оруулалт хийдэг өрх цөөхөн байна. Сүүлийн 12 сарын хугацаанд цөөн тооны чинээлэг өрхүүд (4.1 хувь) хөрөнгө оруулалт, санхүүгийн өгөөж хүртжээ (Зураг 2.6.3б).

Зураг 2.6.3


Санхүүгийн орлоготой, хадгаламжтай өрхийн эзлэх хувь, 2018



34 2018 оны ӨНЭЗС нь өрхүүдэд хадгаламж байгаа эсэхийг асуусан боловч санхүүгийн байгууллагуудад хадгаламжийн данс бий эсэхийг асуугаагүй болно.

**Өдөр тутмын хэрэгцээгээ хангахын тулд ядуу хүмүүс бусдаас нэмэлт мөнгө авах, зээлэх шаардлагатай тулгардаг байна.** Зураг 2.6.4а-д нэг хүнд ногдох өдрийн орлого, хэрэглээний улирлын хандлагыг харуулав. Хэрэглээний түвшин орлогоос шууд хамааралтай, ялангуяа 2016 оны эдийн засгийн хямралын дараа ижилхэн хандлагатай болсон байна. Хүн амын хэрэглээний бүлгүүдийн орлого, хэрэглээний харьцааг харахад (Зураг 2.6.4б) хамгийн чинээлэг бүлгийн өрхүүд дунджаар нийт орлогынхоо 60 хувийг хэрэглээндээ зарцуулдаг байв. Өөрөөр хэлбэл тэд орон сууцны ипотекийн зээлгүй бол орлогынхоо үлдсэн хэсгийг хэмнэх боломжтой гэсэн үг юм. Түүнчлэн эдийн засгийн хямралын үед ч тэд хэрэглээгээ хангах боломжтой байна. Нөгөө талаас хүн амын хамгийн ядуу 20 хувьд хамаарах өрхүүд хөрөнгө багатай, санхүүгийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал учраас өдөр тутмын хэрэглээгээ олсон орлогоороо хангах чадваргүй, бусдаас мөнгө зээлэх эсвэл бусад эх үүсвэрээс нэмэлт орлого олох шаардлагатай болдгийг харуулж байна.

Зураг 2.6.4

Хэрэглээ, орлогын харьцуулалт<sup>35</sup>


**Зээлийг бүх өрх, түүний дотор ядуу өрхүүд ч авах боломжтой.** Зээл авсан өрхийн эзлэх хувь жил ирэх тусам нэмэгдсээр, ялангуяа 2012 оноос хэрэгжиж эхэлсэн орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлээс хойш илүү нэмэгджээ (Зураг 2.6.5а). Орон сууцны ипотекийн зээлийн огцом өсөлтийг дагуулан хэрэглээний зээлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлсэн нь сүүлийн хэдэн жилийн хугацаанд хэрэглээний зээл өсөхөд нөлөөлөв.<sup>36</sup> Судалгааны 2012 оны дүнгээр ядуу гурван өрх тутмын зөвхөн нэг нь л зээл авсан бол 2018 онд ядуу хүмүүсийн бараг тал орчим хувь зээлтэй, тэдгээрийн дийлэнх нь албан ёсны санхүүгийн байгууллагаас зээл авсан байна (Зураг 2.6.5б).

35 Манай улсын нийт өрхийн ойролцоогоор 98 хувь өөрийн эзэмшлийн гэр, сууцтай учраас хийсвэр түрээсийн утгыг хасч тооцсон хэрэглээг ашиглан хэрэглээ ба орлогын харьцуулалтыг хийсэн болно. Удаан эдэлгээтэй барааны хэрэглээг хэрэглээний иж бүрдэлд оруулж тооцсон, хэрэв оруулж тооцохгүй тохиолдолд хэрэглээ орлогын харьцаа 1.1 болно. Өөрийн хэрэглээнд орлого, хэрэглээний бүрэлдэхүүнийг аль алиныг багтаасан. Нийт орлогын бүрэлдэхүүнийг 3-р бүлэгт илүү дэлгэрэнгүй тайлбарлав.

36 Жишээ нь, тэтгэврийн зээлийн хүүг зах зээлийн хүүнээс багаар тогтоосон. Дэлгэрэнгүйг "Монголын эдийн засгийн тойм" Дэлхийн Банк (2020 он)-ээс харна уу.

Зураг 2.6.5


Зээлийн хүртээмж



**Хэдийгээр бүх өрхөд зээл авах боломж сайжирсан ч зээлийн төрөл, зээлийн хэмжээ нь хэрэглээний түвшингээс хамааран өөр өөр байдаг.** Тэтгэвэр, малчин, цалингийн зээл<sup>37</sup> нь хамгийн түгээмэл зээлийн төрөл юм. Тодруулбал өндөр настантай (60, түүнээс дээш насны) өрхийн 74-83 хувь нь тэтгэврийн зээлтэй, нийт малчин өрхийн 70 гаруй хувь нь малчны зээлтэй, цалинтай гишүүнтэй өрхийн талаас илүү хувь нь цалингийн зээл авчээ. Эдгээр төрлийн зээл өрхийн амьжиргааны түвшингээс үл хамааран нийтлэг байна. Харин ипотекийн зээл барьцаа хөрөнгөтэй, зээлийн үрт түүхтэй ядуу бус иргэдэд илүү боломжтой байна. Хүн амын хамгийн чинээлэг бүлгийн 21 хувь нь ипотекийн зээлтэй бол хамгийн ядуу бүлгийн өрхүүдийн хувьд энэ тоо ердөө 3 хувь байна (Зураг 2.6.6а). Зээлийн зорилго нь ядуу болон ядуу бус хүмүүсийн хооронд ялгаатай байдаг. Ядуу өрхүүд өрхийн хэрэглээгээ хангахын тулд зээл авдаг бол ядуу бус өрхүүд удаан эдэлгээт хөрөнгө, орон сууц, машин зэрэг хэрэгцээтэй, үлдэцтэй хөрөнгө худалдаж авах зорилгоор зээл авдаг байна. Энэ ялгаа нь өрхүүдийн сүүлийн 12 сарын хугацаанд авсан зээлийн хэмжээгээр илэрхийлэгдэнэ. Тухайлбал, хамгийн чинээлэг бүлгийн өрхүүдийн авсан зээлийн дундаж хэмжээ нь хамгийн ядуу бүлгийн өрхүүдийн авсан хэмжээнээс гурав дахин их байна (Зураг 2.6.6б).

Зураг 2.6.6

Зээлтэй өрхийн эзлэх хувь, зээлийн төрлөөр, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр



37 Тэтгэврийн зээл гэдэг нь арилжааны банкууд тэтгэвэр авагчийнхаа ирээдүйн тэтгэврийг барьцаалан олгосон хэрэглээний зээл юм. Цалингийн зээл гэдэг нь ажилчдын цалингийн суутгалаар эргэн төлөгдөх боломжтой бэлэн мөнгөний урьдчилгаа зээл юм.


## 2.7. ОРОН СУУЦ, СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Орон сууц нь хүний үндсэн хэрэгцээнээс гадна эрүүл, аюулгүй амьдрах орчныг тодорхойлох чухал хүчин зүйл учраас хүмүүсийн сайн сайхан аж байдлын гол үзүүлэлтүүдийн нэг болдог.

**Өрхийн орон сууцны төрөл газарзүйн байршлын хувьд ялгаатай байгаа ч хөдөө орон нутаг, хот суурин газрын ядуу хүмүүсийн дийлэнх нь гэрт амьдарч байна.** Манай улсад сууцны өмчлөлийн түвшин 98<sup>38</sup> гаруй хувьтай байна. Хот суурин газарт ядуу хүмүүсийн дийлэнх нь гэрт эсвэл сууцны тусдаа байшинд амьдардаг (Зураг 2.7.1). Хотын хүн ам чинээлэг болох тусмаа төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдарч байна. Өөрөөр хэлбэл, хотын хүн амын хамгийн чинээлэг бүлгийн арван хүн тутмын долоо нь орон сууцанд амьдардаг бол хамгийн ядуу бүлгийн дөнгөж 6 хувь нь орон сууцанд амьдардаг байна. Хөдөө орон нутагт ихэнх өрхүүд оршин суугаа газар, ажлын байрны байршил хэр алслагдмал эсэхээс хамааран гэрт эсвэл сууцны тусдаа байшинд амьдардаг бөгөөд хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь нэмэгддэг.

Зураг 2.7.1

Сууцны төрөл, хүн амд эзлэх хувиар, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, 2018



**Сайжруулсан үндны усны эх үүсвэр, сайжруулсан ариун цэврийн байгууламж, найдвартай эрчим хүчний эх үүсвэр зэрэг дэд бүтцийн суурь үйлчилгээг үзүүлэх замаар хүн амын амьдралын чанарыг сайжруулж байна.** Сайжруулаагүй үндны усны эх үүсвэр, ариун цэврийн байгууламж нь өрхийн гишүүдийн өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлэх замаар амьжиргаанд нь сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Мөн цахилгаан эрчим хүчний хангамж тогтворгүй, найдваргүй байх нь нар жаргаснаас хойш хүүхдийн сурч боловсрох, насанд хүрэгчдийн гэртээ ажиллах боломжийг хязгаарладаг.

Эдгээр үндсэн гурван үйлчилгээнээс гадна аюулгүй, байнгын халаалтын эх үүсвэр нь манай орны хүйтэн өвлийн улиралд амьдралын чанарыг хадгалах хамгийн чухал үзүүлэлт юм. Суурь үйлчилгээнд хамрагдах нь аюулгүй, эрүүл амьдралын үндэс суурийг тавьж, өрхийн гишүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэх боломжийг сайжруулж өгнө. Хүснэгт 2.7.1-д тус тайланд ашигласан эдгээр үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг нэгтгэн харуулав.

## Хүснэгт 2.7.1

Дэд бүтцийн суурь үйлчилгээний үзүүлэлтийн тодорхойлолт<sup>39</sup>

Үзүүлэлт	Тодорхойлолт
<b>Сайжруулсан үндны усны эх үүсвэр</b>	Усан хангамжийн шугам сүлжээнд холбогдсон төвлөрсөн усны систем, хамгаалалттай худаг, хамгаалалттай булаг шанд, зөөврийн усны үйлчилгээ, хурын ус болон савласан ус ашигладаг өрхүүд
<b>Сайжруулсан ариун цэврийн байгууламж</b>	Бохир усны системд холбогдсон бие засах байгууламж, агааржуулагчтай нүхэн жорлон, био жорлон, битүү тунгаагуур эсвэл цооног (бохир соруулах) ашигладаг өрхүүд
<b>Цахилгаан, эрчим хүчний хүртээмж</b>	Төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон эрчим хүч, дизель, нарны, салхины эрчим хүч эсвэл бага оврын цахилгаан үүсгүүр ашигладаг өрхүүд
<b>Байнгын халаалт, дулааны эх үүсвэр</b>	Төвлөрсөн эх үүсвэр, хувийн бага оврын уурын зуух эсвэл цахилгаан халаах систем ашигладаг өрхүүд


**Манай улсад 2018 онд ядуу арван хүн тутмын ес нь дэд бүтцийн суурь үйлчилгээний аль нэгийг (сайжруулсан үндны ус, сайжруулсан ариун цэврийн байгууламж, дулааны байнгын эх үүсвэр) авах боломжгүй байна.** Улсын хэмжээнд өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангаж чадсан ч (99.8 хувь) ядуу арван хүн тутмын ес нь сайжруулсан ариун цэврийн байгууламжгүй, халаалтын байнгын эх үүсвэргүй, тэдгээрийг ашиглах боломжгүй байна (Зураг 2.7.2). Энэ нь ихэвчлэн тэдний орон сууцны төрөл (гэр), байршлаас (алслагдсан хөдөө орон нутаг эсвэл хотын гэр хороолол) хамааралтай байна. Хүн амын хамгийн чинээлэг бүлгийн хүмүүсийн 40 орчим хувь сайжруулаагүй ариун цэврийн байгууламжтай, уламжлалт халаалтын эх үүсвэртэй байна. Энэ нь эдийн засгийн хувьд баталгаажсан өрхүүд ч чанартай орон сууц, зохих суурь үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байна гэсэн үг юм.

**Гэрт амьдардаг өрхүүдийг сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангах, байнгын халаалтын эх үүсвэртэй байлгахад бэрхшээл тулгарсаар байна.** 2010-аас 2018 онд хүн амын дунд үндны усны баталгаатай эх үүсвэрээр хангагдах явдал аажмаар сайжирч байгаа ч уламжлалт бие засах байгууламжтай, халаалтын эх үүсвэр асуудалтай гэрт амьдардаг хүмүүс байсаар байна. Судалгааны 2018 оны дүнгээр гэрт амьдардаг хүмүүсийн 99 хувь төвлөрсөн халаалт, бохир усны системд холбогдох боломжгүй байна (Зураг 2.7.2).

Тэд нүхэн жорлон, бохирын цооногийг бие засах байгууламжаар, мод, нүүрс, аргал түлдэг энгийн зуух, пийшинг халаалтын зориулалтаар ашиглаж байна. Ялангуяа 350 мянга орчим хүн амьдардаг Улаанбаатар хотын гэр хороололд сүүлийн хорин жилд хөдөө орон нутгаас хотод шилжин ирэгчид ихээр орж ирснээс агаарын, хөрсний бохирдол улам нэмэгдсээр байна. Үүний улмаас Улаанбаатар хотын оршин суугчид, ялангуяа 5-аас доош насны хүүхдүүдэд амьсгалын замын хүнд өвчин тусах магадлал өндөр учраас эдгээр бага насны хүүхдүүдээ агаарын бохирдлоос хамгаалахын тулд зарим эцэг эхчүүд өвлийн улиралд хүүхдүүдээ хөдөө эмээ, өвөө, хамаатан садны хамт амьдруулахаар явуулах үзэгдэл их байна.

39 2018 оны ӨНЗЭС нь Тогтвортой Хөгжлийн Зорилтын тодорхойлсон үзүүлэлтүүдэд бүрэн хариулт өгөх асуултыг асууагүй боловч тус тайланд дурьдсан зарим үзүүлэлтэд тулгуурлан ТХЗ-ын талаарх зарим ойлголтыг үнэлэх боломжтой юм.


**Зураг 2.7.2** Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж, хүн амд эзлэх хувиар, 2018



**Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж аймгуудад ялгаатай байна.** Зураг 2.7.3-т аймгуудын дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмжийг харуулав. Зураг 2.7.3г-д үзүүлсэн сайжруулсан дэд бүтцээр хангагдсан орон сууц нь сайжруулсан ундны усны эх үүсвэр, сайжруулсан ариун цэврийн байгууламж, байнгын дулааны эх үүсвэр бүхий гурван үйлчилгээнд холбогдсон өрхөд амьдарч буй хүн амын эзлэх хувийг харуулсан нийлмэл индекс юм. Нутгийн зарим хэсэгт, ялангуяа Баруун, Хангайн бүсийн аймгууд энэ үзүүлэлтээр бусдаасаа хоцорч байна. Малчид, гэр хорооллын иргэдийн дийлэнх нь дэд бүтцийн суурь үйлчилгээнд хамрагдах хүртээмж хязгаарлагдмал байдаг учраас аймаг бүрд малчид, гэр хорооллын иргэдийн эзлэх хувьтай холбоотойгоор эдгээр дүгнэлтийг гаргасан гэж хэлж болох юм.


**Зураг 2.7.3** Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж, аймгаар, хүн амын эзлэх хувь, 2018

(а) Сайжруулсан ундны усны эх үүсвэр







(б) Сайжруулсан ариун цэврийн байгууламж



(в) Байнгын халаалт



(г) Сайжруулсан дэд бүтцээр хангагдсан орон сууц



Эх үүсвэр: ӨНЭЗС 2018


Тайлбар: Сайжруулсан дэд бүтцээр хангагдсан орон сууц гэдэг нь орон сууцны чанарын шаардлагыг хангах гурван элементийг бүрдүүлсэн өрх гэж ойлгоно (сайжруулсан үндны усны эх үүсвэр, сайжруулсан ариун цэврийн байгууламж, байнгын халаалтын шийдэл). Монгол улсад нийт хүн амын 99 гаруй хувь нь цахилгаан эрчим хүчээр хангагдсан байна.



# 3 БҮЛЭГ

## ОРЛОГО, ТҮҮНИЙ ЯДУУРЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Хот, хөдөөгийн хүн амын орлогын эх үүсвэр ялгаатай байна.



**Хотын** хамгийн бага хэрэглээтэй 20 хувийнхны бодит орлого 2016-2018 онд бусад бүлэгтэй харьцуулахад **буурсан** бол (-1.0 хувь) **хөдөөгийнх** хамгийн өндөр хувиар (3.8 хувь) **өссөн** байна.



**-1.0%**

Хотод цалин хөлс болон ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого буурсан нь нөлөөлжээ.



**3.8%**

Хөдөөд ХАА-н үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүний үнэ өссөн нь голлон нөлөөлжээ.

Ядуурал буурахад 2010-2014 онд бүх төрлийн орлого нөлөөлж байсан бол 2016-2018 онд зөвхөн хөдөө аж ахуйн орлого, нийгмийн хамгааллын шилжүүлэг болон мөнгөн шилжүүлгийн орлого нөлөө үзүүлжээ.

### Орлогын бүрэлдэхүүн хэсгүүдийн ядуурлын өөрчлөлтөд үзүүлж буй нөлөө

	2010-2014		2016-2018	
	Пункт	Өөрчлөлт	Пункт	Өөрчлөлт
Цалин хөлсний орлого	-7.4	↓	0.5	↑
ХАА-н орлого	-5.7	↓	-0.8	↓
ХАА-н бус орлого	-1.1	↓	0.1	↑
Нийгмийн хамгааллын шилжүүлгийн орлого	-3.4	↓	-1.3	↓
Хөрөнгийн орлого	-0.1	↓	0.8	↑
Мөнгөн шилжүүлгийн орлого	-0.1	↓	-0.2	↓

Энэ бүлэгт өрхийн орлогын эх үүсвэрт үндэслэн ядуурлын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар онцгойлон тусгав. ӨНЭЗС нь өрхийн орлогын бүрэлдэхүүн хэсгийн талаар мэдээлэл цуглуулдаг. Эдгээр мэдээлэл нь өрхийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрүүд ядуурлыг бууруулахад хэрхэн нөлөөлсөн талаар илүү сайн ойлгох боломжийг бий болгож байгаа юм.

### 3.1 ӨРХИЙН ОРЛОГЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ, ТҮҮНИЙ ХАНДЛАГА

ӨНЭЗС-аас өрхийн орлогын бүтцийг дараах зургаан ангилалд хувааж шинжиллээ (Хүснэгт 3.1.1). Үүнд: (1) цалингийн орлого (2) хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого (3) хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого<sup>40</sup> (4) нийгмийн хамгааллын шилжүүлэг (5) капитал хөрөнгийн орлого (6) мөнгөн гуйвуулга болно. Цалин, хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого тухайн өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны үр дүнд бий болдог. Цалинд сүүлийн 12 сарын хугацаанд мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр авсан бүх цалин, нэмэгдэл хөлс, шагнал, урамшууллыг оруулж тооцов. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогыг худалдсан болон өрхийн хэрэгцээнд хэрэглэсэн<sup>41</sup> бүтээгдэхүүний нийт мөнгөн дүнгээс материал, тоног төхөөрөмжид зарцуулсан зардал, хөдөлмөрийн хөлсийг хасаж цэвэр дүнгээр тооцов. Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлогыг нийт орлогоос нийт зардлыг хасаж цэвэр ашгаар тооцов. Хөдөлмөрийн орлогын эдгээр гурван хэлбэр харилцан хамааралтай боловч өрхийн гишүүд дээрх хугацаанд олон төрлийн ажил эрхэлсэн байж болох юм. Хөдөлмөрийн бус орлого нь капитал хөрөнгийн орлого, мөнгөн гуйвуулга, нийгмийн хамгааллын шилжүүлгээс бүрдэнэ. Сүүлийн 12 сард олсон бүх орлогыг өрхийн түвшинд нэгтгэв.

#### Хүснэгт 3.1.1

#### Өрхийн орлогын бүрэлдэхүүн хэсэг

	Орлогын ангилал	Тодорхойлолт
<b>Хөдөлмөрийн орлого</b>	Цалингийн орлого	Өрхийн хөдөлмөр эрхэлдэг бүх гишүүдийн мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр авсан цалин, нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал
	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Мал, малын гаралтай бүтээгдэхүүн, газар тариалангаас олсон өрхийн цэвэр орлого. Газар тариалан болон мал аж ахуйн бүтээгдэхүүнээсээ өрхийн хэрэгцээнд хэрэглэсэн дүнг оруулж тооцсон.
	Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого	Хөдөө аж ахуйн бус өрхийн бизнесээс олсон цэвэр орлого
<b>Хөдөлмөрийн бус орлого</b>	Нийгмийн хамгааллын шилжүүлэг	Тэтгэвэр, ажилгүйдлийн тэтгэмж, хүүхдийн мөнгө, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж зэрэг бусад шилжүүлэг
	Капитал хөрөнгийн орлого	Өөрийн хөрөнгийг түрээслэх замаар олсон орлого, хүүгийн орлого, хувьцааны ногдол ашиг, бондын өгөөж
	Мөнгөн гуйвуулга	Өрхийн бус гишүүдээс гуйвуулсан мөнгөн шилжүүлэг, бэлэг

**Хот, хөдөөгийн өрхийн орлогын эх үүсвэр ихээхэн ялгаатай байгаа ч хөдөө орон нутагт цалинтай ажиллагчдын тоо нэмэгдсээр байна.** 2018 онд хот суурин газрын арван өрх тутмын долоогоос илүү нь цалинтай хөдөлмөрийн үйл ажиллагаанаас орлого олсон бол хөдөө орон нутгийн таван өрх тутмын хоёр нь цалингийн орлоготой байжээ. Хөдөөгийн өрхийн ойролцоогоор гуравны хоёр нь мал аж ахуй, газар тариалан болон хөдөө аж ахуйн бусад үйл ажиллагаанаас орлого олдог байхад хотын арван өрх тутмын зөвхөн нэг нь л мал аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагаанаас орлоготой байна (Зураг 3.1.1а). Орлогын эх үүсвэрийн энэ ялгаа

40 Тогтмол орлого биш учраас удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүн худалдан авах, борлуулах, хөрөнгө өвлөх, хуримын бэлэг, хөрөнгө оруулалт, мөрийтэй тоглоом, сугалаанд хожих зэргээр олсон орлогыг өрхийн орлогын бүтцээс хасч тооцсон болно.


41 Өрхийн хэрэгцээнд хэрэглэсэн бүтээгдэхүүний нэгжийн үнийг тооцохдоо тухайн бүтээгдэхүүний үнийн мэдээлэл аймгийн түвшинд зургаагаас бага тохиолдолтой байвал аймгийн түвшний эсвэл үндэсний түвшний голч үнийг ашиглан тооцов.

олон жилийн түршид багасаж ирсэн нь цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж буй хөдөөгийн өрхийн тоо нэмэгдсэнтэй холбоотой юм (Зураг 3.1.1б). 2010 онд хөдөөгийн цалин хөлсний орлоготой өрхийн эзлэх хувь дөнгөж 35 хувь байснаа өсөж, 2018 онд 44 хувьд хүрчээ. Мөн 2010 онд хөдөөгийн өрхийн 75 хувь мал аж ахуйн үйл ажиллагааны орлоготой байсан бол 2018 онд 63 хувь болж буурсан байна. Энэ нь хөдөө орон нутагт цалинтай хөдөлмөр эрхэлдэг гишүүнтэй өрхийн тоо нэмэгдсэнийг харуулж байна.

**Хот, хөдөөгийн ихэнх өрхөд нийгмийн хамгааллын шилжүүлэг хүрч чаджээ.** Манай улс нийт төсвийнхөө нэлээд хувийг нийгмийн хамгааллын шилжүүлгийн хөтөлбөрүүдэд хуваарилж ирсэн. Засгийн газар 2018 онд ДНБ-ий ойролцоогоор хоёр хувийг нийгмийн халамжид мөн хоёр хувийг нийгмийн даатгалын хөтөлбөрүүдэд зарцуулсан байна. Ядууралд чиглэсэн хөтөлбөрүүдийн хамрах цар хүрээг өргөжүүлэхэд тодорхой ахиц гарсан ч одоо хэрэгжиж буй нийгмийн хамгааллын олон хөтөлбөр нийтийг хамарсан эсвэл тодорхой бүлгүүдэд чиглэсэн хэвээр байна. Өрхийн хүлээн авсан нийгмийн хамгааллын шилжүүлгийн хэмжээ өрхийн хэрэглээний түвшингээр ялгаатай байгаа ч улсын хэмжээнд нийт өрхийн 85 хувь нийгмийн хамгааллын шилжүүлгийн хөтөлбөрүүдээс тодорхой хэмжээний бэлэн мөнгө хүлээн авсан байжээ (Зураг 3.1.1 а).

Зураг 3.1.1

Өрхийн орлогын хуваарилалт, хувиар




**Манай улсын хувьд өрхийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэр төдийлөн олон төрөлтэй биш боловч хөдөө орон нутагт зарим өвөрмөц ялгаа ажиглагдаж байна.** Зураг 3.1.2-д сүүлийн 12 сарын хугацаанд өрхүүд орлогын хэдэн эх үүсвэртэй байсныг харуулав.<sup>42</sup> Хөдөлмөрийн орлогын аль нэг эх үүсвэрээс (цалин, хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйл ажиллагааны орлого гурвын аль нэг) хамааралтай өрхүүд нийт өрхийн 70 орчим хувийг эзэлж байгаа нь харьцангуй тогтвортой байна (Зураг 3.1.2а). 2018 онд нийт өрхийн тал хувь нь цалин хөлстэй ажлын орлогоос, 15.8 хувь нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос, 5.5

42 Жилийн хугацаанд тухайн хүн цалинтай олон ажил хийсэн эсвэл олон салбарт ажилласан байж болох ч 2018 оны ӨНЭЗС-ны хөдөлмөр эрхлэлтийн бүлгийн асуултын бүтэц нь цалинтай ажлыг үйл ажиллагаагаар нь төрөлжүүлж шинжлэх боломжийг олгосонгүй. Тус тайланд өрхийн түвшин дэх хөдөлмөр эрхлэлтийн орлогыг дараах гурван төрлөөр хувааж тооцсон. Үүнд: (i) цалин (ii) хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого (iii) хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого

хувь нь хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос хамааралтай байв. Ерөнхийдөө нийт өрхийн дөнгөж 16.4 хувь олон төрлийн ажлыг давхар хийж орлого олдог (түхайлбал: цалин хөлстэй ажил+хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ; цалин хөлстэй ажил+хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээ; хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ+хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээ гэх мэтчилэн орлогыг хослуулдаг) бөгөөд орлогын эх үүсвэрийн энэ хэлбэр хэрэглээний тэнцүү таван бүлгийн хувьд нийтлэг байна. Хөдөөгийн өрхүүд олон төрлийн ажил эрхлэх замаар орлогоо бүрдүүлэх хандлагатай байна. Хөдөөгийн өрхийн 18.1 хувь нь цалин хөлстэй ажил ба хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний аль алинаас орлого олж байна (Зураг 3.1.2б). Өөрөөр хэлбэл хөдөөгийн малчин өрхийн 12 хувь цалин хөлстэй ажилтай нэгээс доошгүй өрхийн гишүүнтэй гэсэн үг. Нийт өрхийн 14.7 хувь нь хөдөлмөрийн бус орлогын эх үүсвэрээс олсон орлогоосоо хамааралтай амьдарч байгаа бөгөөд үүнд мөнгөн гуйвуулга, капитал хөрөнгийн орлого, тэтгэвэр болон бусад нийгмийн хамгааллын шилжүүлгүүд багтдаг. Хүн амын хамгийн чинээлэг 20 хувийн өрхүүдийн 17 хувь нь, хамгийн ядуу 20 хувийн өрхүүдийн 13 хувь нь хөдөлмөрийн бус орлоготой байна.

Зураг 3.1.2

Өрхийн орлогын эх үүсвэр, хувиар




**Хөдөлмөр эрхэлж олсон орлого хэрэглээний таван бүлгийн хүн амын хувьд ихээхэн ялгаатай байна.** Хүн амын хамгийн чинээлэг 20 хувийн өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь ядуу 20 хувьд хамаарах өрхийн нэг хүнд ногдох сарын орлогоос 6 дахин их байна. Хүн амын хамгийн чинээлэг 20 хувь нийт орлогын 40 гаруй хувийг, харин хамгийн ядуу 20 хувь 7 хүртэлх хувийг бүрдүүлж байна. Хүүхдийн мөнгө, нийгмийн хамгааллын шилжүүлгээс бусад орлогын бүлэгт хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны олж буй орлого хамгийн өндөр байна. Энэ шинжилгээнд нийгмийн хамгааллын шилжүүлгийг хүүхдийн мөнгө, тэтгэвэр болон бусад нийгмийн хамгааллын шилжүүлэг гэж гурав ангилав. Бага орлоготой өрхүүд олон хүүхэдтэй байх

хандлагатай учраас сар бүр олгодог хүүхдийн мөнгөний хөтөлбөрөөс орлоготой байх магадлал өндөр байна. Харин цөөн ам бүлтэй ч өрхийн өндөр настай гишүүний нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэл өндөр байсан байх магадлалтай учраас хамгийн чинээлэг бүлгийн өрхүүдийн нэг хүнд ногдох тэтгэврийн хэмжээ ядуучуудын авдаг тэтгэврийн хэмжээнээс илүү өндөр байна (Зураг 3.1.3в). Чинээлэг айл өрхүүд санхүүгийн хөрөнгөтэй байх магадлал өндөр, хөрөнгө оруулалтын боломжуудад илүү ойр учраас хүн амын хамгийн чинээлэг 20 хувьд хамаарах өрхүүд капиталын хөрөнгө оруулалтаас ашиг хүртэх нь илүү байна. Харин бусад бүлгүүдэд хөрөнгө оруулалт хийх мөнгө үлдэх нь тун бага юм. Сонирхолтой нь хамгийн чинээлэг 20 хувьд хамаарах өрхүүд бусад өрхүүдтэй харьцуулахад илүү их шилжүүлэг (мөнгөн гуйвуулга) хүлээн авдаг байна.

Зураг 3.1.3

Нэг хүнд ногдох сарын дундаж орлого, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, 2018



**Хөдөөгийн өрхийн орлогын 40 хувийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, хотын өрхийн орлогын 60 орчим хувийг цалингийн орлого бүрдүүлж байна<sup>43</sup> (Зураг 3.1.4).** Хөдөө, хотын аль алинд өрхийн нийт орлогын 70 гаруй хувийг хөдөлмөрийн орлого эзэлж байна. Бидний таамаглаж байсанчлан хөдөө орон нутагт мал аж ахуйгаас олох орлогын эзлэх хувь (нийт орлогын 40 хувь) хот суурин газрынхаас (нийт орлогын 2 хувь) харьцангуй өндөр байна. Хотын өрхүүдэд цалингийн орлого нь орлогын хамгийн чухал эх үүсвэр төдийгүй өрхийн нийт орлогын 60 хувийг эзэлж байна. Хот суурин газарт хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон орлогын эзлэх хувь хөдөө орон нутгийнхаас өндөр байгаа нь хувиараа бизнес эрхэлдэг хувь хүмүүсийн 80 орчим хувь хотод амьдардагтай холбоотой юм.


**Хөдөлмөрийн орлого өрхийн орлогын гол эх үүсвэр боловч нийгмийн хамгааллын шилжүүлэг нь ялангуяа ядуу өрхийн орлогод ихээхэн нэмэр болдог байна.** 2018 онд ядуу хүмүүсийн нийгмийн хамгааллын шилжүүлгийн орлого өрхийн нийт орлогын гуравны нэгийг эзэлж байсан нь хүн амын чинээлэг 20 хувиас 15 пунктээр өндөр байна. Шимтгэлгүй нийгмийн хамгааллын шилжүүлгийн хөтөлбөрүүдээс хүлээн авч байгаа дундаж мөнгөн дүн (хүүхдийн мөнгө болон бусад нийгмийн хамгааллын шилжүүлэг) хэрэглээний бүх бүлгүүдэд ижил байна (Зураг 3.1.3в). Гэвч ядуу өрхүүдийн нийт орлого харьцангуй бага учраас эдгээр шимтгэлгүй

43 Өрхийн орлогын дүнд эзлэх хувь хэмжээг орлогын бүрэлдэхүүн тус бүрээс олсон дундаж орлогыг нийт дундаж орлогод хуваан тооцсон болно.

нийгмийн хамгааллын шилжүүлэг хамгийн ядуу 20 хувийн өрхийн орлогын нэлээд хувийг (25 хувь) эзэлж байна (Зураг 3.1.4). Гэтэл энэ шилжүүлэг хүн амын хамгийн чинээлэг 20 хувьд хамаарах өрхийн нийт орлогод дөнгөж 4 хувийг эзэлж байна.

Зураг 3.1.4

Өрхийн дундаж орлого, дүнд эзлэх хувиар, 2018



**Орлогын өсөлтийн түвшин, хэв шинжийн 2010-аас 2014 оны үр дүнг 2016-аас 2018 онтой харьцуулахад эрс ялгаатай байна.** 2010-аас 2014 онд нэг хүнд ногдох орлогын өсөлтийн түвшин 2016-аас 2018 оныхоос харьцангуй өндөр байв (Хүснэгт 3.1.2). Цалин болон хөдөө аж ахуйн үйл ажиллагааны орлого нийт орлогын өсөлтөд голлон нөлөөлжээ. Ялангуяа 2010-аас 2014 онд хэрэглээний бүх бүлэг дэх хөдөөгийн өрхүүдийн цалин, хөдөө аж ахуйн үйл ажиллагааны орлого хоёр оронтой тоогоор нэмэгджээ. Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн цар хүрээг 2010-аас 2012 оны хооронд өргөжүүлснээр өрхийн орлогод нийгмийн хамгааллын шилжүүлгийн өсөлт нэмэгджээ. Гэвч 2016-аас 2018 оны хооронд өрхийн орлогын өсөлт буурч ялангуяа хот суурин газарт амьдардаг хүн амын хамгийн ядуу 20 хувьд хамаарах өрхүүдэд хүнд туссан байна. Сүүлийн жилүүдэд нэг хүнд ногдох орлогын өсөлт хөдөөд 2010-аас 2014 оныхтой харьцуулахад харьцангуй доогуур байсан ч хотод амьдарч буй өрхүүдтэй харьцуулахад орлогын ихэнх бүрэлдэхүүн хэсэгт тогтвортой өсөлтийг үзүүлж чаджээ.

## Хүснэгт 3.1.2

Нэг хүнд ногдох орлогын жилийн нийт өсөлтийн хувь (ЖНӨХ), хот, хөдөөгөөр, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр

## (а) Хот

Хэрэглээний бүлэг	2010-2014					2016-2018				
	Нийт орлого	Цалин	ХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээ	ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ	Нийгмийн хамгааллын шилжүүлэг	Нийт орлого	Цалин	ХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээ	ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ	Нийгмийн хамгааллын шилжүүлэг
I	4.5	7.3	na	-11.8	5.1	-1.0	-0.2	na	-6.4	2.9
II	6.0	7.9	na	-2.0	6.7	1.6	4.4	na	-15.2	3.0
III	9.2	10.2	na	6.6	6.7	1.7	0.8	na	-1.0	2.5
IV	8.5	11.3	na	-2.3	8.4	1.8	-1.5	na	12.3	3.1
V	6.2	12.1	na	-9.4	7.1	1.7	-3.1	na	10.1	4.0
<b>Нийт</b>	<b>7.0</b>	<b>10.5</b>	<b>na</b>	<b>-5.2</b>	<b>6.9</b>	<b>1.4</b>	<b>-0.8</b>	<b>na</b>	<b>4.5</b>	<b>3.2</b>

## (б) Хөдөө

Хэрэглээний бүлэг	2010-2014					2016-2018				
	Нийт орлого	Цалин	ХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээ	ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ	Нийгмийн хамгааллын шилжүүлэг	Нийт орлого	Цалин	ХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээ	ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ	Нийгмийн хамгааллын шилжүүлэг
I	10.2	16.5	12.0	-2.0	2.8	3.8	5.4	3.6	13.3	8.1
II	11.8	23.0	12.3	1.4	2.7	3.4	7.9	0.2	-9.6	7.9
III	11.2	10.7	14.9	-1.0	6.2	3.7	4.5	0.5	0.7	11.3
IV	11.7	8.1	16.7	1.1	7.2	3.2	-4.7	8.5	5.3	6.6
V	11.7	4.9	22.2	0.2	11.6	1.0	-3.7	7.8	-6.5	2.2
<b>Нийт</b>	<b>11.5</b>	<b>9.5</b>	<b>16.7</b>	<b>0.2</b>	<b>6.8</b>	<b>2.6</b>	<b>-0.2</b>	<b>4.8</b>	<b>-2.2</b>	<b>6.5</b>

Эх үүсвэр: ӨНЗЭС 2010-2018

## 3.2 ЯДУУРЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Ядуурлын өөрчлөлтөд нөлөөлж буй орлогын талаарх бүтцийн шинжилгээ хийх нь ядуурлын бууралтад орлогын ямар эх үүсвэр нөлөөлж байгааг ойлгоход бидэнд тус болдог.<sup>44</sup> Энэ хэсэгт ядуурлыг бууруулахад хөдөлмөрийн болон хөдөлмөрийн бус орлогын бүрэлдэхүүн хэсэг тус бүр хэрхэн нөлөөлж байгааг харууллаа. Энэ хэсэгт 2010-аас 2014 ба 2016-аас 2018 гэсэн цаг хугацаанд ядуурлын өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар бүтцийн шинжилгээ хийж харьцуулсан болно.


**2016-аас 2018 онд цалин хөлс, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого, капитал хөрөнгийн орлого буурснаар ядуурлыг нэмэгдүүлсэн бол нийгмийн хамгааллын шилжүүлэг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын өсөлт ядуурал буурахад нөлөөлжээ.** Энэ хугацаанд нийгмийн халамжийн шинэ хөтөлбөр, шинэ тэтгэмжийг нэвтрүүлж, тухайн үед хэрэгжиж байсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн

44 Ядуурлын өөрчлөлтөд бүтцийн шинжилгээ хийхдээ Баррос (2006) ба Азевед (2013) нарын боловсруулсан аргачлалыг ашиглав. Энэ арга нь хүн ам зүй, хөдөлмөрийн орлого (цалинтай ажил, хөдөө аж ахуйн ба хөдөө аж ахуйн бус үйл ажиллагааны орлого) болон хөдөлмөрийн бус орлогод (нийгмийн хамгааллын шилжүүлэг, мөнгөн гүйвүүлгэ, капитал хөрөнгөөс олох орлого гэх мэт) гарч буй өөрчлөлтөөс ядуурлыг бууруулахад нөлөөлж буй хүчин зүйлийг олж тогтоох боломжийг олгодог ба тохиолдол бүрт эдгээр хүчин зүйлийн аль нэгийг өөрчилж бусдыг нь тогтмол байхаар тооцдог. Давхардал үүсэхээс сэргийлж ядуурлын өөрчлөлтөд нөлөөлж буй хувийг тооцоолохдоо бүрэлдэхүүн хэсэг тус бүр дээр Шлаглей-Шоррокс тооцооллын аргыг ашиглав. Бүтцийн шинжилгээний аргын талаар дэлгэрэнгүй судлахыг хүсвэл Азеведа (2013) болон Инхаусте (2014) нарын аргачлалыг харна уу.

тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн нь ядуурал буурахад эергээр нөлөөлжээ. Тухайлбал, ядуурлыг бууруулахад чиглэсэн хүнсний талон хөтөлбөрийн хамрах хүрээг хоёр дахин нэмэгдүүлж, тэтгэмжийн хэмжээг 2016-аас 2018 оны хооронд 20 хувиар нэмэгдүүлсэн байна. Мөн гурваас доош насны хүүхэдтэй эхчүүдэд олгох мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийг шинээр нэвтрүүлжээ. Улмаар нийгмийн хамгааллын шилжүүлгүүд нь дангаараа ядуурлын хувь хэмжээг 1.3 пунктээр бууруулсан байна (Зураг 3.2.1a). Энэ хугацаанд хөдөө орон нутагт мал аж ахуйн салбараас олох орлого нэмэгдсэн нь ядуурал буурахад эергээр нөлөөлсөн өөр нэг хөдөлгөгч хүч байсан ба ядуурлыг 0.8 пунктээр бууруулж чаджээ. Өрхийн орлогын эх үүсвэрийн энэ хоёр бүрэлдэхүүн хэсэг ядуурлын хамралтыг 2.1 пунктээр бууруулав. Нөгөө талаар цалин хөлс, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээ, капитал хөрөнгөөс олох орлого саарсан байна. Капитал хөрөнгөөс олох орлого ядуу өрхийн нийт орлогод маш бага хувийг эзэлдэг боловч энэ төрлийн орлого буурсан нь ядуурал өсөхөд ихээр нөлөөлжээ. Мөн өрхийн нийт орлогын дийлэнх хувийг эзэлдэг цалин хөлсний бодит орлого (өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад -1.1 хувь) буурсан нь ядуурлыг нэмэгдүүлэх бас нэгэн хүчин зүйл болсон бөгөөд ядуурлын хамралтыг 0.5 пунктээр нэмэгдүүлжээ. Гэвч ядуурлыг нэмэгдүүлсэн эдгээр хүчин зүйлийг нийгмийн хамгааллын шилжүүлэг, хөдөө аж ахуйгаас олсон орлогын өсөлтөөр нөхөж чадсан тул 2016-аас 2018 оны хооронд ядуурлын хамралт бага зэрэг буурчээ.

Зураг 3.2.1

Ядуурлын өөрчлөлтийн бүтцийн шинжилгээ, орлогын бүрэлдэхүүн хэсгээр, пунктээр



**Эсрэгээрээ 2010 оны үеэс өрхийн цалингийн орлого сайн байсан учраас ядуурлыг бууруулах гол хүчин зүйл болж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, нийгмийн хамгааллын шилжүүлэг нь хоёр дахь хүчин зүйлсэд тооцогдож байв.** Шинжилгээний дүнгээр 2010-аас 2014 онд нэлээд ялгаатай дүр зураг ажиглагдсан юм. Энэ хугацаанд ядуурал 17.2 пунктээр буурсан ба хүн ам зүй, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн бус орлогын бүх бүрэлдэхүүн хэсгүүд ядуурлыг буурахад эергээр нөлөөлжээ (Зураг 3.2.1б). Ялангуяа 2016-аас 2018 оны нөхцөл байдалтай харьцуулахад энэ хугацаанд ядуурлын бууралтад цалингийн орлого хамгийн чухал хөдөлгөгч хүч байсан бөгөөд ядуурлын хамралтыг 2010-аас 2014 оны




хооронд дангаараа 7.4 пунктээр бууруулсан байна. Энэ үед мал аж ахуйн орлого, нийгмийн хамгааллын шилжүүлэг нь ядуурлыг бууруулах хоёр дахь, гурав дахь хүчин зүйлст тооцогдож мал аж ахуйн орлого ядуурлын хамралтыг 5.7, нийгмийн хамгааллын шилжүүлэг 3.4 пунктээр бууруулсан байна.

**Ядуурлыг бууруулахад орлогын ямар эх үүсвэр гол үүрэг гүйцэтгэж байгаа нь хот, хөдөөд ялгаатай байна.** Зураг 3.2.2а-д үзүүлснээр 2016-аас 2018 оны хооронд хөдөө орон нутагт мал аж ахуйн орлого ба нийгмийн хамгааллын шилжүүлгийн орлого ядуурлын түвшинг тус бүр 1.8 пунктээр бууруулсан мөн цалин хөлс, мөнгөн гуйвуулгын орлого нэмэгдсэний нөлөөгөөр хөдөө орон нутаг дахь ядуурлын хамралт 4.1 пунктээр буурчээ. Харин хот суурин газарт хөдөлмөрийн орлого багассаны улмаас ядуурал буурахад сөргөөр нөлөөлж, зөвхөн нийгмийн хамгааллын шилжүүлэг, мөнгөн гуйвуулгын орлого ядуурлыг тус бүр 0.3 ба 0.8 пунктээр бууруулсан байна. 2010-аас 2014 онд (Зураг 3.2.2б) цалингийн өсөлт хот суурин газарт ядуурал буурахад их хувь нэмэр оруулсан бол мал аж ахуйгаас олох орлогын өсөлт хөдөөд ядуурлыг бууруулахад гол хөдөлгөгч хүчин зүйл болсон нь тодорхой байна. Энэ хугацаанд нийгмийн хамгааллын шилжүүлгийн хөтөлбөрүүд эрчимтэй өргөжсөн ч цалин хөлс, мал аж ахуйгаас олох орлого нийгмийн хамгааллын шилжүүлгийн хөтөлбөрүүдтэй харьцуулбал ядуурлыг буурахад илүү их хувь нэмэр оруулжээ. Энэ үр дүн Хүснэгт 3.1.2-т харуулсан орлогын өсөлтийн хувьтай ижил хандлагатай байна.

Зураг 3.2.2

Ядуурлын өөрчлөлтийн бүтцийн шинжилгээ, орлогын бүрэлдэхүүн хэсгээр, улс дундаж, хот, хөдөөгөөр



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Adams, Richard Jr. 2004. "Economic Growth, Inequality and Poverty: Estimating the Growth Elasticity of Poverty." *World Development*, Elsevier, vol. 32(12), 1989-2014.
- Azevedo, Joao Pedro; Inchauste, Gabriela; Olivieri, Sergio; Saavedra, Jaime; Winkler, Hernan. 2013. "Is labor income responsible for poverty reduction? a decomposition approach". Policy Research working paper; no. WPS 6414. Washington, DC: World Bank.
- Barros, Ricardo Paes, Mirela de Carvalho, Samuel Franco, and Rosane Mendonça. 2006. "Uma Análise das Principais Causas da Queda Recente na Desigualdade de Renda Brasileira." In: *Revista Econômica* 8 (1): 117–147. Rio de Janeiro: Universidade Federal Fluminense.
- Datt, Gaurav, and Martin Ravallion. 1992. "Growth and Redistribution Components of Changes in Poverty Measures: A Decomposition with Applications to Brazil and India in the 1980s." *Journal of Development Economics*, 38: 275–296.
- Deaton, Angus S., and Salman Zaidi. 2002. "Guidelines for Constructing Consumption Aggregates for Welfare Analysis." *Living Standards Measurement Study Working Paper 135*, World Bank, Washington, DC.
- Foster, Greer and Thorbecke. 1984. "A Class of Decomposable Poverty Measures." *Econometrica* 52 (3): 761–65.
- Inchauste Comboni, Maria Gabriela; João Pedro Azevedo, B. Essama-Nssah, Sergio Olivieri, Trang Van Nguyen, Jaime Saavedra-Chanduvi and Hernan Winkler. 2014. "Understanding changes in poverty". Washington, DC: World Bank Group.
- Kolenikov, Stanislav, and Anthony Shorrocks. 2005. "A Decomposition Analysis of Regional Poverty in Russia." *Review of Development Economics* 9 (1):25–46.
- National Statistics Office of Mongolia and the World Bank. 2015. "Poverty measurement using the household socio-economic surveys in Mongolia".
- Үндэсний статистикийн хороо 2017. "Ядуурлын дүр төрх-2016".
- Ravallion, Martin, and Monika Huppi. 1991. "Measuring Changes in Poverty: A Methodological Case Study of Indonesia during an Adjustment Period." *The World Bank Economic Review* 5 (5): 57–82.
- Ravallion, Martin. 1992. "Poverty Comparisons - A Guide to Concepts and Methods." *Papers 88*, World Bank - Living Standards Measurement.
- Ravallion, Martin. 1994. "Poverty Comparisons." *Fundamentals of Pure and Applied Economics* 56. Chur, Switzerland: Harwood Academic Publishers.
- Ravallion, Martin. 1998. "Poverty Lines in Theory and Practice". *Living Standards Measurement Study (LSMS) Working Paper 133*. Washington, DC: The World Bank.
- Ravallion, Martin. 2001. *Poverty lines: Economic foundations of current practices*. World Bank, Washington D.C.
- World Bank. 2009. "Mongolia: Livestock sector study VOLUME I – SYNTHESIS REPORT", World Bank, Washington, DC.
- World Bank. 2015. "Poverty Measurement using the household socio-economic surveys in Mongolia" poverty methodology note, World Bank, Washington, DC.
- World Bank. 2016. "Mongolia: Progress in Reducing Poverty and Boosting shared prosperity, 2010-2014?", World Bank, Washington, DC.
- World Bank. 2018. "Perceptions of precariousness: a qualitative study of constraints underlying gender disparities in Mongolia's labor market" World Bank, Washington, DC.
- World Bank. 2019. "Mongolia Systematic Country Diagnostic." World Bank, Washington, D.C.
- Дэлхийн банк. 2020. "Монголын эдийн засгийн тойм". Дэлхийн банк, Вашингтон.

## ХАВСРАЛТ А. ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Энэ хавсралтад 2018 онд хийгдсэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны ерөнхий танилцуулга, түүврийн зохиомж, мэдээлэл боловсруулалтын талаарх нэмэлт мэдээллүүдийг тусгав. .

### А.1 ӨНЭЗС-НЫ ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ӨНЭЗС нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлохоос гадна өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индекс ашигладаг сагс болон жинг шинэчлэх, ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар тооцоход шаардлагатай хэрэглээний мэдээлэл гаргах, ТХЗ-ын зарим шалгуур үзүүлэлтийг тооцох зорилготой улсын хэмжээнд төлөөлөх чадвартай судалгаа юм. ҮСХ нь амьжиргааны түвшинг тодорхойлоход шаардлагатай үзүүлэлтүүдийг урьд нь тасралтгүй явагддаг байсан “Өрхийн орлого, зарлагын судалгаа”-нд нэгтгэн 2007 оноос эхлэн ӨНЭЗС нэртэйгээр явуулж буй бөгөөд судалгааны үзэл баримтлалын дагуу хураангуй болон дэлгэрэнгүй гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулан явуулж байна. Тэгш тоотой жилүүдэд буюу хоёр жил тутам хүн амын амьжиргаа, ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох зорилгоор судалгааны асуулгыг амьжиргааг тодорхойлох үзүүлэлтүүдээр баяжуулан явуулдаг. Судалгааны мэдээллийг 2014 оноос таблет (САPI) ашиглан цуглуулж байна. Энэ тайланд 2018 оны 1-р сараас 12-р сарыг дуусталх бүтэн нэг жилийн хугацааг хамруулан шинжилгээ хийв.

#### СУДАЛГААНЫ АСУУЛГА

2018 оны судалгааг дэлгэрэнгүй хэлбэрээр явуулсан бөгөөд 13 бүлэг асуулгыг багтааж маягтаа боловсруулсан. Судалгаанд гурван төрлийн асуулгын хуудас ашигласан. Үүнд:

- Өрхийн нийгэм, эдийн засгийн үндсэн мэдээллийн маягт (ӨНЭЗС-1): ӨНЭЗС-1 маягтаар өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл, боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт, бусад орлого, мал аж ахуй ба газар тариалан, өрхийн хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, хадгаламж, зээл, орон сууц ба эрчим хүч, удаан эдэлгээт бараа, хүнсний бус зарлагын мэдээллийг цуглуулсан.
- Өрхийн хүнсний мэдээллийн маягт (ӨНЭЗС-2а, ӨНЭЗС-2б): ӨНЭЗС-2а маягтаар нийслэл, аймгийн төвийн өрхүүдийн өдрийн тэмдэглэлийн нэгтгэл болох 30 хоногийн хүнсний хэрэглээний мэдээлэл цуглуулсан. ӨНЭЗС-2б маягтаар сумын төв, хөдөөгийн өрхүүдийн сүүлийн 7 хоногийн хүнсний хэрэглээний мэдээлэл цуглуулсан.
- Өдрийн тэмдэглэлийн маягт (ӨНЭЗС-3): Өдрийн тэмдэглэлээр нийслэл, аймгийн төвийн өрхүүдийн өдөр тутмын хүнсний хэрэглээний мэдээллийг нэг сарын турш цуглуулсан

### А.2 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

ӨНЭЗС-ны түүвэр нь улс, бус, хот, хөдөө, суурьшил, аймгийг төлөөлөх чадвартай. Нийт 320 сум 9 дүүргийн 16488 өрхийг санамсаргүй түүврийн аргаар сонгож мэдээлэл цуглуулсан.

#### ТҮҮВРИЙН ХҮРЭЭ

Судалгаанд Монгол Улсын нийт өрх буюу Үндэсний статистикийн хорооны Хүн, ам өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй өрхүүдийн жагсаалтыг түүврийн хүрээ болгон ашигласан.

### ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

Түүврийн хэмжээг 95 хувийн итгэлцэх түвшинд, алдааны магадлал 1.5 хувь, түлхүүр үзүүлэлт  $P=0.33$ , дизайн эффект нь  $deff=3$  байхаар дараах томъёогоор тооцсон бөгөөд түүврийн хэмжээг тогтоохдоо судалгааны үргэлжлэх хугацаа болох 12 сард тэгш хуваагдах нөхцлийг харгалзан үзсэн.

$$n = \frac{deff * P * (1 - P) - 1.96^2}{e^2}$$

Улсын хэмжээний нийт түүврийн хэмжээ нь 16488 өрх бөгөөд сар бүр 1374 өрх судалгаанд хамрагдсан.

### ТҮҮВРИЙН ЗОХИОМЖ

Судалгаанд Улаанбаатар, аймгийн төв, сумын төв, хөдөө нутаг гэсэн дөрвөн суурьшлын бүсийг ашиглан өрхийн сонголтыг хоёр шатат магадлалт түүврийн аргаар хийсэн. Эхний шатанд түүврийн анхан шатны нэгжийг (ТАШН) хэмжээнд нь пропорциональ тэгш хуваарилалтын аргаар сонгосон. Хоёр дахь шатанд ТАШН-ээс өрхүүдийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгосон.

Судалгааны ТАШН нь Улаанбаатар хотод хэсэг, аймгийн төв, сумын төв, хөдөө нутагт баг байна.

#### Улаанбаатар хотод:

- Улаанбаатар хотын нийт хэсгээс 360 ТАШН-ийг
- Сонгогдсон ТАШН тус бүрээс 10 өрх сонгосон.

#### Аймгийн төвд:

- Аймгийн төв тус бүрт 24 ТАШН, өрхийн тооноос харгалзан Говьсүмбэрт 12, Дархан-Уулд 36, Орхонд 60 ТАШН сонгосон.
- Сонгогдсон ТАШН тус бүрээс 10 өрх сонгосон.

#### Сумын төв, хөдөө нутагт:

- Аймаг тус бүрийн сумын төвөөс 24, хөдөө нутгаас 24, нийт 48 ТАШН, Говьсүмбэр, Дархан-Уул аймагт сумын төвөөс 12, хөдөөгөөс 12, Өвөрхангай, Хөвсгөл аймагт сумын төвөөс 24, хөдөөгөөс 36 ТАШН-ийг сонгосон.
- Сонгогдсон ТАШН тус бүрээс 8 өрх сонгосон.

### ТҮҮВРИЙН ХУВААРИЛАЛТ

Тогтоосон түүврийн хэмжээг хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар хуваарилсан. Ингэхдээ аймгийн өрхийн тоог суурьшил бүрд пропорционалиар хуваарилсан.

## Хүснэгт А.1

## ӨНЭЗС-ны түүврийн хуваарилалт, 2018

Аймгийн нэр	Түүврийн анхан шатны нэгж (ТАШН)					Түүвэрлэгдсэн өрхийн тоо				
	Улаан-баатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Нийт	Улаан-баатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Нийт
Улаанбаатар	360				360	3600				3600
Дорнод		24	24	24	72		240	192	192	624
Сүхбаатар		24	24	24	72		240	192	192	624
Хэнтий		24	24	24	72		240	192	192	624
Төв		24	24	24	72		240	192	192	624
Говьсүмбэр		12	12	12	36		120	96	96	312
Сэлэнгэ		24	24	24	72		240	192	192	624
Дорноговь		24	24	24	72		240	192	192	624
Дархан-Уул		36	12	12	60		360	96	96	552
Өмнөговь		24	24	24	72		240	192	192	624
Дундговь		24	24	24	72		240	192	192	624
Орхон		60			60		600			600
Өвөрхангай		24	24	36	84		240	192	288	720
Булган		24	24	24	72		240	192	192	624
Баянхонгор		24	24	24	72		240	192	192	624
Архангай		24	24	24	72		240	192	192	624
Хөвсгөл		24	24	36	84		240	192	288	720
Завхан		24	24	24	72		240	192	192	624
Говь-Алтай		24	24	24	72		240	192	192	624
Баян-Өлгий		24	24	24	72		240	192	192	624
Ховд		24	24	24	72		240	192	192	624
Увс		24	24	24	72		240	192	192	624
	360	540	456	480	1476	3600	5400	3648	3840	16488

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## ТҮҮВРИЙН ЖИН

Өрх бүрт ашигласан түүврийн жин нь тухайн өрхийн сонгогдох магадлалын урвуу хамааралтай тэнцүү байна. Түүврийн жинг дараах томъёогоор тооцсон.

$$p_{hi} = \frac{n_h \times M_{hi}}{M_h} \times \frac{m_{hi}}{M'_{hi}},$$

Үүнд:

$P_{hi}$  =  $h$  бүлгээс сонгогдсон  $i$ -р ТАШН-ийн өрх сонгогдох магадлал

$n_h$  =  $h$  бүлгээс сонгогдох ТАШН-ийн тоо

$M_{hi}$  =  $h$  бүлгээс сонгогдсон  $i$ -р ТАШН-ийн түүврийн хүрээнд тодорхойлсон өрхийн тоо

$M_h$  =  $h$  бүлэгт харгалзах нийт ТАШН-ийн түүврийн хүрээнд тодорхойлсон өрхийн тоо

$m_{hi}$  =  $h$  бүлгээс сонгогдсон  $i$ -р ТАШН-ээс сонгогдсон өрхийн тоо (хотод 10, хөдөөд 8 өрх)

$M'_{hi}$  =  $h$  бүлгээс сонгогдсон  $i$ -р ТАШН-ийн жагсаалтаар ирүүлсэн өрхийн тоо

( $M'_{hi} = M_{hi}$  байж болно)

2018 оны судалгаанд нийт түүврийн 99.8 хувь буюу 16454 өрх хамрагдсан. Улаанбаатар, аймгийн төвийн өрхийг хаягт суурилан судалгаанд хамруулсан. Мөн түүврийн анхан шатны нэгж (ТАШН) бүрт 2 нөөц өрхийг нэмэлтээр сонгож өгсөн, сонгогдсон өрх судалгаанд хамрагдах боломжгүй үед нөөц өрхөөс судалгааг авсан.

Түүврийн жин улс, бүс, аймгийн түвшинд төлөөлөх чадвартай тооцогдсон. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан 16454 өрхийн мэдээлэл Монгол Улсын нийт өрх, бүс, аймгийн түвшинд төлөөлөх чадвартай байна.

## Хүснэгт А.2

## ӨНЭЗС-ны хамрагдалт, ТАШН-ээр, ярилцлага авсан сараар, 2018

	Улаанбаатар	Аймгийн төв	Хөдөө	Улсын хэмжээнд
1 сар	298	450	624	1 372
2 сар	300	449	624	1 373
3 сар	296	450	624	1 370
4 сар	295	449	623	1 367
5 сар	297	450	624	1 371
6 сар	295	450	623	1 368
7 сар	296	449	623	1 368
8 сар	299	450	624	1 373
9 сар	298	450	624	1 372
10 сар	299	449	624	1 372
11 сар	300	450	624	1 374
12 сар	300	450	624	1 374
Нийт	3 573	5 396	7 485	16 454

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## ХАВСРАЛТ Б. ЯДУУРЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ<sup>45</sup>

Энэ хавсралтад ядуурлын тооцоог хийсэн аргачлалын талаар дурдсан болно. Энэ хэсэгт аж байдлын үзүүлэлтийг сонгох, хэрэглээний иж бүрдлийг байгуулах, ядуурлын шугамыг тооцох зэрэг мэдээлэл боловсруулалтын бүх шатыг тайлбарлав.

### Б.1 АЖ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН СОНГОЛТ

Ядуурал нь хувь хүний аж байдлын доройтол, гачигдалтай байдлаар илрэх бөгөөд эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавх доройтох, хоол тэжээлийн гачигдал, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж хязгаарлагдмал байх, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байх зэргээр илэрдэг. Ядуурлын эдгээр ялгаатай бүрэлдэхүүн хэсгүүд хосолсон байх тохиолдол элбэг байдаг. Жишээлбэл, хоол тэжээлийн дутагдалд орсон хүн голдуу боловсрол багатай, эрүүл мэндийн тусламж авах боломжгүй байх г.м.

Хэдийгээр бүх хэлбэрийн гачигдал ядуу гэсэн утгыг илэрхийлэх боловч мөнгөөр хэмжигдэх гачигдал ядуурлыг тодорхойлох гол хэмжигдэхүүн байдаг. Орлого, хэрэглээ хоёрын алиныг нь аж байдлын хэмжүүр үзүүлэлт болгон сонгож авахыг шийдэх нь юуны түрүүнд чухал юм. Орлого, хэрэглээ хоёр ойролцоо хэмжигдэхүүнүүд мэт боловч өөр өөр тодорхойлолттой байдаг.<sup>46</sup> Хэдийгээр энэ хоёр нь өөр ойлголтууд боловч хоёул сэтгэл ханамжийг ямар нэг байдлаар илэрхийлдгээрээ төстэй. Хэрэглээ нь хувь хүн бүр бодитоор юу хэрэглэснийг илэрхийлдэг бол орлого нь тухайн хүний чадварыг хөрөнгийн хамт хэмжинэ. Хүний бүхий л амьдралын турш дахь амьжиргааны түвшинг судлахыг сонирхож байгаа бол орлого ба хэрэглээний алийг сонгох нь ялгаагүй. Харин богино хугацааны буюу жишээ нь нэг жилийн хувьд орлогоос хэрэглээ нь илүү тогтвортой, өөрчлөлт багатай байна.

Нэгдүгээрт, хэрэглээ нь орлоготой харьцуулахад улирлын хэлбэлзэл багатай байдаг. Тухайлбал газар тариалан эрхэлж байгаа өрхийн орлогын түвшин ургац хураалт, тариалалтын үетэй холбоотойгоор маш хэлбэлзэлтэй байдаг учраас энэ үзүүлэлтийг ашигласнаар амьжиргааны түвшинг үлэмж хэмжээгээр ихэсгэж, багасгаж бодит бусаар тооцоолох магадлал илүү байна.

Хоёрдугаарт, албан бус сектор, хөдөө аж ахуйд ажилладаг, хувиараа хөдөлмөр эрхлэгчид орлогоо нарийн тодорхойлоход төвөгтэй байдаг. Хэрэглээ нь мэдээлэл өгөгчдөд орлогоос илүү хялбар ойлголт байдаг. Ялангуяа, орлого нь хувиараа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанаас орж байгаа тохиолдолд хэрэглээг мэдээлэхэд илүү хялбар байна. Жишээлбэл, албан ёсны бүртгэлтэй салбарт ажиллаж байгаа хүн орлогын үндсэн эх үүсвэрээ буюу жишээлбэл цалин, хөлсөө тодорхой мэдээлэхэд ямар нэг хүндрэл учрахгүй. Харин албан бус сектор, эсвэл хөдөө аж ахуйд ажилладаг, хувиараа хөдөлмөр эрхлэгчид орлогоо нарийн тодорхойлоход бэрхшээлтэй байдаг бөгөөд өрхийн болон бизнесийн ажил гүйлгээ холилдон бүртгэгддэг. Өрхүүд орлогоосоо илүүгээр хэрэглээгээ мэдээлэхдээ дуртай байдаг. Тэд орлогын талаарх мэдээллийг нь өөр зорилгоор, тухайлбал татварын хэмжээ тогтоох үүднээс ашиглаж магадгүй гэж болгоомжилдог, эсвэл орлогын талаар асуух нь таатай бус гэж үздэгтэй ч холбоотой юм. Мөн өрхийн гишүүд нь өрхийн орлого, түүний эх үүсвэрээс илүүтэйгээр хэрэглээгээ сайн мэдэж байдаг.

45 Хавсралтын энэ хэсэг Раваллион (1994) Деатон, Зайди нарын (2002) ядуурлын тооцооны аргачлалын дагуу бичигдсэн. Монгол Улсад үндэсний ядуурлын үзүүлэлтүүдийг хэрхэн тооцох талаар ҮСХ, ДБ-ны 2015 онд гаргасан ядуурлын тооцооны аргачлалын техникийн баримт бичгийг үзнэ үү.

46 Деатон, Зайди нарыг харна уу (2002)



## Б.2 ХЭРЭГЛЭЭНИЙ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙГ ТОГТООХ

Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоохдоо онол, практикийг хослуулан авч үздэг. Нэгдүгээрт, аль болох дэлгэрэнгүй ашиглах боломжтой мэдээлэл байх хэрэгтэй. Энэ мэдээллээс хүн амын аж байдлыг тодорхойлохгүй, эрэмбэлэхэд нөлөө үзүүлэхгүй зарим үзүүлэлтүүдийг тооцоонд оруулахгүй хасах ёстой. Хоёрдугаарт, худалдан авалт хэрэглээний цорын ганц бүрэлдэхүүн хэсэг биш учраас зах зээлийн болон зах зээлийн бус гүйлгээг хоёуланг хамруулна. Гуравдугаарт, зардал бол хэрэглээ биш. Удаан хадгалахад тохиромжгүй, ялангуяа хүнсний бүтээгдэхүүний хувьд худалдан авснаа бүгдийг нь хэрэглэдэг гэж үзэх нь түгээмэл. Харин орон сууц, удаан эдэлгээт бараа гэх мэт бусад бараа, үйлчилгээний хувьд тохируулга хийх шаардлагатай. Эцэст нь хэрэглээ хүнс, хүнсний бус, сууц, удаан эдэлгээт бараа, эрчим хүч гэсэн 5 үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг бүр тодорхой нэр төрлүүдээс бүрдэх ба эдгээр нэр төрөл бүрийн хэрэглээний үнэлгээг хийх аргачлалыг доор товч тайлбарлав.

### ХҮНСНИЙ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

Хүнсний хэрэглээг тооцохдоо хүнсний бүх бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийн хэрэглээг нэг цаг хугацаанд шилжүүлэн, нэмж бүрдүүлэх бөгөөд дараа нь өрх бүрийн бүх хүнсний барааг нэгтгэдэг. 2018 оны ӨНЭЗС-гаар гурил, гурилан бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, загас болон далайн бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, төрөл бүрийн өөх тос, жимс, жимсгэнэ, чихэр, жимсний чанамал, хүнсний бусад бүтээгдэхүүн, цай, кофе, цэвэр ус, ундаа, жимсний шүүс, согтууруулах ундаа, тамхи гэсэн 14 бүлэг болгон ангилсан 130 нэр төрлийн бүтээгдэхүүний хүнсний хэрэглээний мэдээллийг өрхийн түвшинд цуглуулсан.

Мэдээлэл цуглуулах арга болон хугацаа нь хот, хөдөөд ялгаатай. Хотын суурьшил буюу Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд хүнсний хэрэглээний мэдээллийг өрхийн өдөр тутмын бүртгэл дээр үндэслэн цуглуулсан бөгөөд судлаач нар сард гурван удаа өөрөөр хэлбэл арав хоног тутамд өрхөд очиж мэдээллийг нэгтгэж байв. Өөрөөр хэлбэл, өрх тус бүрийн хувьд хүнсний мэдээллийн хамрах хугацаа нь нэг сар байлаа. Сумын төв болон хөдөөд өрхийн сүүлийн долоо хоногийн хүнсний хэрэглээг сануулж бүртгэх аргыг ашигласан. Ийм хоёр өөр арга хэрэглэсэн нь дараах гурван шалтгаантай болно. Нэгдүгээрт, судлаач нар аймгийн төвд байрладаг тул аймгийн төвөөс алслагдсан сумын төв болон хөдөөгийн өрхүүдэд арав хоног бүр очих боломж байхгүй. Хоёрдугаарт, малчин өрхүүд тогтмол нүүдэллэдэг учраас хоёр дахь, гурав дахь очилтоор зорьсон өрхөө олоход хүндрэл учрах магадлал их. Гуравдугаарт, хөдөөгийн хүн ам нь хотын хүн амтай харьцуулахад худалдан авалтыг бөөнөөр нь голдуу хийдэг тул өрх өдөр тутмын бүртгэл нөхөхөд илүү бэрхшээлтэй байдаг.

Хэрэглээний энэ бүрэлдэхүүн хэсгийг боловсруулахад хэд хэдэн үндсэн зарчмыг хэрэглэсэн. Нэгдүгээрт, хэрэглээний бүх боломжит эх үүсвэрийг оруулав. Өөрөөр хэлбэл хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ нь зах зээлээс худалдан авсан эсвэл гэрээс гадуур хэрэглэсэн хүнсний зүйлээс гадна өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн, бусдаас авсан бэлэг, бараа солилцоогоор авсан бүтээгдэхүүн зэргээс бүрдэнэ. Хоёрдугаарт, худалдан авсан болон өөрийн аж ахуйгаас авсан бүх хүнсний бүтээгдэхүүнийг биш тухайн хугацаанд хэрэглэсэн бүтээгдэхүүнүүдийг хэрэглээний бүтцэд багтаасан. Гуравдугаарт, мөнгөөр худалдан аваагүй хүнсний зүйлийг үнэлж оруулсан. ӨНЭЗС-гаар зөвхөн өрхийн хүнсний худалдан авалтын хувьд дундаж үнийн дүн, тоо хэмжээний талаар мэдээлэл цуглуулсан бөгөөд бусад эх үүсвэрийн хувьд зөвхөн тоо, хэмжээний мэдээллийг авсан. Тиймээс худалдан аваагүй хүнсний бүтээгдэхүүний мөнгөн дүнг тооцохдоо дундаж үнийн мэдээллийг ашиглалаа. Хэрвээ өрх ямар нэг нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдан аваагүй боловч хэрэглэсэн бол хэрэглээг нь үнэлэхэд түүний дээд түвшний (өрхийн харьяалагдах түүврийн нэгжийн гэх мэт) дундаж үнийг ашиглана.

### ХҮНСНИЙ БУС БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

Хүнсний бус хэрэглээг хүнсний хэрэглээтэй адилаар шууд, хялбархан тооцоолно. Хүнсний хэрэглээтэй адилаар нэг хугацаанд шилжүүлэн тэгшитгэсэн хүнсний бус хэрэглээний бүхий л эх үүсвэрийг оруулах ёстой. Хүнсний бус хэрэглээгээр өргөн хүрээний буюу эрэгтэй, эмэгтэй хүний, хүүхдийн хувцас, гутал, бэлэг дурсгал, үнэт эдлэл, бөс бараа, боловсрол, эрүүл мэнд, амралт чөлөөт цаг, соёлын зардал, гоо сайхан, ариун цэврийн бараа үйлчилгээ, гэр ахуйн бараа, удаан эдэлгээтэй бараа, орон сууцны зардал, тээвэр, холбоо, даатгал, татвар зэрэг 38 бүлгийн 371 нэр төрлийн бүтээгдэхүүний мэдээллийг цуглуулсан. Хүнсний бус барааны нэр төрлүүд дотроо ижил бус, ялгаатай олон бүтээгдэхүүнийг агуулдаг учраас нэгжийн үнийг нь тооцоход бэрхшээлтэй байдаг. ӨНЭЗС-гаар хүнсний бус барааны тоо хэмжээний талаарх мэдээллийг цуглуулдаггүй. Энэ бүрэлдэхүүн хэсэгт удаан эдэлгээтэй бараа, сууц, түлш, эрчим хүчнээс бусад хүнсний бус барааны хэрэглээг тооцно.

Зөвхөн хэрэглээнд ордог хүнсний бус барааны нэр төрлүүдийг л хэрэглээний иж бүрдэлд багтаах ёстой гэсэн алтан дүрэм бий. Тухайлбал, хувцас, гутал, гоо сайхны бараа, бүтээгдэхүүн, амралт, чөлөөт цагт зарцуулсан зардал гэх мэт зүйлс хамрагдана. Харин их хэмжээгээр зарлагддаг боловч эргэж амьжиргаанд үзүүлэх нөлөө багатай зарим хүнсний бус нэр төрлүүдийг хасдаг. Жишээ нь, хөрөнгийн гүйлгээ (санхүүгийн хөрөнгө, өр, хүүгийн төлбөр), татвар, даатгал, гэнэтийн эсвэл их хэмжээний мөнгө зарцуулагддаг хурим, төрөлт, оршуулгын зардлыг тооцоонд оруулахгүй хасдаг. Мөн бусад өрхөд шилжүүлсэн мөнгөн гуйвуулгыг хасаж тооцсон нь дээр байдаг учир нь шилжүүлгийг хүлээн авсан талын хэрэглээнд энэ орлого тусгагдсан учраас давхардах магадлалтай гэж үздэг. Хэрэв дээрх хэрэглээнүүдийг тооцоонд оруулбал өрхийн амьжиргааны байдлыг хиймлээр өсгөх нөхцөл болно.

Хүнсний бус хэрэглээний бүрэлдэхүүн хэсэг дотроос хоёр зүйл буюу эрүүл мэнд, боловсролын тооцоог онцгойлон авч үзэх шаардлагатай. Боловсролын тооцооны хувьд гурван асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт, боловсрол нь хэрэглээ биш харин хөрөнгө оруулалт гэж үзэх ойлголт байдаг. Учир нь хүн боловсролынхоо үр өгөөжийг зөвхөн сурч байх үедээ бус бүхий л амьдралынхаа турш хүртдэг. Хоёрдугаарт, боловсролын зардал нь хүний амьдралын тодорхой үед л зарцуулагддаг. Жишээ нь боловсролын зардалдаа яг ижил хэмжээний зардал зарцуулсан нэг нь одоо суралцаж байгаа, нөгөө нь нэлээд хэдэн жилийн өмнө сургуулиа төгсчихсөн хоёр хүнийг харьцуулж авч үзье. Энэ тохиолдолд одоо суралцаж байгаа нь боловсролын зардлаасаа шалтгаалаад амьжиргаа сайтай мэт тооцогдох боловч энэ үр дүн тэдний бодит амьжиргааны түвшний ялгааг харуулж чадахгүй. Ийм учраас боловсролын зардлыг амьдралынх нь нийт хугацаанд тэгшитгэн хуваарилах нь хамгийн оновчтой арга болно. Гуравдугаарт, улсын сургуульд суралцаж буй байдлыг тооцож үзэх хэрэгтэй. Хэрэв бүх хүн ерөнхий боловсролыг төрөөс үнэ төлбөргүй авах боломжтой байхад хувийн сургуулийг сонгон төлбөр төлж суралцаж байгаа нь өрхийн амьжиргааны түвшинтэй холбоотой байдаг. Ийм тохиолдолд тухайн зардлыг тооцоонд тусгах нь зүйтэй гэж үздэг.

Эрүүл мэндийн зардал зарим талаараа боловсролтой адил байдаг. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт зарцуулсан зардлыг хэрэглээ биш хөрөнгө оруулалт гэж тооцно. Эрүүл мэндийн үйлчилгээний ялгаатай байдал өрхүүдийн амьжиргааг харьцуулахад асуудал үүсгэж болох юм. Хүн амын зарим хэсэг төрөөс үзүүлдэг үнэ төлбөргүй, эсвэл ихэнх зардлыг нь хариуцдаг үйлчилгээнд хамрагдаж байхад нөгөө хэсэг нь эрүүл мэндийн салбарын үйлчилгээний хүртээмжгүй байдлаас болж сонголтгүйгээр хувийн салбарын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах тохиолдолд зардлын энэ ялгавартай байдал амьжиргааны ялгааг харуулахгүй. Энд анхааран үзэх хэд хэдэн зүйл бий. Нэгдүгээрт, эрүүл мэндийн зардал нь байнга бус тодорхой цаг хугацаанд бөөнөөр гардаг. Хоёрдугаарт, өрхийн гишүүн өвчилсөнтэй холбогдон гарсан эрүүл мэндийн зардал учраас өрхийн амьжиргаанд муугаар нөлөөлөх учиртай гэвч гарсан зардлаар тооцоо хийхэд амьжиргаа нь өссөн

мэт харагддаг. Гуравдугаарт, эрүүл мэндийн даатгал нь харьцуулалтыг буруу тооцоонд хүргэдэг. Учир нь эрүүл мэндийн даатгалтай өрхийн гишүүн өвдлөө гэхэд өрхийн төсвөөс бага хэмжээний мөнгө зарцуулсан байдаг. Харин эрүүл мэндийн даатгалгүй өрхийн гишүүд эмчилгээндээ өрхийн төсвөөс их мөнгийг зарцуулна. Иймээс энэ судалгааны хувьд эрүүл мэндийн зардлыг хүнсний бус хэрэглээний бүрэлдэхүүнд оруулж байна. Эрүүл мэндийн асуудалтай тулгарсан өрхүүдийн амьжиргааны ялгааг харуулах боломжгүй болох учраас энэ үзүүлэлтийг хасалгүй тооцоонд авч үлдэх шаардлагатай.

Хүнсний бус хэрэглээтэй холбоотой дараагийн бэрхшээлтэй асуудал нь хэрэглээг тооцох хугацааг сонгох юм. Анхааран үзэх гол асуудал нь өрхийн худалдан авалт хийх давтамж болон хэрэглээгээ эргэн санах хугацааны хамаарал юм. Ариун цэврийн хэрэгсэл, гоо сайхны бараа, орон сууцны төлбөрөөс бусад хүнсний бус олон бараа, бүтээгдэхүүний хувьд сүүлийн долоо хоног, сард ямар нэгэн худалдан авалт хийгээгүй байх тохиолдол элбэг түл эргэн санах хугацааг ихэнхдээ сүүлийн сар, сүүлийн жилээр сонгодог. ӨНЭЗС нь сүүлийн сар ба сүүлийн жил гэсэн хоёр өөр хугацааг хамарсан мэдээлэл цуглуулдаг. Аль хугацааг сонгож тооцоо хийх нь хэрэглээний бүрдэлд их нөлөөтэй байдаг. Өрхүүд сар бүр хүнсний бус бараа, бүтээгдэхүүн худалдан аваад байдаггүй учраас олон өрхийн хувьд ямар ч хэрэглээ мэдээлэгдэхгүй байх магадлалтай. Сүүлийн нэг сарын худалдан авалтыг тооцоонд ашигласнаар сарын дундаж хэрэглээг тооцоолж болох ч судалгаанд хамрагдсан нэг сарын хугацаанд хүнсний бус бараа, үйлчилгээний худалдан авалт хийгээгүй өрхүүд хэрэглээ багатайд тооцогдон улмаар ядуу гэсэн ангилалд хамаарах магадлал маш өндөр байдаг. Сүүлийн нэг жилийг эргэн санах хугацаа болгон авбал хүнсний бус бараа, бүтээгдэхүүний хувьд илүү үндэслэлтэй хугацаа болох учир дээрх бэрхшээл арилна. Гэвч эргэн санах хугацааг уртасгахаар нэг сул тал үүсдэг. Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагаа мэдээлэх өрхийн тоо, зардлын нэр төрөл нэмэгдэх боловч дундаж зарлага нь эргэн санах хугацаа богинотой зардлаас багасаж гарч ирдэг. Энэ хоёр сонголтын давуу болон сул талыг нь харгалзан үзсэн гуравдахь сонголт нь эргэн санах хоёр хугацааг хослуулах арга юм. Энэ тохиолдолд хэрэв тухайн өрх сүүлийн нэг сард хүнсний бус бараа, бүтээгдэхүүн худалдан авсан бол тухайн мэдээллийг нь авч, харин сүүлийн нэг сарын хугацаанд хүнсний бус бараа бүтээгдэхүүн худалдан аваагүй бол сүүлийн нэг жилийнх нь мэдээллээс авч тооцоо хийнэ.

### УДААН ЭДЭЛГЭЭТЭЙ БАРАА

Өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээтэй бараа нь амьжиргааны түвшинг тодорхойлох чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Эдгээр бараа нь удаан хугацаанд ашиглагддаг учир худалдан авсан үнэ нь хэрэглээг тодорхойлох тохиромжтой үзүүлэлт болохгүй. Энд тооцоо хийх хамгийн зөв арга нь удаан эдэлгээтэй бараанаас авч байгаа сэтгэл ханамжийн түвшинг тооцох юм. Энэхүү авч байгаа сэтгэл ханамжийн хэмжээ нь биетээр ажиглагдахгүй ч үнийн дүнтэй шууд пропорциональ бөгөөд элэгдлийн түвшин гэсэн үзүүлэлтээр тодорхойлогдоно. Бараа бүрийн элэгдлийн түвшинг тооцохдоо ӨНЭЗС-гаар авсан удаан эдэлгээтэй барааны одоогийн зах зээлийн үнэ, ашигласан (мэдээлэл нь өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээтэй барааны тоо ширхгийн хамт цуглуулагдсан) хугацаанд үндэслэнэ.<sup>47</sup>

Энэ бүрэлдэхүүн хэсгийн тооцоог 3 үе шаттайгаар хийнэ. Нэгдүгээрт, удаан эдэлгээтэй бараанаас хэрэглээний бүрэлдэхүүнд орох нэр төрлийг сонгоно. ӨНЭЗС-гаар гэр ахуйн хэрэгслээс эхлээд тавилга хүртэлх 44 нэр төрлийн удаан эдэлгээтэй барааны талаар мэдээлэл цуглуулсан. Гэхдээ нийт удаан эдэлгээтэй барааны 1/3 болох өрхийн бизнест ашиглагддаг бараа, сууц болон “бусад” гэж ангилагдсан бараануудыг тооцоонд оруулаагүй. Нийт 30 удаан эдэлгээтэй барааг тооцоонд оруулсан. Хоёрдугаарт, хэрэглээний бүрэлдэхүүнд сонгон оруулсан удаан эдэлгээтэй барааны хувьд элэгдлийн түвшинг тооцохдоо нэгжийн үнэ (хувьсах хэмжигдэхүүн) ба ашигласан хугацаанд

47 Инфляци болон нэрлэсэн хүүг ашиглан боловсронгуй болгож болно.

үндэслэсэн шугаман регресс тооцсон. Энэхүү тооцооны арга нь нэг барааны хувьд хэрэглэсэн хугацаанаас хамааран элэгдлийн өөр, өөр түвшинг бодох боломжийг олгодог. (Жишээ нь удаан эдэлгээтэй бараа нь шинэ бол элэгдлийн түвшин буюу бараанаас авч буй сэтгэл ханамж өндөр байна.) Эцэст нь хэрэглээг тооцоходоо тухайн барааны үнийг элэгдлийн хувиар үржүүлэн өрхөөр нэгтгэж гаргана.

## СУУЦ

Хүн амын амьжиргааны түвшний гол үзүүлэлт нь орон сууцны нөхцөл билээ. Хөгжиж байгаа орнуудын хувьд орон сууцны түрээсийн зах зээл хязгаарлагдмал эсвэл байдаггүй учир тооцоо хийх, хэрэглээний бүтцэд оруулахад нэлээд бэрхшээлтэй байдаг. Үүнийг хэрэглээний бүтцэд оруулах зорилго нь удаан эдэлгээтэй бараатай адилаар тухайн орон сууцыг эзэмшиж байгаагаас авах ханамжийн хэмжээг тооцож оруулахад оршино. Хэрвээ тухайн өрх байр түрээслэн амьдарч байгаа бол түрээсийн хэмжээ нь сэтгэл ханамжийн үнэлгээ болно. Манай орны хувьд нийт өрхийн 98 хувь өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг учир түрээсийн мэдээлэл дээр үндэслэн сууцнаасаа авч байгаа сэтгэл ханамжийн хэмжээг тооцох боломжгүй байдаг. Хэдий тийм боловч ӨНЭЗС-гаар өрх хэрвээ сууцаа түрээслэлбэл хэдэн төгрөгөөр түрээслэх (хийсвэр түрээс), худалдах бол хэд гэж үнэлэх үнийг асууж бичсэн. Бодит түрээсийн утга бүртгэгдээгүй тохиолдолд хийсвэр түрээсийн утгыг ашиглан түрээс тооцож хэрэглээний иж бүрдэлд оруулж болдог. Тооцооны түрээсийн утгыг таамаглаж гаргадаг учраас зарим тохиолдолд ашиглах боломжгүй байх талтай. Мөн нийт хүн амын 40 орчим хувь нь гэрт амьдардаг тул түрээсийн утгыг тооцоход хүндрэл учирч байна.

Сууцаа өмчилж буй өрхүүдийн сууцны нөхцөлийг тодорхойлогч шал, хана, дээврийн үндсэн материалын төрөл, өрөөний тоо, усан хангамж, цахилгаан, дулаан, байршил зэргийг харгалзан үзэж сууцны тусдаа байшин, нийтийн тохилог сууц 33 жилийн дараа, гэр 17 жилийн дараа бүрэн элэгдэнэ гэж тооцоонд тусгасан. Сууцны үнийн талаарх мэдээллийг удаан эдэлгээтэй барааны бүлэгт цуглуулдаг бөгөөд нэг төрлийн нэгээс илүү сууц эзэмшдэг өрхүүдийн хувьд тэдгээрийн дунджаар тооцсон. Регрессийн шинжилгээг хийхдээ орон сууцны төрөл тус бүрийн хувьд тооцоог тус тусад нь хийнэ. Хэрвээ өрх хоёр өөр төрлийн сууц эзэмшдэг бол (жишээ нь: гэр ба сууцны тусдаа байшин) хедоник загварыг ашиглан тооцоо хийнэ. Хедоник загвар нь гэр, сууцны тусдаа байшин, орон сууцанд тус тусад нь тооцоолол хийдэг.

## ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧ

Хүнсний бус хэрэглээний анхааран үзэх нэг бүрэлдэхүүн хэсэг нь эрчим хүчний хэрэглээ буюу халаалт, цахилгааны зардал юм. Манай орон өвөл -40, зун +30 хэмд хүрдэг эрс тэс уур амьсгалтай. Хэдийгээр зуны улирал байгаль, цаг уурын нөхцөл харьцангуй тааламжтай хэдий ч өвлийн улирал онцгой хүнд нөхцөл үүсгэдэг. Өвлийн улирал бараг 6 сар үргэлжлэн, голдуу хасах хэмтэй байдаг бөгөөд нэг, хоёрдугаар сарын дундаж температур -25 байдаг. Энэ онцгой нөхцөл нь түлш, халаалт өрхийн хэрэглээний зайлшгүй, нэн чухал хэрэгцээ болохыг илэрхийлж байгаа бөгөөд зарим тохиолдолд хэрэглээний чухал бүрэлдэхүүн хэсэг болдог.

ӨНЭЗС-гаар түлш, эрчим хүчний зардлыг худалдан авсан бол үнийг бичүүлж, өөрсдөө бэлтгэсэн түлшний зардлыг өрхүүдээр өөрсдөөр нь үнэлүүлэн мэдээллийг цуглуулсан. Өрхийн өөрсдөө бэлтгэсэн түлшний үнийн талаар мэдээлэл байхгүй нөхцөлд хэрэглээний утгыг тооцох боломжгүй болох буюу өрхийн түлш, эрчим хүчний хэрэглээ дутуу тооцогдох магадлалтай байдаг. Тиймээс өрх халаалтандаа хэрэглэсэн түлшээ худалдан аваагүй тохиолдолд өрхийн өөрсдийн бэлтгэсэн түлшний тоо хэмжээг тухайн түлшинд харгалзах медиан үнээр үржүүлж, түлш эрчим хүчний хэрэглээнд оруулсан болно. Хэрэв тухайн түүврийн нэгжид уг нэр төрлийн түлшний худалдан авалт хийгдээгүй бол худалдан авалт хийгдсэн түүний дээд түвшний (сум, аймаг, бүс, суурьшил) түүврийн нэгжид харьяалагдах медиан үнийг ашигласан.

### Б.3 ҮНИЙН ТОХИРУУЛГА

Манай оронд хүнсний бүтээгдэхүүний үнийн улирлын хэлбэлзэл өндөр. Жишээ нь, хаврын улиралд хүнсний бүтээгдэхүүний үнэ бусад улирлыг бодвол харьцангуй өндөр, бус нутгуудын хувьд харилцан адилгүй байдаг. Ялангуяа, бусад бүсүүдтэй харьцуулахад Улаанбаатар хотод зарим бараа, бүтээгдэхүүний үнэ өндөр байдаг. Ийм учраас амьжиргааны түвшинг бодитойгоор тооцохын тулд зарлагын дүнг үнийн индекс ашиглан тохируулга хийх шаардлагатай болдог. Ядуурлын тооцоог хийхдээ дээрх хэсэгт дурдсан алхмуудаар бүрдүүлсэн хэрэглээний иж бүрдэлд Паашийн индекс ашиглан цаг хугацааны болон газар зүйн байршлын үнийн тохируулга хийсэн. ӨНЭЗС болон улсын хэрэглээний үнийн индексээс авсан мэдээллийг хослуулан ашиглаж түүврийн анхан шатны нэгжийн түвшинд Паашийн үнийн индексийг тооцов.

Түүвэрлэлтийн анхан шатны  $i$  нэгж дэх Паашийн үнийн индексийг дараах томъёогоор тодорхойлно:

$$P_i^P = \left[ \sum_{k=1}^n w_{ik} \left( \frac{P_{ik}}{P_{0k}} \right)^{-1} \right]^{-1}$$

Энд  $w_{ik}$  - түүврийн анхан шатны  $i$  нэгжийн  $k$  нэрийн барааны төсөвт/хэрэглээнд эзлэх хувийн жин;  
 $P_{ik}$  - түүврийн анхан шатны  $i$  нэгжийн  $k$  нэрийн барааны дундаж үнэ (үнийн медиан);  
 $P_{0k}$  -  $i$  нэгжийн  $k$  нэрийн барааны улсын дундаж үнийн түвшин (үнийн медиан).

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийн нийт хэрэглээнд эзлэх дундаж хувь хэмжээ болон нэгжийн дундаж үнийг хоёуланг нь ӨНЭЗС-аар цуглуулсан. Хүнсний бус бүрэлдэхүүн хэсгийн хувьд өрхийн төсөвт эзлэх дундаж хувь хэмжээг ӨНЭЗС-наас, харин дундаж үнийг улсын хүнсний бус барааны үнийн мэдээллээс авч ашигласан. Хүнсний бүтээгдэхүүний хувьд цаг хугацааны болон газар зүйн байршлын тохируулгыг, харин хүнсний бус бүх бараа, бүтээгдэхүүний хувьд цаг хугацааны засварлалтыг оруулж тооцсон.

Хүнсний болон нийт үнийн индексийг сараар болон суурьшлаар Хүснэгт Б.1-д харуулав. Энэ индексээс амьжиргааны өртөг бусад аль ч нутаг дэвсгэрээс Улаанбаатар хотод илүү өндөр байгааг, мөн улирлын нөлөөллийг харж болно.

#### Хүснэгт Б.1

Түүврийн анхан шатны нэгжийн Паашийн индекс, бүлгээр, ярилцлага авсан сараар, 2018

	Хүнсний Паашийн индекс				Нийт Паашийн индекс			
	Улаанбаатар	Аймгийн төв	Хөдөө	Улсын дундаж	Улаанбаатар	Аймгийн төв	Хөдөө	Улсын дундаж
2018 он								
1 сар	0.98	0.95	0.86	0.93	0.99	0.98	0.93	0.96
2 сар	1.01	0.96	0.91	0.96	1.00	0.98	0.95	0.97
3 сар	1.04	0.98	0.90	0.98	1.01	0.99	0.95	0.98
4 сар	1.05	1.01	0.94	1.00	1.01	0.99	0.96	0.99
5 сар	1.06	1.03	0.95	1.02	1.01	1.01	0.97	1.00
6 сар	1.10	1.05	0.98	1.05	1.03	1.01	0.98	1.01
7 сар	1.09	1.04	0.97	1.03	1.03	1.01	0.97	1.00
8 сар	1.03	1.00	0.92	0.99	1.02	1.01	0.96	1.00
9 сар	1.04	0.99	0.93	0.99	1.03	1.01	0.97	1.00
10 сар	1.05	1.01	0.92	1.00	1.04	1.02	0.98	1.01
11 сар	1.05	1.01	0.97	1.02	1.05	1.04	1.01	1.04
12 сар	1.09	1.03	0.96	1.03	1.07	1.04	1.00	1.04
Дундаж	1.05	1.01	0.93	1.00	1.02	1.01	0.97	1.00

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Б.4 ӨРХИЙН БҮТЦИЙН ТОХИРУУЛГА

Аж байдлын үзүүлэлтийг бий болгох эцсийн шат нь өрхийн түвшинд тодорхойлогдсон амьжиргааны түвшний хэмжигдэхүүнүүдийг нэг хүнд ногдох хэмжээнд шилжүүлэх юм. Учир нь зэрэгцүүлэлтийг өрхөөр биш хувь хүнээр хийдэг. Эрүүл мэнд, боловсролоос бусад зардлын мэдээллийг өрхийн түвшинд цуглуулдаг тул хувь хүний аж байдлын түвшинг тооцохын тулд өрхийн нийт хэрэглээг тухайн өрхийн нийт ам бүлийн тоонд харьцуулан тооцно. Үүнийг өрхийн гишүүн бүр ижил хувь, хэмжээтэйгээр хэрэглэнэ гэж үзэх нэгдсэн практикт үндэслэн тодорхойлдог.

## Б.5 ЯДУУРЛЫН ШУГАМ

Ядуурлын шугам нь тодорхой өгөгдсөн цаг хугацаа, оршин байгаа орчинд хувь хүний амьжиргааны түвшинг мөнгөн дүнгээр илэрхийлсэн утга юм (Раваллион 1998). Хэрвээ хэн нэгэн амьжиргааны стандарт доод түвшингээс бага хэрэглээтэй бол уг хүнийг ядуу гэж тодорхойлно.

Дэлхийн банктэй хамтран ажилласан техникийн зөвлөгөөний хүрээнд ядуурлын шугамыг үндсэн хэрэгцээний зардлын аргыг ашиглан тооцдог. Энэ аргаар тодорхойлбол, ядуурлын шугам нь хүний үндсэн хэрэгцээнд шаардлагатай хэрэглээний сагсанд орсон бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийт дүн юм. Ядуурлын шугамыг 2010 оны ӨНЭЗС-ны мэдээлэлд үндэслэн тооцсон. Хүнсний ядуурлын шугам нь нэг хүний хоногт авах шаардлагатай 2100 кк илчлэгт үндэслэн тооцогдсон. Харин хүнсний бус ядуурлын шугам нь хүнсний ядуурлын шугамд харгалзах хүнсний бус бараа, үйлчилгээний зардал юм.

### ХҮНСНИЙ ЯДУУРЛЫН ШУГАМ

Энэ ядуурлын шугамыг байгуулах эхний алхам нь хүний эрүүл, идэвхтэй амьдралыг хангахад шаардлагатай хүнс тэжээлийн хэмжээг тодорхойлох юм. Манайд нэг хүний хоногт авч байх ёстой илчлэгийн хэмжээг 2100 ккалори байхаар жишиг болгож авсан. Хоёрдугаарт, хүнсний сагсыг сонгох ёстой. Нэг арга нь тухайн орны жишиг болгон авч байгаа хүн амын хүнсний хэрэглээний бүтцийг харгалзан тогтоодог. Энэ судалгаанд дээрх аргыг ашиглан, нийт хүн амыг нэг хүнд ногдох хэрэглээгээр нь эрэмбэлэн, доогуур хэрэглээтэй 40 хувийн хүн амын дундаж хүнсний сагсыг сонгон авсан. Гуравдугаарт, хүнсний сагсыг илчлэгийн хэмжээгээр тодорхойлохдоо хүнсний бүтээгдэхүүний илчлэгийн үзүүлэлтийг ашиглана. Энэ үзүүлэлтийг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс тогтоодог. Калорийн хэмжээг тооцоолохдоо цөөн хэдэн зүйлийг анхаарах хэрэгтэй. Архи, тамхи нь өрхийн зайлшгүй хэрэглээ биш гэдгийг анхаарах шаардлагатай байдаг. Мөн өрхөөс гадуур хэрэглэсэн хүнсний зүйлийн илчлэгийн хэмжээг тодорхойлоход маш их бэрхшээлтэй байдаг. Дээрх шалтгаанаар архи, тамхины хэрэглээ, өрхөөс гадуур хэрэглэсэн хүнсний хэрэглээг энэхүү тооцоонд хамруулаагүй. Дөрөвдүгээрт, нэг калорийн дундаж үнийг тооцож улмаар хүнсний сагсыг хоногт 2100 ккалори авахаар хуваарилсан.

### ХҮНСНИЙ БУС ЯДУУРЛЫН ШУГАМ

Хүнсний бус ядуурлын шугамыг дээд болон доод гэж хоёр янзаар тооцдог. Хүнсний бус ядуурлын дээд шугамыг хүнсний хэрэглээ нь хүнсний ядуурлын шугамтай ойролцоо байгаа хүн амын нийт хэрэглээнд нь эзлэх хүнсний хувийн жинг тодорхойлж тогтооно. Хүнсний ядуурлын шугамаас нэмэх, хасах нэг хувийн хооронд хүнсний хэрэглээтэй өрхийн хүнсний хувийн жинг тооцно. Үүнийг нэмэх, хасах хоёр хувь, гурван хувь гэх мэтээр арван хувь хүртэл давтан үйлдэнэ. Эдгээр арван хувийн жинг дундажлан нийт зардалд эзлэх хүнсний хувийн жинг эцэслэн тооцно. Энэ хувийн жинг үндэслэн хүнсний бус хэрэглээний хувийн жинг тодорхойлж, нийт ядуурлын шугамыг тооцно. Доод ядуурлын шугамын арга зүй дээд ядуурлын шугам тооцохтой төстэй боловч нэг ялгаа нь нийт хэрэглээ нь хүнсний ядуурлын шугамтай тэнцүү хүн амыг жишиг бүлгээр сонгоно. Дунд ядуурлын шугамыг хүнсний ядуурлын шугам дээр дээд болон доод хүнсний бус ядуурлын шугамын дунджийг нэмж тооцно.

## ЯДУУРЛЫН ШУГАМЫГ ШИНЭЧЛЭХ

Ядуурлын шугамыг тодорхой хугацааны дараа оновчтой зөв арга хэрэглэн шинэчлэх нь маш чухал байдаг. Одоогийн бидний ашиглаж буй ядуурлын шугамыг 2010 оны амьжиргааны байдалд үндэслэн тогтоосон. (2010 оны ӨНЭЗС-ны мэдээлэлд үндэслэн тооцсон) Ядуурлын шугамыг зөвхөн судалгаа хоорондох үнийн өөрчлөлтөөр тохируулга хийн шинэчилж байна. Манай улсын хувьд хүнсний болон хүнсний бус ядуурлын шугамыг хүнсний болон хүнсний бус бүлгийн хэрэглээний үнийн индекс ашиглан шинэчлэн тогтоож байна. 2018 оны ядуурлын шугамыг Хүснэгт Б.2-т харуулав. Ядуурлын тооцоо болон тайланд дунд ядуурлын шугамыг ашигласан хэдий ч дээд болон доод ядуурлын шугамыг ашигласан тооцооллыг Хавсралт В-д үзүүлэв.

### Хүснэгт Б.2

Нэг хүнд сард ногдох ядуурлын шугам, 2018

	Доод ядуурлын шугам		Дунд ядуурлын шугам		Дээд ядуурлын шугам	
	Төгрөг	%	Төгрөг	%	Төгрөг	%
Хүнсний	84 993	67	84 993	51	84 993	39
Хүнсний бус	42 731	33	81 587	49	133 621	61
Нийт	127 724	100	166 580	100	218 614	100

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Б.6 ЯДУУРЛЫН ХЭМЖҮҮРҮҮД

Ядуурлын хэмжүүрийн талаар олон ном, товхимол байдаг хэдий ч Фостер, Грээр, Торбек нарын 1984 онд боловсруулсан ядуурлын хэмжүүрийг түлхүү ашигладаг. Үүнийг дараах нэгдсэн томъёогоор тооцдог.

$$P_{\alpha} = (1/n) \sum_{i=1}^q \left( \frac{z - y_i}{z} \right)^{\alpha}$$

Энд:

$\alpha$ - сөрөг бус параметр,

$z$  – ядуурлын шугам,

$y$  – хэрэглээ,

$i$  - хувь хүн,

$n$  – ерөнхий олонлогт байгаа нийт хүн амын тоо,

$q$ - ядуурлын шугамаас доош хэрэглээтэй хүний тоо

Ядуурлын хамралтын хүрээний индекс ( $\alpha=0$ ) нь нийт хүн амд эзлэх ядуу хүн амын хувь бөгөөд энэ нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг үзүүлнэ. Энэ нь ядуурлыг хэмжих хамгийн энгийн бөгөөд тайлбарлахад амархан үзүүлэлт учраас хамгийн өргөн хэрэглэгддэг хэмжүүр юм. Гэсэн ч үүнд зарим дутагдалтай тал бий. Уг үзүүлэлт нь ядуу хүмүүсийн хэрэглээний түвшин ядуурлын шугамаас хэр зэрэг хол байгаа болон ядуу хүн амын дунд хэрэглээний тархалт ямар байгааг үзүүлж чаддаггүй. Ядуурлын гүнзгийрэлтийн индекс нь ( $\alpha=1$ ) ядуурлын шугамаас хүн амын хэрэглээ хэр зэрэг доогуур байгааг илэрхийлнэ. Хэрэглээний хомсдол их байх тусам гүнзгийрэлт өндөр байна. Ядуурлын мэдрэмжийн индекс ( $\alpha=2$ ) нь ядуу хүн амын дундах хэрэглээний тархалтын мэдрэмжийг илэрхийлэх бөгөөд ядуу хүн амын дундах хэрэглээний өөрчлөлт нь ядуурлын хамралтын хүрээ, ядуурлын гүнзгийрэлтийг өөрчлөхгүй, харин мэдрэмжийг өөрчилнө.



## ХАВСРАЛТ В. ДООД, ДЭЭД ЯДУУРЛЫН ТООЦООНУУД

### Хүснэгт В.1.

Нэг хүнд сард ногдох ядуурлын шугам, 2016, 2018 он

	2016		2018	
	Төгрөг	(%)	Төгрөг	(%)
<b>Доод</b>				
Хүнсний	75 034	67	84 993	67
Хүнсний бус	37 244	33	42 731	33
Нийт	112 278	100	127 724	100
<b>Дунд</b>				
Хүнсний	75 034	51	84 993	51
Хүнсний бус	71 111	49	81 587	49
Нийт	146 145	100	166 580	100
<b>Дээд</b>				
Хүнсний	75 034	39	84 993	39
Хүнсний бус	116 463	61	133 621	61
Нийт	191 497	100	218 614	100

Тайлбар: Ядуурлын шугамыг 2010 онд суурилан үнийн индекс ашиглан тооцов.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2016, 2018

### Хүснэгт В.2.

Доод ядуурлын тооцоонууд, 2016, 2018 он

	2016				2018			
	Ядуурлын			Ядуу хүн ам (%)	Ядуурлын			Ядуу хүн ам (%)
	Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт	Мэдрэмж		Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт	Мэдрэмж	
Улсын дундаж	15.2	3.4	1.1	100.0	13.9	3.0	1.0	100.0
<b>Хот, хөдөө</b>								
Хот	14.0	3.2	1.1	62.2	13.9	3.2	1.1	66.1
Хөдөө	17.9	3.6	1.1	37.8	14.0	2.6	0.8	33.9
<b>Суурьшил</b>								
Улаанбаатар	12.3	2.8	1.0	36.5	12.9	3.0	1.0	42.6
Аймгийн төв	17.3	4.0	1.3	25.7	15.9	3.8	1.3	23.5
Сумын төв	17.5	3.6	1.1	20.1	13.4	2.7	0.8	17.5
Хөдөө нутаг	18.4	3.6	1.1	17.7	14.6	2.6	0.7	16.4
<b>Бүс</b>								
Баруун	20.3	4.3	1.4	18.1	15.3	3.2	1.0	14.4
Хангай	16.8	3.3	1.0	20.3	14.1	2.7	0.8	18.5
Төв	13.1	3.1	1.1	13.4	12.6	2.8	0.9	14.3
Зүүн	24.7	5.5	1.8	11.7	20.3	4.3	1.4	10.2

Эх үүсвэр: ӨНЭЗС 2016, 2018



**Хүснэгт В.3.** Дээд ядуурлын тооцоонууд, 2016, 2018 он

	2016				2018			
	Ядуурлын			Ядуу хүн ам (%)	Ядуурлын			Ядуу хүн ам (%)
	Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт	Мэдрэмж		Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт	Мэдрэмж	
Улсын дундаж	48.5	15.3	6.5	100.0	46.5	14.4	6.1	100.0
Хот, хөдөө								
Хот	45.1	14.1	6.1	63.1	43.8	13.9	6.1	62.6
Хөдөө	55.6	17.6	7.4	36.9	51.6	15.4	6.2	37.4
Суурьшил								
Улаанбаатар	42.2	12.9	5.5	39.4	41.8	13.2	5.7	41.3
Аймгийн төв	50.9	16.6	7.3	23.7	48.3	15.7	6.9	21.3
Сумын төв	51.6	16.5	7.1	18.6	49.5	14.8	6.0	19.3
Хөдөө нутаг	60.5	18.9	7.8	18.3	54.1	16.2	6.4	18.1
Бүс								
Баруун	58.6	18.8	8.1	16.4	53.4	16.3	6.7	15.1
Хангай	54.4	16.9	7.0	20.7	51.8	15.6	6.3	20.4
Төв	44.0	13.7	5.9	14.1	44.0	13.4	5.6	14.9
Зүүн	63.5	22.3	10.1	9.4	55.3	18.8	8.3	8.3

Эх үүсвэр: ӨНЭЗС 2016, 2018

## ХАВСРАЛТ Г. СТАТИСТИК НЭМЭЛТ ҮР ДҮНГҮҮД

### Хүснэгт Г.1.

Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2018

Ядуурлын шугамыг хувилсанаар	Ядуурлын		
	Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт	Мэдрэмж
150%	55.7	19.0	8.6
140%	51.0	16.6	7.3
130%	46.0	14.1	6.0
120%	40.2	11.7	4.7
110%	34.6	9.4	3.6
100%	28.4	7.2	2.7
90%	21.8	5.2	1.8
80%	15.6	3.5	1.2
70%	10.4	2.1	0.7
60%	6.0	1.1	0.3
50%	2.9	0.5	0.1

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

### Хүснэгт Г.2.

Ядууралд өртөх эмзэг байдал

	2010	2012	2014	2016	2018
Ядуурлын шугамнаас доогуур хэрэглээтэй хүн амын хувь					
Улсын дундаж	38.8	27.4	21.6	29.6	28.4
Хот	33.2	23.3	18.8	27.1	27.2
Хөдөө	49.0	35.4	26.4	34.9	30.8
Ядуурлын шугамыг 25 хувиар нэмэгдүүлснээс доогуур хэрэглээтэй хүн амын хувь					
Улсын дундаж	54.2	41.5	35.7	45.1	43.3
Хот	48.9	36.1	31.3	41.9	40.8
Хөдөө	63.7	52.0	43.3	52.0	48.2

Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2018

**Хүснэгт Г.3.** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр

	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаан- баатар
Ядуурлын хамралтын хүрээ	28.4 (0.7)	31.8 (1.3)	30.8 (1.2)	26.1 (1.3)	37.4 (1.8)	25.9 (1.2)
Ядуурлын гүнзгийрэлт	7.2 (0.2)	7.8 (0.4)	7.3 (0.4)	6.6 (0.4)	10.0 (0.6)	6.7 (0.4)
Ядуурлын мэдрэмж	2.7 (0.1)	2.8 (0.2)	2.5 (0.2)	2.4 (0.2)	3.7 (0.3)	2.6 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	100.0	13.2	18.3	15.8	6.9	45.8
Хүн амын тоо (мян.хүн)	3 186.4	407.2	600.4	511.5	222.6	1 444.7
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	14.7	19.9	14.5	9.2	41.8
Ядуу хүн амын тоо (мян.хүн)	904.9	133.2	179.6	131.0	82.8	378.2
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.6	3.9	3.3	3.3	3.3	3.8
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	25.3	26.7	22.8	24.1	24.8	26.6
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	46.6	46.6	47.2	46.2	46.7	46.4
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	75.5	82.6	77.7	74.8	73.9	73.0
Хотжилт (%)	66.3	32.4	40.6	38.8	38.7	100.0

Тайлбар: Нийт хүн амын тоо нь засаг захиргааны мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд 2018 оны Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо юм. Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЗЗС 2018

**Хүснэгт Г.4.** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар

	Улсын дундаж	Хот			Хөдөө		
		Нийт	Улаан- баатар	Аймгийн төв	Нийт	Сумын төв	Хөдөө нутаг
Ядуурлын хамралтын хүрээ	28.4 (0.7)	27.2 (0.9)	25.9 (1.2)	30.1 (1.2)	30.8 (0.8)	28.9 (1.0)	32.9 (1.3)
Ядуурлын гүнзгийрэлт	7.2 (0.2)	7.2 (0.3)	6.7 (0.4)	8.2 (0.4)	7.2 (0.2)	7.0 (0.3)	7.4 (0.4)
Ядуурлын мэдрэмж	2.7 (0.1)	2.8 (0.2)	2.6 (0.2)	3.2 (0.2)	2.4 (0.1)	2.4 (0.1)	2.4 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувийн жин (%)	100.0	66.3	45.8	20.5	33.7	18.1	15.6
Хүн амын тоо (мян.хүн)	3 186.4	2 147.4	1 444.7	702.7	1 039.0	558.0	481.0
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	63.5	41.8	21.7	36.5	18.4	18.1
Ядуу хүн амын тоо (мян.хүн)	904.9	574.6	378.2	196.4	330.3	166.5	163.8
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.6	3.7	3.8	3.5	3.4	3.3	3.5
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	26.5	27.4	27.7	26.7	24.8	25.1	24.4
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	46.6	46.5	46.4	46.8	46.6	47.6	45.5
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	75.5	72.9	73.0	72.5	80.2	76.2	85.0

Тайлбар: Нийт хүн амын тоо нь засаг захиргааны мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд 2018 оны Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо юм. Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЗЗС 2018

## Хүснэгт Г.5.

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, 2018 он

	Ядуурлын хамралтын хүрээ		Ядуурлын гүнзгийрэлт		Ядуурлын мэдрэмж	
	Тооцоолол	Стандарт алдаа	Тооцоолол	Стандарт алдаа	Тооцоолол	Стандарт алдаа
Улсын дундаж	28.4	0.7	7.2	0.2	2.7	0.1
Баруун бүс	31.8	1.3	7.8	0.4	2.8	0.2
Баян-Өлгий	24.3	2.2	5.2	0.6	1.8	0.3
Говь-Алтай	45.1	3.3	13.4	1.3	5.1	0.6
Завхан	25.7	2.5	5.0	0.8	1.8	0.4
Увс	29.6	2.5	7.2	0.8	2.5	0.3
Ховд	40.9	3.0	10.9	1.1	4.1	0.5
Хангайн бүс	30.8	1.2	7.3	0.4	2.5	0.2
Архангай	38.2	2.3	9.9	0.9	3.5	0.4
Баянхонгор	29.6	2.3	4.3	0.5	1.1	0.2
Булган	36.8	3.1	11.3	1.2	4.4	0.6
Орхон	25.1	3.2	6.5	1.0	2.5	0.5
Өвөрхангай	34.1	2.4	7.6	0.7	2.4	0.3
Хөвсгөл	25.3	2.8	6.1	0.8	2.1	0.3
Төвийн бүс	26.1	1.3	6.6	0.4	2.4	0.2
Говьсүмбэр	51.9	4.8	12.2	1.9	4.2	1.0
Дархан-Уул	32.8	4.0	9.6	1.7	4.1	0.9
Дорноговь	23.4	2.5	5.2	0.7	1.7	0.3
Дундговь	21.7	2.5	6.3	0.8	2.5	0.4
Өмнөговь	11.8	2.0	2.2	0.4	0.7	0.2
Сэлэнгэ	34.0	2.5	7.9	0.8	2.7	0.4
Төв	20.5	2.2	5.4	0.6	2.0	0.3
Зүүн бүс	37.4	1.8	10.0	0.6	3.7	0.3
Дорнод	42.5	3.1	12.0	1.2	4.6	0.6
Сүхбаатар	30.2	2.5	6.6	0.8	2.4	0.4
Хэнтий	38.0	3.1	10.8	1.1	4.0	0.5
Улаанбаатар	25.9	1.2	6.7	0.4	2.6	0.2

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Хүснэгт Г.6. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2016, 2018 он

	2016 он				2018 он					
	Хамралтын хүрээ	Ядуурлын Гүнзгийрэлт	Мэдрэмж	Хүн амын хувийн жин (%)	Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	Хамралтын хүрээ	Ядуурлын Гүнзгийрэлт	Мэдрэмж	Хүн амын хувийн жин (%)	Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)
Улсын дундаж	29.6	7.7	2.9	100.0	100.0	28.4	7.2	2.7	100.0	100.0
Хот, хөдөө										
Хот	27.1	7.2	2.8	67.8	62.1	27.2	7.2	2.8	66.3	63.5
Хөдөө	34.9	8.8	3.2	32.2	37.9	30.8	7.2	2.4	33.7	36.5
Суурьшил										
Улаанбаатар	24.8	6.4	2.5	45.2	37.8	25.9	6.7	2.6	45.8	41.8
Аймгийн төв	31.8	8.8	3.4	22.6	24.3	30.1	8.2	3.2	20.5	21.7
Сумын төв	32.3	8.5	3.2	17.5	19.1	28.9	7.0	2.4	18.1	18.4
Хөдөө нутаг	38.0	9.2	3.2	14.6	18.8	32.9	7.4	2.4	15.6	18.1
Бүс										
Баруун	36.0	9.7	3.7	13.6	16.5	31.8	7.8	2.8	13.2	14.7
Хангай	33.6	8.2	2.9	18.4	20.9	30.8	7.3	2.5	18.3	19.8
Төв	26.8	7.0	2.7	15.5	14.1	26.1	6.6	2.4	15.8	14.5
Зүүн	43.9	12.5	4.8	7.2	10.7	37.4	10.0	3.7	6.9	9.2

Эх үүсвэр: ӨНЭЭС 2016, 2018

**Хүснэгт Г.7.** Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ, 2016, 2018 он

	Тейлийн индекс		Жини коэффициент		GE(2)		Нэг хүнд сард ногдох дундаж хэрэглээ		
	2016	2018	2016	2018	2016	2018	2016	2018	Өсөлт
Улсын дундаж	0.19	0.19	0.32	0.33	0.28	0.28	269 328	279 912	3.9
Хот, хөдөө									
Хот	0.20	0.21	0.33	0.34	0.30	0.30	283 934	294 377	3.7
Хөдөө	0.15	0.15	0.30	0.29	0.21	0.21	238 520	251 438	5.4
Суурьшил									
Улаанбаатар	0.21	0.21	0.34	0.34	0.32	0.32	298 437	306 373	2.7
Аймгийн төв	0.17	0.18	0.31	0.32	0.23	0.25	254 967	267 551	4.9
Сумын төв	0.16	0.15	0.30	0.30	0.20	0.21	249 889	257 564	3.1
Хөдөө нутаг	0.15	0.15	0.28	0.29	0.22	0.21	224 914	244 330	8.6
Бүс									
Баруун	0.14	0.15	0.28	0.29	0.18	0.20	226 325	245 355	8.4
Хангай	0.15	0.16	0.30	0.30	0.20	0.23	243 769	251 806	3.3
Төв	0.18	0.17	0.32	0.31	0.24	0.23	279 637	278 150	-0.5
Зүүн	0.15	0.19	0.29	0.33	0.23	0.27	211 121	248 860	17.9

Тайлбар: Хоёр үеийн ядуурлын шугамын харьцаан дээр үндэслэн 2016 оныг 2018 оны үнээр илэрхийлэв. GE(a) индексээр тэгш бус байдлын хэмжүүрүүдийн Ерөнхий Энтропи ангийг тэмдэглэсэн бөгөөд а-ийн утга их (бага) байх тусам тархалтын дүнд хэсэгт хэрэглээний ялгавраас бүр их хамааралтай болдог.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2016, 2018

**Хүснэгт Г.8.** Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ, аймаг, нийслэлээр, 2018 он

	Тейлийн индекс	Жини коэффициент	GE(2)	Нэг хүнд сард ногдох дундаж хэрэглээ
Улсын дундаж	0.19	0.33	0.28	279 912
Баруун бүс	0.15	0.29	0.20	245 355
Баян-Өлгий	0.15	0.30	0.20	284 004
Говь-Алтай	0.16	0.29	0.23	200 508
Завхан	0.11	0.25	0.13	257 491
Увс	0.14	0.28	0.19	238 951
Ховд	0.14	0.28	0.19	214 673
Хангайн бүс	0.16	0.30	0.23	251 806
Архангай	0.13	0.28	0.16	217 024
Баянхонгор	0.16	0.28	0.28	256 438
Булган	0.12	0.27	0.13	211 286
Орхон	0.21	0.34	0.33	299 278
Өвөрхангай	0.13	0.28	0.16	236 884
Хөвсгөл	0.13	0.28	0.14	266 439
Төвийн бүс	0.17	0.31	0.23	278 150
Говьсүмбэр	0.09	0.23	0.11	182 132
Дархан-Уул	0.16	0.31	0.18	249 623
Дорноговь	0.15	0.29	0.18	284 353
Дундговь	0.17	0.31	0.21	302 939
Өмнөговь	0.13	0.27	0.16	310 862
Сэлэнгэ	0.14	0.29	0.17	240 174
Төв	0.20	0.33	0.32	322 332
Зүүн бүс	0.19	0.33	0.27	248 860
Дорнод	0.16	0.30	0.22	217 771
Сүхбаатар	0.18	0.33	0.23	289 887
Хэнтий	0.20	0.33	0.32	247 310
Улаанбаатар	0.21	0.34	0.32	306 373

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Хүснэгт Г.9.

Ядуурлын өөрчлөлтийг хэрэглээний өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь, 2016, 2018 оны зөрүүгээр, пунктээр

	Ядуурлын		
	Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт	Мэдрэмж
<b>Улсын дундаж</b>			
Ядуурлын өөрчлөлт	-1.2	-0.6	-0.2
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-2.5	-0.8	-0.4
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	1.3	0.3	0.1
<b>Хот</b>			
Ядуурлын өөрчлөлт	0.1	-0.1	0.0
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-2.1	-0.7	-0.3
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	2.1	0.7	0.3
<b>Хөдөө</b>			
Ядуурлын өөрчлөлт	-4.1	-1.6	-0.8
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-4.2	-1.3	-0.5
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	0.1	-0.3	-0.2
<b>Улаанбаатар</b>			
Ядуурлын өөрчлөлт	1.1	0.3	0.1
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-1.2	-0.5	-0.2
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	2.3	0.8	0.4
<b>Аймгийн төв</b>			
Ядуурлын өөрчлөлт	-1.7	-0.6	-0.2
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-3.1	-1.1	-0.5
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	1.4	0.5	0.3
<b>Сумын төв</b>			
Ядуурлын өөрчлөлт	-3.4	-1.5	-0.7
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-2.2	-0.7	-0.3
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-1.2	-0.8	-0.4
<b>Хөдөө нутаг</b>			
Ядуурлын өөрчлөлт	-5.1	-1.8	-0.8
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-7.1	-2.2	-0.9
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	2.0	0.4	0.1
<b>Баруун</b>			
Ядуурлын өөрчлөлт	-4.3	-1.9	-0.9
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-6.3	-2.0	-0.9
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	2.1	0.1	0.0
<b>Хангай</b>			
Ядуурлын өөрчлөлт	-2.7	-0.9	-0.4
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-3.0	-0.8	-0.3
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	0.2	-0.1	-0.1
<b>Төв</b>			
Ядуурлын өөрчлөлт	-0.7	-0.3	-0.2
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	0.3	0.1	0.0
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	-1.0	-0.5	-0.3
<b>Зүүн</b>			
Ядуурлын өөрчлөлт	-6.6	-2.5	-1.0
Хэрэглээний өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг	-10.6	-4.9	-2.3
Тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг	4.1	2.4	1.3

Эх үүсвэр: ӨНЗЗС 2016, 2018

**Хүснэгт Г.10.** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улирлаар

	Улсын дундаж	I улирал	II улирал	III улирал	IV улирал
		(2018 оны 1-3 сар)	(2018 оны 4-6 сар)	(2018 оны 7-9 сар)	(2018 оны 10-12 сар)
Ядуурлын хамралтын хүрээ	28.4 (0.7)	28.6 (1.3)	29.7 (1.3)	27.1 (1.4)	28.1 (1.3)
Ядуурлын гүнзгийрэлт	7.2 (0.2)	7.5 (0.5)	7.5 (0.5)	6.8 (0.5)	6.9 (0.4)
Ядуурлын мэдрэмж	2.7 (0.1)	2.9 (0.2)	2.8 (0.2)	2.5 (0.2)	2.5 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Хүн амын хувийн жин (%)	100.0	25.2	25.1	24.7	25.0
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	25.4	26.3	23.5	24.8
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.6	3.6	3.6	3.5	3.6
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	26.5	26.5	26.5	26.1	26.7
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	46.6	46.3	46.5	46.9	46.5
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	75.5	75.1	75.2	75.1	76.4

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЗЗС 2018

**Хүснэгт Г.11.** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн ам бүлийн тоогоор

	Улсын дундаж	Өрхийн ам бүлийн тоо							
		1	2	3	4	5	6	7	8-аас дээш
Ядуурлын хамралтын хүрээ	28.4 (0.7)	2.0 (0.4)	6.7 (0.6)	13.7 (0.7)	23.2 (0.9)	33.7 (1.2)	45.9 (1.8)	55.0 (2.8)	68.9 (3.3)
Ядуурлын гүнзгийрэлт	7.2 (0.2)	0.3 (0.1)	1.2 (0.2)	2.6 (0.2)	5.1 (0.2)	7.9 (0.4)	11.8 (0.6)	16.7 (1.2)	24.7 (1.7)
Ядуурлын мэдрэмж	2.7 (0.1)	0.1 (0.0)	0.4 (0.1)	0.7 (0.1)	1.7 (0.1)	2.7 (0.2)	4.4 (0.3)	7.1 (0.7)	11.5 (1.0)
Нэмэлт үзүүлэлтүүд:									
Хүн амын хувийн жин (%)	100.0	3.6	9.5	16.3	25.6	21.8	13.2	5.6	4.4
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	0.3	2.2	7.8	20.9	25.9	21.3	10.9	10.7
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	26.5	0.0	6.1	21.5	36.0	42.0	43.9	41.9	39.6
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	46.6	53.8	54.7	45.1	41.3	42.3	44.0	46.5	50.7
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	75.5	46.4	66.1	75.4	85.1	87.8	87.6	81.7	77.8

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЗЗС 2018



**Хүснэгт Г.12.** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар

	Улсын дундаж	<30	30 - 39	40 - 49	50 - 59	>=60
Ядуурлын хамралтын хүрээ	28.4 (0.7)	25.7 (1.4)	33.9 (1.1)	28.5 (1.1)	27.2 (1.3)	20.1 (1.3)
Ядуурлын гүнзгийрэлт	7.2 (0.2)	5.4 (0.4)	8.5 (0.4)	7.7 (0.4)	7.0 (0.5)	4.8 (0.4)
Ядуурлын мэдрэмж	2.7 (0.1)	1.8 (0.2)	3.1 (0.2)	3.0 (0.2)	2.7 (0.2)	1.8 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	100.0	10.0	29.0	27.7	19.7	13.6
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	9.1	34.6	27.8	18.9	9.6
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.6	3.2	4.2	4.1	3.3	2.6
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	26.5	33.0	45.0	27.0	11.6	7.8
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	46.6	26.1	34.5	44.3	54.4	68.8
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	75.5	84.9	85.5	80.6	69.6	56.5

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

**Хүснэгт Г.13.** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр

	Улсын хэмжээнд		Хот		Хөдөө	
	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй
Ядуурлын хамралтын хүрээ	31.7 (1.4)	27.6 (0.7)	32.4 (1.7)	25.7 (0.9)	29.4 (1.6)	31.0 (0.9)
Ядуурлын гүнзгийрэлт	9.0 (0.5)	6.7 (0.2)	9.5 (0.7)	6.5 (0.3)	7.4 (0.6)	7.2 (0.3)
Ядуурлын мэдрэмж	3.6 (0.3)	2.5 (0.1)	3.9 (0.3)	2.5 (0.2)	2.7 (0.3)	2.4 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	19.3	80.7	22.1	77.9	13.7	86.3
Ядуу хүн амын хувийн жин (%)	21.5	78.5	26.3	73.7	13.1	86.9
Өрхийн ам бүлийн дундаж тоо	2.8	3.8	3.0	3.9	2.3	3.6
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	19.9	27.1	21.3	28.1	16.4	25.3
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	52.9	44.5	51.8	44.6	55.6	44.4
Гэрлэсэн, хамтран амьдардаг (%)	15.3	93.4	16.5	93.9	11.2	92.4
Бэлэвсэн, салсан, тусдаа амьдарч байгаа (%)	72.9	4.1	72.3	4.0	75.0	4.1

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Хүснэгт Г.14.

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшингээр

	Улсын дундаж	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Мэргэжлийн	Дээд
Ядуурлын хамралтын хүрээ	28.4 (0.7)	51.7 (2.3)	41.6 (1.7)	41.1 (1.3)	33.0 (1.2)	26.8 (1.2)	10.1 (0.8)
Ядуурлын гүнзгийрэлт	7.2 (0.2)	14.7 (1.0)	11.0 (0.6)	11.0 (0.5)	8.6 (0.4)	6.4 (0.4)	2.0 (0.2)
Ядуурлын мэдрэмж	2.7 (0.1)	5.8 (0.6)	4.1 (0.3)	4.2 (0.3)	3.3 (0.2)	2.3 (0.2)	0.6 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувийн жин (%)	100.0	3.6	7.5	14.0	25.6	25.2	24.1
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	6.5	11.0	20.3	29.8	23.8	8.6
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.6	3.5	3.3	3.5	3.7	3.7	3.5
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	25.3	26.8	20.3	21.8	26.6	24.2	28.6
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	46.6	47.9	54.5	48.8	44.5	48.1	43.0
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	75.5	71.6	68.5	78.5	75.7	77.4	74.4

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Хүснэгт Г.15.

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажиллах хүчний оролцооны байдлаар

	Улсын дундаж	Ажилтай				Ажилгүй	Ажиллах хүчнээс гадуур
		Нийт	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр	Үйлчилгээ		
Ядуурлын хамралтын хүрээ	28.4 (0.7)	27.0 (0.7)	35.9 (1.2)	30.0 (1.3)	20.9 (0.9)	44.9 (2.6)	29.3 (1.2)
Ядуурлын гүнзгийрэлт	7.2 (0.2)	6.5 (0.2)	8.4 (0.4)	7.7 (0.4)	4.9 (0.3)	13.3 (1.1)	8.1 (0.5)
Ядуурлын мэдрэмж	2.7 (0.1)	2.3 (0.1)	2.8 (0.2)	2.8 (0.2)	1.7 (0.1)	5.7 (0.7)	3.2 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувийн жин (%)	100.0	72.9	17.6	20.4	34.9	4.8	22.3
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	69.4	22.2	21.6	25.6	7.6	23.0
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.6	3.8	3.7	4.0	3.8	3.9	2.9
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	25.3	30.1	26.1	32.8	30.6	24.7	13.2
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	46.6	41.1	43.0	39.4	41.0	44.3	60.9
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	75.5	83.5	90.3	89.5	76.7	83.8	53.7

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Хүснэгт Г.16.

## Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн салбараар

	Улсын дундаж	Ажил эрхэлдэг				Төрийн өмчит үйлдвэр	Ажил эрхлээгүй	Тэтгэмж авагч
		Малчин	Хувийн	Улсын	Улсын			
Ядуурлын хамралтын хүрээ	28.4 (0.7)	33.3 (1.3)	27.5 (1.0)	21.2 (1.3)	14.9 (2.4)	44.9 (2.6)	29.3 (1.2)	
Ядуурлын гүнзгийрэлт	7.2 (0.2)	7.2 (0.4)	7.1 (0.3)	4.2 (0.3)	3.8 (0.9)	13.3 (1.1)	8.1 (0.5)	
Ядуурлын мэдрэмж	2.7 (0.1)	2.3 (0.1)	2.7 (0.2)	1.2 (0.1)	1.4 (0.4)	5.7 (0.7)	3.2 (0.2)	
Нэмэлт үзүүлэлтүүд:								
Хүн амын хувийн жин (%)	100.0	15.1	42.4	12.1	3.3	4.8	22.3	
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	17.7	41.0	9.0	1.7	7.6	23.0	
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.6	3.7	3.8	3.7	3.9	3.9	2.9	
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	25.3	26.0	31.3	30.8	31.8	24.7	13.2	
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	46.6	43.2	40.4	40.8	40.4	44.3	60.9	
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	75.5	90.3	83.1	75.2	87.9	83.8	53.7	

Тайлбар: Тэтгэмж авагч гэдэгт төрөөс ямар нэгэн төрлийн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа бүх өрхийн тэргүүлэгчийг хамрууллаа.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Хүснэгт Г.17.

## Мал аж ахуй эрхлэлт

	Үхэр		Адуу		Тэмээ		Хонь		Ямаа		Бод	
	Малтай өрх (%)	Малын дундаж тоо	Малтай өрх (%)	Малын дундаж тоо	Малтай өрх (%)	Малын дундаж тоо	Малтай өрх (%)	Малын дундаж тоо	Малтай өрх (%)	Малын дундаж тоо	Малтай өрх (%)	Малын дундаж тоо
Улсын дундаж	21.7	5.5	17.6	5.8	2.4	7.1	21.4	38.5	21.8	32.6	26.6	17.8
Хот, хөдөө												
Хот	4.8	4.0	2.6	4.9	0.2	2.8	3.9	24.7	3.9	23.2	6.6	9.1
Хөдөө	55.1	5.7	47.1	6.0	6.9	7.3	55.8	40.4	57.2	33.9	66.1	19.5
Суурьшил												
Улаанбаатар	2.4	4.7	1.0	5.3	0.0	1.3	1.1	24.7	0.9	15.4	3.1	7.6
Аймгийн төв	10.1	3.7	6.1	4.8	0.4	3.1	10.0	24.7	10.6	24.7	14.4	9.8
Сумын төв	37.0	3.7	25.6	4.1	2.3	3.7	33.7	20.0	35.4	18.7	45.5	9.9
Хөдөө нутаг	76.1	6.9	72.0	6.7	12.2	8.1	81.6	50.1	82.4	41.4	89.9	25.2
Бүс												
Баруун	48.7	3.5	41.3	3.2	8.1	3.3	48.6	28.7	51.4	28.1	59.4	12.7
Хангай	40.2	6.6	33.4	5.7	2.2	10.9	42.4	36.0	42.6	30.3	49.5	18.4
Төв	26.1	5.5	20.5	6.6	4.6	12.5	26.3	47.5	27.2	42.7	34.1	21.0
Зүүн	39.3	7.4	33.9	11.2	3.4	2.0	36.8	58.7	37.1	37.2	42.6	28.6
Ядуурлын байдал												
Ядуу бүс	22.2	6.2	17.8	6.9	2.6	8.6	21.4	45.8	21.6	37.4	26.7	21.0
Ядуу	20.5	3.4	17.0	3.0	1.9	1.9	21.2	19.8	22.4	21.0	26.5	9.6

Тайлбар: Малын тоог бодод шилжүүлсэн. Ингэхдээ малыг адуутай адилгаж тооцдог. Нэг бод нь нэг адуу, нэг үхэр, 0.67 тэмээ, 6 хонь буюу 8 ямаатай тэнцүү гэж тооцдог. Сарлагийг үхэрт тооцсон.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Хүснэгт Г.18.

## Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, мал аж ахуй эрхлэлтийн байдлаар

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	Малтай	Малгүй	Малтай	Малгүй	Малтай	Малгүй
Ядуурлын хамралтын хүрээ	28.2	28.5	23.2	27.5	29.2	33.8
	(0.9)	(0.8)	(2.0)	(1.0)	(1.0)	(1.2)
Ядуурлын гүнзгийрэлт	6.1	7.6	5.8	7.3	6.2	9.1
	(0.3)	(0.3)	(0.9)	(0.3)	(0.3)	(0.4)
Ядуурлын мэдрэмж	2.0	2.9	2.3	2.8	1.9	3.4
	(0.1)	(0.1)	(0.6)	(0.2)	(0.1)	(0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	26.6	73.4	6.6	93.4	66.1	33.9
Ядуу хүн амын хувийн жин (%)	26.5	73.5	5.6	94.4	62.8	37.2
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.7	3.5	3.9	3.7	3.6	3.0
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.9	25.4	27.1	26.2	24.5	22.0
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	45.9	46.8	46.3	46.6	45.8	47.9
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	86.1	71.8	84.7	72.1	86.3	70.5

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018

## Хүснэгт Г.19.

## Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, газар эзэмшил, өмчлөлийн байдлаар

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	Газартай	Газаргүй	Газартай	Газаргүй	Газартай	Газаргүй
Ядуурлын хамралтын хүрээ	26.8	29.9	28.1	26.3	24.5	37.3
	(0.8)	(0.9)	(1.1)	(1.2)	(1.0)	(1.2)
